МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

The Nature Conservancy
Protecting nature. Preserving life.™

ЭКОЛОГИЙН БҮС НУТГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол орны өмнийн говийн бүс нутагт
хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь

2013 он

Экологийн бүс нутгийн үнэлгээний тайлан: Монгол орны өмнийн говийн бүс нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь

Зохиогчид:
Майкл Хайнер, Юндэн Баяржаргал, Жосеф Кисикер, Даваа Галбадрах, Нямсүрэн Батсайхан, Ганбаатар Мөнхзул, Ичинхорлоо Одончимэг, Ойдов Энхтуяа, Дончинбуу Энхбат, Хэнрих вон Уехрдэн, Ричард Ридинг, Керк Олсон, Родни Жаксон, Жеффрэй Эванс, Брюс МкКенни, Жэймэс Оаклеаф, Кэй Сочи.

Редакцын зөвлөл:
Н.Батсайхан, Яа.Адъяа, Л.Амгалан, С.Амгаланбаатар, Д.Ариунгэрэл, Д.Даш, Д.Зүмбэрэлмаа, Б.Лхагвасүрэн, Б.Мөнхцог, Б.Оюунгэрэл, Д.Санжмятав, Д.Суран, Х.Тэрбиш, Г.Цогтжаргал, Н.Цэвээнмядаг.

Судалгааны зөвлөхүүд:
Н.Батсайхан, Яа.Адъяа, Х.Тэрбиш, Н.Цэвээнмядаг, Б.Лхагвасүрэн, Д.Суран, Б.Мөнхцог, Д.Зүмбэрэлмаа, Д.Ариунгэрэл, С.Амгаланбаатар, Г.Цогтжаргал, Яад. Адъяа, Петра Каченски, Гана Вингард, Мариа Фернандез-Гименез, Жан Коеинг, Б.Нямбаяр, Томас МкКарти, Харри Роналдс, Томас Мюллер, Петер Леимгрувер.

Англи хэлнээс орчуулсан: Д.Батболд.
Орчуулгын редактор: Д.Галбадрах, Н.Батсайхан.

Талархал: Энэхүү судалгаанд Монгол улсын төрийн захиргааны төв болон аймаг, орон нутгийн захиргааны төлөөлөл, их сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагууд, төрийн бус байгууллагуудын ажилтан, судлаачид хамтран оролцсон бөгөөд эдгээр нийт оролцогчдын хамтын бүтээл юм. Үүнд:

Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ, хуучин нэрээр),
Эрдэс баялаг, эрчим хүчний яам (ЭБЭХЯ, хуучин нэрээр),
Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам (ЗТБХБЯ, хуучин нэрээр),
Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (ҮХШХ, хуучин нэрээр),
Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар (ГХБГЗЗГ, хуучин нэрээр),

Дэ Нэйче Консерванси (TNC),
Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF),
Зэрлэг Амьтдыг Хамгаалах Нийгэмлэг (WCS),
Мерси Корпс,

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академ (ШУА)-ийн Биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лаборатори,
Монгол Улсын ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Шувуу судлалын лаборатори,
Монгол Улсын ШУА-ийн Ботаникийн хүрээлэн,
Монгол Улсын ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн,
Монгол Улсын ШУА-ийн Газарзүйн хүрээлэн,
Монгол улсын их сургуулийн Биологи, Биотехнологийн Сургууль,

Дорноговь аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын Газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,

Өмнөговь аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын Газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,
Дундговь аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын Газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,
Өвөрхангай аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын Газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,
Баянхонгор аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын Газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,
Говь-Алтай аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын Газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,
Ховд аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын Газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар зэрэг болно.

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд санхүүгийн тусламж үзүүлсэн Рио Тинто групп, судалгааны туршид үнэтэй зөвлөмж, санал өгч байсан Судалгааны зөвлөх баг болон тайланг засварласан редакцын зөвлөлд гүн талархал илэрхийлье!

Судалгааны үр дүн болох тайлан, интернэт дээр суурилсан ГМС–ийн өгөгдлүүдийг дараах хаягт байрлуулсан болно:
https://s3.amazonaws.com/DevByDesign-Web/MappingApps/Gobi/demo/gobi.html

Энэхүү үнэлгээний ажлыг Рио Тинто группын тусламжаар гүйцэтгэв.

2013 оны 7 дугаар сар.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ
ХУРААНГУЙ
1.0 УДИРТГАЛ....1
1.1 Судалгааны бүс....1
1.2 Байгаль хамгааллын төлөвлөлт....4
1.3 Урьд хийгдэж байсан бүс нутгийн байгаль хамгааллын төлөвлөлт, тэргүүлэх чиглэлээ тогтоох судалгаанууд....4
1.4 Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь....6
1.5 Судалгааны үр дүнг ашиглах нь....7
2.0 АРГА ЗҮЙ БА ҮР ДҮН....9
2.1 Тойм....9
2.2 Хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын бүрдэл хэсэг....12
2.2.1 Газрын экосистемийн ангилал....14
2.2.2 Хамгаалллын төлөөлөл зүйл....24
2.3 Төлөөлүүлэн хамгаалах зорилт....24
2.4 Нөлөөллийн индекс....27
2.5 Дүн шинжилгээ....31
2.6 Хамгаалах шаардлагатай газрыг сонгох....31
2.7 Биологийн үнэ цэнийн хэмжүүр....32
2.8 Хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтоох....34
2.9 Хамгаалах шаардлагатай бусад газар нутаг....37
2.9.1 Зэрлэг амьтны идэш тэжээл, шилжилт хөдөлгөөний хувьд чухал идээшил нутаг....37
2.9.2 Судлаачдын тодорхойлсон хамгаалах шаардлагатай газар нутаг....38
2.10 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хувилбарууд....41
3.0 ХЭЛЭЛЦҮҮЛЭГ....47
3.1 Судалгааны ажлын үр дүнг байгаль орчныг хамгаалах ба нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд хэрхэн ашиглах нь....47
3.1.1 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний өргөтгөл ба менежмент....47
3.1.2 Уул уурхай, эрчим хүчний хөгжлийн нөлөөллийг бууруулах чиглэл....48
3.1.3 Зээлдүүлэгчийн гүйцэтгэлийн стандарт: Чухал амьдрах орчин....48
3.1.4 Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтоох нь....49
3.1.5 Газар ашиглалтын төлөвлөлт....50
3.1.6 Судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх үндэслэл....50
3.2 Хэрэгжүүлэх шаардлагатай бусад асуудал....51
3.2.1 Хамгаалах шаардлагатай болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн давхцал илэрсэн газар....51
3.2.2 Зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөнд учрах саад бэрхшээл....51
3.2.3 Газрын доорх устай шүтэлцээтэй экосистемийг хамгаалах нь....52
3.2.4 Газрын доорх усны өөрчлөлтийн хүн, мал, зэрлэг амьтанд үзүүлэх нөлөө, түүний мониторинг....53
3.2.5 Хуримтлагдах нөлөөлөл....54
3.2.6 Монгол улсын хэмжээнд хамгаалах шаардлагатай газар нутгийг тодорхойлох нь: Хялганат хээрийн болон өмнийн говийн экологийн бүс нутгийн үнэлгээ....56
3.3 Энэ судалгааны ажлын дутагдалтай тал, түүнийг сайжруулах тухай зөвлөмж....56
3.3.1 Экосистемийн ангилал....57
3.3.2 Зүйлийн тархац нутгийн загвар....57
3.3.3 Нөлөөллийн индекс....59
3.4 Дараагийн алхам....59
3.4.1 Хамгаалах шаардлагатай газар нутгийг дахин нягтлах нь....60
3.4.2 Чадавхийг бэхжүүлэх....60
4.0 ДҮГНЭЛТ....61
НОМ ЗҮЙ....62

ХАВСРАЛТ
Хавсралт 1: Экосистемийн ангилал: экосистемийн хэв шинжийг тодорхойлох нь....69
Хавсралт 2а: Газрын экосистемийн ангилал-Судалгаанд хамрагдсан бүс нутгийн болон хамгаалах шаардлагатай газар нутгийн хэмжээгээр....76
Хавсралт 2б: Зүйлийн амьдрах орчны загвар - Судалгаанд хамрагдсан газар нутгийн бүтэц ба экологийн хувьд чухал ач холбогдолтой буюу хамгаалах шаардлагатай газар нутаг....82
Хавсралт 3: Сонгон авсан зүйлийн амьдрах орчны тархацын зураг....84
Хавсралт 4а: Экосистемийн төрөл тус бүрт үзүүлэх хуримтлагдах нөлөөлөл....122
Хавсралт 4б: Сонгон авсан зүйлийн тархацад үзүүлэх хуримтлагдах нөлөөлөл....123
Хавсралт 5: Судалгааны зөвлөх баг болон ДБХС-гийн Биологийн олон янз байдлын орхигдлын үнэлгээ (Chimed-Ochir et al. 2010)-гээр гаргаж ирсэн газар нутгийн тодорхойлолт....125
Хавсралт 6: Газрын доорх усны нөлөөлөлд зайнаас тандан судлах арга ашиглан мониторинг хийх....127
Хавсралт 7: Зөвлөх багууд болон орон нутгийн оролцогч талууд: Ажлын хэсэг байгуулах тухай сайд нарын тушаалаар баталсан зөвлөх багийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны хуваарь....129

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Экосистемийн ангилал: Ашигласан мэдээ ба аргачлал 19
Хүснэгт 2: Экосистемийн ангилал: Био-газарзүйн мужлалаар..... 20
Хүснэгт 3: Сонгосон зүйлийн жагсаалт болон мэдээллийн эх сурвалж..... 25
Хүснэгт 4. Хүний нөлөөллийн индексийг тооцоолсон байдал: Нөлөөллийн төрлүүд ба ашигласан мэдээ..... 30

ЗУРГИЙН ЖАГСТААЛТ

Зураг 1: Монгол орны газрын эко-бүс нутаг..... 3
Зураг 2: Судалгаанд хамрагдсан бүс нутаг: Монгол орны өмнийн говь..... 3
Зураг 3: Хамгаалах шаардлагатай буюу экологийн хувьд чухал ач холбогдолтой газрыг тогтоох үйл явц..... 5
Зураг 4: Хамгаалбал зохих биологийн олон янз байдлыг сонгох нь:
Орон зайн хэмжээ ба биологийн олон янз байдлын бүрдэл хэсэг..... 14
Зураг 5: Ургамлын бүлгэмдлийн тархац ба ургамлын бүтээмжид үндэслэсэн ургамалшлын ангилал 17
Зураг 6: Хөрсний засалттай ургамалшлын нийлбэр индекс. 17
Зураг 7: Газрын экосистемийн ангилал 21
Зураг 8: Газрын гадаргын хэв шинж 23
Зураг 9: Зүйл болон амьдрах орчны хамаарлын муруй: Амьдрах орчны талбай болон
зүйлийн тоо хэмжээний хоорондын хамаарал 27
Зураг 10: Нөлөөллийн индексийн хүчин зүйлс ба ГМС-н өгөгдөл 29
Зураг 11: Нөлөөллийн индекс..... 29
Зураг 12: Хамгаалах шаардлагатай газар нутгийн эхний хувилбар 32
Зураг 13: Оновчтой байдлын сонголт: Марксан программ ашиглан хамгийн үнэмлэхүй
сонголтоор хамгаалах газрыг тогтоодог 33
Зураг 14: Ховор байдал: Экосистемийн хэв шинжийг хувьд хамгийн ховор тохиолдол
бүхий төлөвлөлтийн нэгжүүд 33
Зураг 15: Хулангийн амьдрах орчны тархацын загвар. 35
Зураг 16: Хамгаалах шаардлагатай газар нутгийн эхний хувилбар болон
ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон газрууд..... 35
Зураг 17: Хамгаалах шаардлагатай газар нутгууд ба ашигт малтмалын
тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай газрууд..... 36
Зураг 18: Хамгаалах шаардлагатай газар нутгууд ба ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй
давхцаж буй зарим газрыг хассан байдал. 36
Зураг 19: Хамгаалах шаардлагатай газар нутгууд, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн
давхцалыг багасгах зорилгоор дахин загварчилсан байдал. 36
Зураг 20: Бэлчээрийн ургамлын бүтээжмийн өөрчлөлт ба идээшил нутаг 38
Зураг 21: Хамгаалах шаардлагатай газар нутаг..... 39
Зураг 22: Хамгаалах шаардлагатай газар нутаг болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл 39
Зураг 23: Тээврийн зурвас дэд бүтцээс зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд учруулах саад тотгор. 40
Зураг 24: Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-ийн гүйцэтгэлийн стандартыг
хэрэгжүүлэх зорилгод нийцүүлсэн амьдрах орчны ангилал 41
Зураг 25: Бүс нутгийн хүрээнд уул уурхайн нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах боломжит хувилбар:
нэг уурхайн жишээн дээр. 43
Зураг 26: Бүс нутгийн хүрээнд уул уурхайн нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах боломжит хувилбар:
нэг аймгийн хүрээнд 44
Зураг 27: Газрын доорх уснаас хамааралтай экосистемийн хэв шинж 45
Зураг 28: Үндэсний хэмжээнд хамгаалах шаардлагатай газар нутаг:
Монгол орны хялганат хээрийн болон өмнийн говийн бүсээр. 55

Фото зургууд
Нүүр хуудас: Joseph Kiesecker;
Joseph Kiesecker: Хуудас 2, 6, 9, 10, 12, 13, 27, 28, 31, 47, 48, 50, 54, 59;
Michael Heiner: Хуудас 1, 4, 6, 7, 8, 11, 13, 15, 16, 18, 24, 26, 34, 37, 49, 51, 52, 53, 56, 57, 58, 60, 61.

ӨМНӨХ ҮГ

Дэлхийн хуурай газрын бараг тэн хагас нь хүний үйл ажиллагааны нөлөөнд өртөж, байгалийн уугуул төрх, хэв шинж өөрчлөгдөж, улмаар байгаль орчны нөхцөл доройтож, биологийн олон янз байдал ядмаг болохын зэрэгцээ ихээр устаж байна. Манай дэлхийн хэмжээнд үйлдвэрлэл ирэх 20 жилд 2 дахин нэмэгдэж, уул уурхай, дэд бүтэц, эрчим хүчний салбарт урьд өмнө байгаагүй их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж, хөгжлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөө тэдий хэмжээгээр эрс нэмэгдэх төлөв ажиглагдаж буй. Монгол улсад энэ тусгалын илрэл гэж хэлж болохуйц эдийн засгийн өсөлтийг бий болгох чиглэлээр эрдэс баялаг болон газрын тос хайх, олборлох үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагааг тэтгэх, хангах дэд бүтцийг барьж байгуулах явцад биологийн олон янз байдал, хүний эрүүл, амгалан амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөө сүүлийн арав гаруйхан жилд илэрхий ажиглагдах болов. Иймд дээр дурьдсан сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах болон арилгах нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны гурамсан тогтолцооны хамгийн чухал шийдвэрлэх асуудал болон тулгараад байна.

Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд болон Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга нарын 2011 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А-358/235/282/120 дугаартай хамтарсан тушаалаар “Монгол орны өмнийн говийн бүс нутагт хэрэгжиж буй хөгжлийн төсөл хөтөлбөрүүдийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь” төслийг дэмжин баталсан болно. Энэ төслийг хэрэгжүүлэх зорилгоор “Экологийн бүс нутгийн үнэлгээ” хийж, нөлөөллийг бууруулах арга зам, үйл ажиллагааны зөвлөмжийг боловсруулахад шинжлэх ухааны судалгаа болон хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, шүүн хэлэлцэж, үр дүнг баталгаажуулах зорилготой ажлын хэсэг байгуулж ажилласны үр дүнд “Экологийн бүс нутгийн үнэлгээ”-ний өргөн цар хүрээтэй ажил амжилттай дуусч, төслийн тайлан товхимол хэлбэрээр Та бүхэнд хүрч буйд талархаж байна.

Монгол орны өмнөд говь цөлийн бүс нутаг нь хэдэн арван зууны туршид бэлчээр сэлгэн нүүдэллэдэг малчдын амьжиргаа, малын идээшил бэлчээр нутаг болохын зэрэгцээ Төв Азийн хуурай гандуу цөлд оршин амьдрах эндемик болон олон ховор, ховордсон зэрлэг амьтан, ургамлын зүйл шүтэн амьдарсаар ирсэн уугуул нутаг орон билээ. Иймд, Монгол орны говь цөлийн бүс нутагт хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөж, хэрэгжүүлэх явцад илрэх нөлөөллийг бууруулах, арилгах, бүс нутгийн төлөөлөл болох экосистемийн хэв шинж, зэрлэг амьтан, ургамлын амьдрах, ургах орчныг хамгаалах, хүн амьдрах эрүүл, амгалан орчныг хангах, тэтгэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлэх асуудал нэн чухлаар тавигдаж байна.

Дэ Нэйче Консерванси (The Nature Conservancy) байгууллага нь хөгжлийн энэхүү өсөн нэмэгдэж буй хэрэгцээг байгаль орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах шаардлагатай уялдуулах, нийцүүлэх чиглэлээр ”Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх арга”-ыг боловсруулан дэлхийн зарим оронд амжилттай туршин хэрэгжүүлсээр байна. “Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх” гэдэг ухагдахуун нь эрдэс баялаг болон газрын тос олборлох үйлдвэрлэл, тэдгээрийг дагасан дэд бүтэц зэрэг эдийн засгийн хөгжлийг биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нийцүүлэн хослуулах зорилгоор шинжлэх ухааны үндэслэл бүхий ландшафтын түвшний төлөвлөлт хийх судалгааны аргыг илэрхийлдэг.

Та бүхэнд хүргэж буй “Монгол орны өмнийн говийн экологийн бүс нутгийн үнэлгээ” тайлан нь Дэ Нэйче Консерванси байгууллагын 2010 онд хийж гүйцэтгэсэн “Монгол орны хээрийн экологийн бүсийн үнэлгээ”-ний үргэлжлэл юм. Эдгээр судалгааны үр дүнд Монгол орны хээр, дагуурын ойт хээр болон өмнөд говь цөлийн бүс нутгийн биологийн олон янз байдлын чухал амьдрах орчин болон экологийн үйл явцыг тэтгэж чадах, зайлшгүй хамгаалах шаардлагатай газар нутгуудийг шинжлэх ухааны сүүлийн үеийн аргад тулгуурлан тогтоогоод байна. Экологийн бүс нутгийн

үнэлгээг Монгол орны баруун болон төвийн бүс нутагт үргэлжлүүлэн хийж эхлээд байна. Үүний үр дүнд, Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд экологийн хувьд чухал ач холбогдолтой газруудыг тодорхойлж, уул уурхай, түүнийг дагасан дэд бүтцийн хөгжлийг байгаль хамгаалах асуудалтай зохистой уялдуулж төлөвлөхөд шаардлагатай үндэсний хэмжээний нэгдсэн мэдээллийн сан бүрдэх юм.

Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудлыг ландшафтын түвшинд хэрэгжүүлэх төдийгүй, уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчид болон шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангахад энэ тайлан чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.
Монгол орныхоо биологийн олон янз байдлыг хамгаалах үйл хэргийг өсөн нэмэгдэж буй хөгжлийн асуудлуудтай уялдуулахад шинжлэх ухааны мэдлэг, арга туршлагаа хуваалцан ажиллаж буй Дэ Нэйче Консерванси байгуулага болон ажлын хэсэгт оролцож, өөрсдийн мэдлэг чадвараа зориулж, үнэт хувь нэмэр оруулсан судлаач, эрдэмтэн, мэргэжилтэн, мэдээллийн туслалцаа үзүүлсэн орон нутгийн удирдлага, иргэд, бусад байгууллагад чин сэтгэлийн талархал илэрхийлье!

С.Оюун



Монгол Улсын Их Хурлын Гишүүн,
Засгийн Газрын Гишүүн,
Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Сайд

ХУРААНГУЙ

Энэ тайлан нь төлөвлөж буй уул уурхай, түүнийг дагалдах дэд бүтцийн хөгжлийн төлөвлөлт, амьдрах орчныг хамгаалах асуудлыг тэнцвэртэй хослуулах, Засгийн газрын хүсэл эрмэлзлийн хүрээнд хийгдсэн Монгол орны өмнийн говийн бүсийн байгаль хамгаалах төлөвлөгөө юм. Судалгааны ажлын хүрээнд бид одоо байгаа мэдээлэл, эрдэм шинжилгээний бүтээл, мэргэжилтнүүдийн зөвлөгөөн дээр тулгуурлан зайлшгүй хамгаалах шаардлагатай буюу экологийн хувьд чухал ач холбогдолтой газруудыг тодорхойлж, амьдрах орчныг хамгаалах, түүнд учирч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах асуудлаар шийдвэр гаргахад дэмжлэг болохуйц мэдээллийн системийг бүрдүүлэв.

1. Бидний судалгаанд хамрагдсан говийн бүс нь Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн өмнөд хэсэгт хамаарах газар нутгийн гуравны нэг (32%) буюу нийт 510,000 км^2 талбайг эзлэнэ. Энэ бүс нутаг нь баруун ба баруун умард хэсгээр Алтай, Хангайн нуруу, зүүн умард этгээдэд Дорнод Монголын тал хээр, өмнөд хэсгээр БНХАУ-тай хиллэдэг. Өмнийн говийн бүс нь зэрлэг амьтан, ургамлыг тэтгэж тэдний амьдрах орчин нь болох дэлхийн дайд хамгийн бага хөндөгдсөн, уудам, байгалийн унаган төрхөө хадгалсан газар нутгуудын нэг юм. Гэвч, уул уурхайн болон үүнтэй холбоотой дэд бүтцийн хурдацтай хөгжил нь зэрлэг амьтан, ургамал, мөн уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн эрхлэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна.
2. Судалгааны хүрээнд өмнийн говийн бүс нутгийн биологийн олон янз байдал ба экологийн үйл явцын төлөөллийг тэтгэж чадах, хамгаалал ба менежментийн зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх тохиолдолд зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөн ба тэдний амьдрах орчиндоо идээшин амьдрах нөхцөлийг хангасан ландшафтын түгээмэл уудам, экологийн хувьд “эрүүл” амьдрах орчныг хамарсан багц газрыг илрүүлсэн юм. Байгаль хамгаалллын чухал ач холбогдолтой эдгээр багц газрыг “хамгаалах шаардлагатай газар нутаг”[1] гэж томъёолсон. Энэ судалгаанд одоо байгаа мэдээлэлд нийцүүлэн, тохирсон арга, аргачлалыг боловсруулан ашиглалаа. Чухал ач холбогдол бүхий биологийн олон янз байдлыг экосистемийн ангилал, бүс нутгийн Улаан данс (IUCN, бүс нутгийн үнэлгээ)-д устаж болзошгүй, ховордож байгаа, эмзэг ба ховордож болзошгүй зэрэг ховордлын зэрэглэлд бүртгэгдсэн шувуу, хөхтөн, мөлхөгчдийн 33 зүйлийн амьдрах орчны тархацын загварыг ашиглан тодорхойлсон болно. Бид хамгаалах шаардлагатай газар нутгуудыг тогтоохын тулд эхлээд экосистем тус бүрийн тархац, тоо хэмжээ төлөөллийг хангах зорилгыг биелүүлэх, удаад нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хуримтлагдах нөлөөлөл буюу нөлөөллийн индекс дээр тулгуурлан, экологийн нөхцөл байдлын хувьд хамгийн зохистой хувилбарыг сонгох шаардлагуудыг харгалзан үзлээ.
3. Хамгаалах шаардлагатай газар нутгуудад дараах газрууд хамаарна. Үүнд: а) Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, б) Шувуудад чухал газрууд, Тост уулын орон нутгийн хамгаалалттай газар гэх мэт бусад байгаль хамгаалллын чухал ач холбогдолтой газрууд, в) Экосистемийн төлөөлөл, экологийн нөхцөл байдлыг хамгийн зохистой хувилбараар сонгох зорилгоор байгаль хамгаалллын төлөвлөлт хийхэд хэрэглэдэг “MARXAH” программыг ашиглан сонгосон газар нутгууд тус тус хамаарна. Хамгаалах шаардлагатай газар нутгуудад судалгааны талбайн 37 хувийг эзлэх, нийт 195,000 км^2 дэвсгэр нутагтай 50 нэгж газар хамрагдаж байна. Хамгаалах шаардлагатай нийт газар нутгийн 57 хувь нь улсын тусгай хамгаалалттай газрын одоогийн сүлжээнд хамрагддаг. Судалгаанд хамрагдсан газар нутгийн хүрээнд төлөвлөлтийн нэгж газар тус бүрийн хамгаалллын ач холбогдлын үнэ цэнийг тогтоохын тулд “MARXAH” программын зохистой сонголтын хувилбар болон ховор байдлыг харгалзан экосистемийн илрэцийн хамгаалллын харьцангуй ач холбогдлын индексийг боловсруулав.

1 Хамгаалах шаардлагатай газар нутгийг мөн экологийн чухал ач холбогдолтой газар гэж үзэж болно.

4. Уул уурхайн олборлолт, хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай болон хамгаалах шаардлагатай газар нутгуудын хооронд давхцал үүсч болох талбайг зураглав. Давхцал бүхий газар нутгууд, хамгааллын үнэ цэн хамгийн их буюу 30 хувь хүртэл утгатай газрууд мөн хулангийн тархац нутгийн хүрээнд багтах хамгийн чухал идээшил орчин бүхий газар нутагт хөгжлийн төсөл хэрэгжүүлэхээс зайлхийх шаардлагатай гэж үзлээ. Бусад давхцал бүхий газрыг хамгаалах шаардлагатай газар нутгийн бүрэлдхүүнээс хасч, одоогоор тусгай зөвшөөрөл олгогдоогүй бөгөөд экологийн хувьд бүтэц, нөхцлийн хувьд ижил төстэй газруудыг илрүүлж, орлуулан солилоо. Зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөнд саад учруулж болох, тэдэнд шууд аюул хөнөөл болохуйц, одоогийн ашиглаж байгаа болон төлөвлөж буй зам тээврийн дэд бүтцийн нийт зургаан зурвас газрыг зураглав.
5. Уул уурхай, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, олборлолт зэрэг хөгжлийн төслөөс улбаатай нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах зорилгод бидний судалгаагаар тогтоосон хамгаалах шаардлагатай газар нутгийг хэрхэн ашиглаж болохыг жишээгээр дүрслэн үзүүлэв. Мөн хамгаалах шаардлагатай газар нутгийн гадна хэрэгжих хөгжлийн төслүүдийн болзошгүй нөлөөллийг хэрхэн тодорхойлох, дүйцүүлэн хамгаалж болох газруудыг хэрхэн тогтоох тухай жишээгээр тайлбарлав.

Энэхүү тайланг хэрхэн ашиглах вэ?

Хөгжлийн нөлөөллийг бууруулах уламжлалт арга нь хэд хэдэн дутагдалтай. Ихэнх улс орнууд төслийн нөлөөллийг зөвхөн тухайн төслийн хувьд авч үзэх, эсвэл зөвхөн нөлөөлөлд өртсөн газар нутгийн хэмжээнд нь нөлөөллийг үнэлэх буюу тэр орчимд нь бууруулах хэлбэрээр хэрэгжүүлж байна. Эдгээр уламжлалт арга нь амьдрах орчин хоорондын холбоо, зүйлийн үргэлжилсэн тархац нутаг тасралтгүй жижиглэн хуваагдсаар “арал” маягийн жижиг тасархай амьдрах орчин болж хуваагдахаас сэргийлэх, экологийн бүрэн үүрэг, үйл ажиллагааг хэвийн гүйцэтгэж чадахуйц ландшафтыг хамгаалах асуудлыг нөлөөллийг бууруулах зорилго болгон авч үздэггүй эсвэл тун бага анхаардаг зэрэг сул талтай.

Нөлөөллийг бууруулах уламжлалт аргын хувьд ирээдүйд тохиолдох бэрхшээлийг урьдчилан дэвшүүлэх боломж хомс юм. Ихэнх тохиолдолд тухайн газар нутагт үзүүлэх хуримтлагдах нөлөөлөл болон бусад уул уурхай, дэд бүтцийг барьж байгуулах үед үүсэх нөлөөллийг хамтад нь тооцох асуудлыг орхигдуулж байна.

Энэ судалгааны ажлын үндсэн зорилго нь өнөөдөр байгаль орчинд оруулж байгаа хөрөнгө оруулалт удаан хугацааны турш тогтвортой үр ашгаа өгч байх талаар шаардлагатай санал, бодлого дэвшүүлэхэд оршино. Энэ дүн шинжилгээ нь хөгжлийн төсөл хөтөлбөр болон уур амьсгалын өөрчлөлт (өсөн нэмэгдэж байгаа тоосжилт, цөлжилт, газрын доорх усны хомсдол, нийгмийн асуудал)-ийн ирээдүйд үзүүлэх нөлөөллөөс шалтгаалан Монгол орны говь, цөл нутагт нүүрлэж байгаа байгаль орчны бүх асуудлуудыг бүхэлд нь шүүн хэлэлцээгүй билээ. Эдгээр асуудлуудын заримыг нь нарийн хэмжүүрээр шүүж, тухайлбал тодорхой нэг төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх үед дэвшүүлэн шийдвэрлэх шаардлагатай. Харин, бидний энэ дүн шинжилгээ нь тодорхой нэг хөгжлийн төсөл, түүнээс байгаль орчинд оруулж байгаа хөрөнгө оруулалт нь байгаль хамгаалах илүү өргөн хүрээ бүхий бүс нутгийн зорилготой хэрхэн уялдаж, нэмэр болох талаар зөвлөмж өгөх юм. Энэ судалгааны ажлын үр дүнг хэрхэн ашиглаж болохыг дор жагсаалтаар харуулав:

- Монгол орны газар нутгийн 30 хувийг тусгай хамгаалалтад авах талаарх Монгол улсын Засгийн газрын өмнөө тавьсан зорилтыг биелүүлэх зорилгоор тусгай хамгаалалтад зарим газрыг авах үндэслэл боловсруулахад зөвлөмж болох (2.8 болон 3.1.1 хэсгүүдийг үзнэ үү).
- Өнгөрсөн, одоо, ирээдүйд хүний үйл ажиллагаанаас (тухайлбал хуримтлагдах нөлөөлөл гэх мэт) байгаль орчинд өөрчлөлт орох эсэх асуудлыг авч үзэхэд үндсэн суурь мэдлэг болох (Хавсралт 4-ийг үзнэ үү).
- Хөгжлийн төслийг биологийн олон янз байдлын хамгаалалд шаардлагатай газар, усан орчноос өөр газарт хэрэгжүүлэх байдлаар төлөвлөх замаар хөгжил – байгаль орчны зөрчилдөөнийг бууруулах, улмаар байгаль хамгаалах арга хэмжээг хөгжлийн сөрөг нөлөөлөлд их өртөхөөргүй

газар нутаг руу чиглүүлэх.

- Маш чухал, хэвийн, мөн нөлөөлөлд өртсөн зэрэг ялгаатай амьдрах орчныг тодорхойлох ландшафтын түвшний төлөвлөлт хийх, Олон улсын санхүүгийн корпорацийн гүйцэтгэлийн стандарт 6 (IFC Performance Stand 6)-тай уялдуулж, тухайн амьдрах орчин тус бүрт тохирсон нөлөөллийг бууруулах зөвлөмж боловсруулах (3.1.3 хэсгийг үзнэ үү).
- Хөгжлийн төсөл хэрэгжүүлж байгаа газарт нөлөөлөл бууруулах иж бүрэн, үр дүнтэй арга хэмжээг дэмжих. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа үед тэдгээр нь экологийн хувьд нөлөөлөлтэйгээ ижил тэнцүү байх, бүс нутгийн байгаль хамгаалах зорилготой нийцсэн байх, Засгийн газрын болон бизнесийн төлөвлөгөөнд сууж өгсөн байх шаардлагыг тус тус хангаж байгаа эсэхийг хянах (2.9 болон 3.1.4 хэсгийг үзнэ үү).
- Хөгжлийн нөлөөллийг байгаль орчныг хамгаалах шаардлагатай үйл ажиллагаагаар нөхөж, биологийн олон янз байдлын тухайд эерэг үр дүнд хүрсэн байх (3.1.4 хэсгийг үзнэ үү).
- Газар ашиглалтын төлөвлөлтийн үйл явцыг аймаг, сумын түвшинд гүйцэтгэх, мэдээлэх.
- Цаашид шинээр хийх биологийн судалгаа, шинжилгээний ажлын удирдамж болох зэргийг дурьдаж болно.

Байгаль хамгаалах үйл ажиллагааг үр дүнтэй байлгахын тулд тэргүүлэх ач холбогдол бүхий байгаль хамгаалах үйл ажиллагааг системтэйгээр ландшафтын түвшинд тодорхойлох зарчмыг баримталж, амьдрах орчин, аюул занал, нөлөөллийн тархацыг бүс нутгийн эсвэл ландшафтын түвшинд авч үзэх шаардлагатай. Бид энэ судалгааны ажлаар богино хугацаанд, мэдээлэл харьцангуй бага нөхцөлд ландшафтын түвшинд байгаль хамгаалах төлөвлөлтийг хийх боломжийг харуулах, мөн шийдвэр гаргах шаардлагатай үед ч дэмжлэг үзүүлж чадахуйц баримт бичиг гаргахыг зорьсон юм. Судалгааны ажлын үр дүн ба бусад мэдээллийг цаашид байнга цуглуулах, мониторинг хийх, боловсруулах, цэгцлэх үйл явцын анхны алхам гэж ойлгох хэрэгтэй. Судалгааны ажилд ашигласан болон өөрсдийн боловсруулан гаргасан арга зүй нь нийтэд ил тод нээлттэй учраас шинэчлэх, засварлах боломжтойгоос гадна, ажлын үр дүн ба олонх мэдээллийг бид нийтийн хүртээл болгож бусад байгууллага, судлаачид ашиглах боломжийг олгох болно.



1.0 УДИРТГАЛ

1.1 СУДАЛГААНЫ БҮС

Дэлхийн эх газрын 11 орчим хувийг гандуу газар нутаг эзлэх (Mortimore et al. 2009) бөгөөд энэхүү нутаг нь маш олон хэлбэрийн биологийн олон янз байдлыг тэтгэж байдгийн зарим нь дэлхийн хэмжээнд ховордож, устах аюулд өртсөн зүйл байдаг (Durant et al. 2012, IUCN 2011). Биологийн олон янз байдлын олон хэлбэрээс үл хамааран дэлхий даяар тархсан нийт гандуу газар нутгийн дөнгөж 10-аас бага хувь нь хамгаалалтад орсон байдаг (Hoekstra et al. 2005) бол 20 орчим хувь нь ямар нэгэн байдлаар доройтолд орсон байна (Reynolds et al. 2007, Safriel et al. 2005, UNCCD 1994). Гандуу газар нутаг нь дэлхийн бүх тивд тархсан ба дэлхийн нийт хүн амын 6 орчим хувь нь энэ нутагт амьдардаг ажээ. Эдгээр нь ихэвчлэн амиа аргацаасан аж ахуй бүхий тариачин, малчин (нүүдлийн мал аж ахуй эрхлэгч) байх ба тэдний амьжиргаагаа тогтвортой хангах явдал тухайн нутгаасаа хамааралтай байдаг (Mortimore et al. 2009; Safriel et al. 2005).

Тодорхойлолтоор бол гандуу газар нутаг нь маш бага хур тунадас унадаг газар юм. Ийм бүс нутагт ихэнх ургамлын зүйлийн ургахад шаардлагатай чийгийн хэмжээнээс бага хур тунадас унах бөгөөд учир нь ууршиж байгаа усны хэмжээ нь хур тунадас хэлбэрээр унаж байгаа уснаас их байдагтай холбоотой юм. Уур амьсгалын ийм хуурай нөхцөл нь ач холбогдол өндөртэй ашигт малтмалыг бүрэлдэн бий болох, нэг газар ихээр төвлөрөх угтвар нөхцөл болдог байна. Шохойн чулуу, борын давс, азотын давс, калийн давс ба бусад төрлийн давс нь тэдгээрийг агуулж байсан ус ууршсаны улмаас гандуу газар нутагт үүсдэг ажээ. НҮБ-ын байгаль орчны хөтөлбөрийн статистик мэдээллээс харвал, дэлхийд олборлож байгаа зэс болон ураны 50 илүү хувь нь гандуу газар нутагт ногдохоос гадна газрын тосны нөөцийн 75 хувь нь энэ газар нутагт хамаардаг (Safriel et al. 2006).

Монгол орны говь, цөл нутгийг онгон (аж ахуйн үйл ажиллагаанд хамгийн бага өртсөн) зэрлэгээрээ үлдсэн дэлхийн хамгийн том газар нутгийн нэг хэмээн судлаачид тодорхойлжээ (Sanderson et al. 2002). Дэлхийн гандуу эко-бүс нутгийн хүрээнд (Olson et al. 2001) Алашань цөлийн тэгш өндөрлөг нь хүний нөлөөнд хамгийн бага буюу 20 хувиас бага хэмжээгээр өртсөн гэж судлаачид онцолжээ (Oakleaf et al. хэвлэлд). Монгол орны говь, цөлийн бүс нутаг нь ховордлын эрсдэлтэй болон устаж болзошгүй 33 зүйл амьтны уугуул нутаг юм (Clark et al. 2006, Terbish et al. 2006, Gombobataar et al. 2012). Энэ бүс нутагт

ховордлын эрсдэлтэй зүйлийн жагсаалтад бүртгэгдсэн Монгол хулан (*Equus hemionus*), хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*), цагаан зээр (*Procapra gutturosa*), янгир (*Capra sibirica*), хавтгай (*Camelus ferus*) болон өөр жижиг биетэй бусад амьтны зүйлийн дэлхийн хэмжээнд томоохонд тооцогдох популяци оршдог (Moehlman et al. 2008, Mallon 2008, Mallon 2008). НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Шим мандлын нөөц газар хэмээх ангилалд бүртгэгдсэн Говийн их дархан цаазат газар (ГИДЦГ)-ын "А" хэсэг нь мазаалайн дэлхийн тархацын цор ганц түшиц нутаг, нөгөө талаас хавтгайн дэлхийд үлдсэн сүүлчийн гурван тусгаар тархац нутгийн нэг юм. Эдгээр ховордлын эрсдэлтэй болон устаж болзошгүй зүйлүүдийн экологийн болон нөхцөл байдлын талаарх мэдээлэл дутмаг, тодорхойгүй байна. Иймээс энэ бүс нутгийн зэрлэг амьтан, ургамлын суурь судалгааны ажлыг нэн даруй эхлүүлэх нь зүйтэй юм (Batsaikhan et al. 2010, Clark et al. 2006).

Энэ бүс нутагт түүхэн үеэс эдүгээ хүртэл хүн амын суурьшил, нягтшил бага байсаар ирсэн (ШУА 2009) тул хүний үйл ажиллагааны нөлөө, сөрөг үр дагавар дэлхийд хамгийн бага байдаг газар нутгуудын нэг хэвээр байгаа юм (Sanderson et al. 2002). Гэвч, 1990 оны зах зээлийн эдийн засгийн шилжилтээс улбаалан энэ гандуу бүс нутагт хүний үйл ажиллагааны дарамт, хөнөөл эрс нэмэгджээ. Мал маллагааны уламжлалт хэлбэр, сүргийн бүтэц өөрчлөгдсөний зэрэгцээ (Fernandez-Gimenez and Batbuyan 2004, Fernandez-Gimenez 2001, Fernandez-Gimenez 1999), Монгол улсын




хэмжээнд мал сүргийн тоо толгой сүүлийн хорин жилийн хугацаанд бараг хоёр дахин өсөж, ойролцоогоор 40 орчим сая толгойд хүрчээ (Үндэсний статистикийн газар, 2008). Үүнээс улбаалан, хүн амын суурьшил, усны эх булаг орчимд бэлчээрийн талхигдал нүүрлэж, улмаар мал болон зэрлэг амьтдын бэлчээрийн тэтгэх даац буурах үйл явц ихээр ажиглагдах болжээ (Reading et al. 2006, 2010, Stump et al. 2005).


Ашигт малтмалын эрэл хайгуул, ашиглалт өргөн цар хүрээнд хурдацтай нэмэгдэж байна. Өнөөгийн байдлаар Монгол улсын нийт газар нутгийн 15 орчим хувьд ашигт малтмал, газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдоод байгаа бөгөөд цаашид 26 орчим хувьд нь ийм зөвшөөрөл олгох боломж нээлттэй байна (Ашигт малтмалын газар, 2012). Уул уурхайн хөгжил нь Монгол орны говийн бүс нутагт бусад бүс нутагтай харьцуулахад илүү хурдацтай байгаа нь илэрхий боллоо. Бидний судалгаанд хамрагдсан энэ бүс нутгийн нийт талбайн 24 хувьд нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон бөгөөд, харин 32 хувьд нь тусгай зөвшөөрөл нэмж олгох боломж нээлттэй байгаа ажээ (Ашигт малтмалын газар, 2012). Уул уурхайн үйл ажиллагаанаас газар ба усанд үзүүлэх шууд нөлөө нь тухайн уурхайн эдэлбэр нутгаар хязгаарлагдахгүй бөгөөд улмаар уурхайн үйл ажиллагаатай холбоотой зам тээврийн дэд бүтэц, замын хөдөлгөөний эрчмээс үүдэлтэй саад тотгор амьтны шилжилт хөдөлгөөнд илүү аюул уршиг учруулж болзошгүй байна (Ito et al. 2005, Ito et al. 2013, Kaczensky et al. 2011, Kaczensky et al. 2006, Olson 2012, Lkhagvasuren et al. 2011, Lkhagvasuren 2000).


Энэ судалгааны бүс нутгийг ДБХС-гийн Монгол дах хөтөлбөрийн газраас Биологийн олон янз байдлын орхигдлын үнэлгээг хийхдээ, Төв Азийн Монгол орны хэсгийн Говь, цөлийн эко-бүс нутгийн Зүүн гарын говь, Говь-Алтай, Алтайн-өвөр говь ба Дорнод говь хэмээх 4 дэд эко-бүс нутаг болгон (Зураг 1-ыг үзнэ үү) ангилжээ (Chimed-Ochir et al. 2010). Энэ бүс нутаг нь Монгол улсын нийт газар нутгийн гуравны нэг (32%) буюу нутгийн өмнөд хэсгийн 510,000 км^2 талбайг эзлэнэ. Дурьдсан бүс нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, урт хүйтэн өвөлтэй сэрүүн цөлд хамаарна. Алтайн-өвөр говийн хэт гандуу цөлд жилд унах

Зураг 1: Монгол орны газрын эко-бүс нутаг.



Зураг 2: Судалгаанд хамрагдсан бүс нутаг: Монгол орны өмнийн говь









хур тунадасны хэмжээ 40 мм-ээс хэтрэхгүй бол хил залгаа орших Говь-Алтайн уулсаар 200 мм-ээс илүү хур тунадас унадаг (Hijmans et al. 2005). Гэвч жилийн хур тундасны хэмжээ харилцан адилгүй бөгөөд зарим газарт хур тунадас огт унахгүй байх агаад, маш их хэлбэлздэг. Агаарын олон жилийн дундаж температурын үзүүлэлт 1 дүгээр сард -20 градусаас илүү хүйтэн байдаг бол 7 дугаар сард 33 хэмээс илүү халдаг (Зураг 2. Hijmans et al. 2005).

1.2 БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Байгаль хамгаалах системтэй төлөвлөлт гэдэг нь экосистем, бүлгэмдэл, төрөл зүйлийн төлөөлөл болж чадах экологийн хувьд чухал ач холбогдол бүхий газруудыг тогтоох шинжлэх ухааны үндэслэлтэй цогц арга юм. Байгаль хамгаалах аливаа үйл ажиллагаа нь илүү үр дүнтэй, оновчтой байхын тулд амьдрах орчны тархац, учирч болох аливаа аюул уршгийг бүс нутаг ба ландшафтын түвшний хэмжээнд харгалзан үзэхийг шаарддаг (Margules & Pressey 2000, Groves 2003). Байгаль хамгааллын төлөвлөлтийн эцсийн бүтээгдэхүүн нь биологийн олон янз байдал, тэдгээрийн тархацыг бүрэн төлөөлж чадахуйц хэд хэдэн газар нутгийг нэгтгэсэн хамгааллын чухал ач холбогдолтой бүрдэл газар нутаг байна (e.g. Noss et al. 2002). Байгаль хамгааллын системтэй төлөвлөлтөд орон зайн дүн шинжилгээ хийхэд ашигладаг “Марксан” зэрэг өөрөө оновчтой сонголт хийх чадвартай программ хангамжийг ашигладаг (Ball and Possingham 2000). Энэ программ хангамж нь биологийн олон янз байдлыг тэтгэх амьдрах орчны хувьд хамгийн бага шаардлагыг хангаж чадахуйц, мөн газар нутгийн эзлэх талбайн хэмжээг хамгийн бага байх газрыг сонгох аргад үндэслэгджээ (Pressey et al. 1997, Ball 2000, Ball and Possingham 2000).

Дээр дурьдсан арга нь Groves *et al.* (2002), Groves (2003) болон Higgins & Esselman (2006) нарын боловсруулсан эко-бүс нутгийн үнэлгээний аргачлал ба стандартад тулгуурлажээ. Эко-бүс нутгийн үнэлгээ нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд: (1) тухайн судалгаанд хамрагдсан газрын биологийн олон янз байдлыг хамтатган төлөөлж чадахуйц зүйл, экосистем, бусад олон янз байдлыг илэрхийлэх сонгосон элементийг тодорхойлж, газрын зурагт буулгах; (2) хамгаалахаар төлөвлөж буй биологийн олон янз байдлын экологи, эволюцийн шаардлагыг удаан хугацааны туршид тэтгэхүйц тоо толгойн элбэгшил, тархацыг тооцсон зорилтыг дэвшүүлэх; (3) хамгаалахаар зорьж буй биологийн олон янз байдлын харьцангуй амьдрах чадвар, экологийн нийлэмж чанар, учрах аюул уршиг, тархац (бүлгэмдэл, популяци, экосистем гэх мэт)-ын төлөв байдлыг үнэлэх; (4) экологийн харьцангуй нийлэмж чанарыг илэрхийлэх, ирээдүйд учирч болох аюул уршгийн хамгийн бага эрсдлийг даван туулж чадах, хамтдаа төлөөлүүлэн хамгаалах зорилтыг хангаж чадахуйц биологийн олон янз байдлын элементийн тохиолдоцыг илрүүлэхэд дээр дурьдсан мэдээллийг ашиглах зэрэг болно. Энэ үйл ажиллагааны дарааллыг Зураг 3-т бүдүүвчлэн үзүүлэв.

1.3 УРЬД ХИЙГДЭЖ БАЙСАН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭ ТОГТООХ СУДАЛГААНУУД

Монгол улс дэлхийн хэмжээнд мэдэгдэж байгаа хамгийн эртний тусгай хамгаалалт бүхий газруудын нэг болох Богд хан уулын дархан цаазтай газрыг 1778 онд байгуулжээ. Монгол улсын Байгаль орчны яам 1996 онд Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны Үндэсний хөтөлбөрийг хэвлүүлсэн байна (БОЯ 1996). Энэ хөтөлбөрт Дархан цаазтай газар 8, Байгалийн цогцолборт газар 40, Байгалийн нөөц ба Дурсгалт газар 37 тус

Зураг 3: Хамгаалах шаардлагатай буюу экологийн хувьд чухал ач холбогдолтой газрыг тогтоох үйл явц.



тус шинээр байгуулахаар зөвлөжээ. 2008 оны байдлаар эдгээрийн 40 орчим хувийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан байна (Chimed-Ochir et al. 2010). Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мастер төлөвлөгөө (1998)-нд нийт газар нутгийн 30 хувийг улсын ба орон нутгийн тусгай хамгаалалтад авах зорилт дэвшүүлжээ. УИХ-ын 13 дугаар тогтоолд дурьдсан энэхүү 30 хувийн зорилтын 15 хувийг нь улсын тусгай хамгаалалтад, үлдэх 15 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад тус тус авахаар заажээ.

Өнөөдрийн байдлаар, Монгол улсын нийт газар нутгийн 17.4 хувь буюу 27.2 сая га газрыг хамарсан улсын тусгай хамгаалалттай 90 газрыг байгуулаад байна (Мягмарсүрэн ба Намхай 2012). Үүнээс гадна, Монгол улс 6 газрыг ЮНЕСКО-гийн Шим мандлын нөөц газар (UNESCO 2011a)-т, 2 газрыг Дэлхийн өв (UNESCO 2011b)-д, мөн 11 газрыг Рамсарын сүлжээ (Ramsar 2011)-нд тус тус бүртгүүлээд байна. Bird Life International байгууллагаас 70 газрыг Шувуудад чухал газар хэмээн тодорхойлжээ (Nyambayar & Tsveenmyadag 2009). Биологийн олон янз байдлын орхигдлын үнэлгээ (Chimed-Ochir et al. 2010)-гээр тусгай хамгаалалтад авах шаардлагатай 34 газрыг Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд шинээр хамруулахаар санал болгосны 6 нь бидний судалгаанд хамрагдсан говь, цөлийн бүсэд байгаа юм.

Судалгааны ажлын хамрах талбайн хүрээнд 110,000 км^2 талбайг эзлэн орших улсын тусгай хамгаалалттай 14 газар нутаг байх ба энэ нь нийт судалгаанд хамрагдсан талбайн 21%-ийг эзлэж байна. Судалгааны бүсэд Шувуудад чухал газар 8 байгаагаас дөрөв нь бүхэлдээ тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ. Эдгээр газар нутгуудыг зайлшгүй хамгаалах шаардлагатай газар нутагт шууд хамруулсан. Бүс нутгийн 30 хувийг хамгаалах зорилтод хүрэхийн тулд цаашид хамгаалах шаардлагатай газруудыг энэ судалгаагаар тогтоосон.





1.4 ХӨГЖЛИЙГ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨ БАГАТАЙ ТӨЛӨВЛӨХ НЬ

Дэ Нэйче Консерванси (TNC) байгууллага нь Монгол улсын засгийн газартай хамтран уул уурхай болон эрчим хүчний хөгжлийг уламжлалт бэлчээрийн мал аж ахуй болон амьдрах орчныг хамгаалах асуудалтай тэнцвэртэй хослуулах “Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь” хэмээх шинжлэх ухааны үндэслэлтэй аргачлалыг хэрэглэж байна (Kiesecker et al. 2009, Kiesecker et al. 2010, McKenney and Kiesecker 2010, Kiesecker et al 2011, Kiesecker et al. 2013). Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь тухайн нэг төслөөр хязгаарлагдахгүй, харин хөгжлийн хуримтлагдах нөлөөллийг ландшафт (бүхэл бүтэн экосистем)-ын хүрээнд тодорхойлох замаар тогтвортой хөгжлийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж чадах арга юм. Ландшафтын түвшинд байгаль хамгаалах төлөвлөлтийг ашигласнаар нөлөөллийг бууруулах уламжлалт аргыг эрс сайжруулах боломжтой. Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь байгаль хамгаалллын төлөвлөлтийг “нөлөөллийг бууруулах дараалал”-тай хослуулснаар нөлөөллийг үр дүнтэй бууруулах, зайлсхийх, дараа нь бууруулах буюу нөхөн сэргээх, эцэст нь дүйцүүлэн хамгаалах боломжийг бүрдүүлнэ. Нөлөөллийг үр дүнтэй бууруулахад дараах хэдэн чухал асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай. Үүнд:

- Тухайн нэг төслийн байршлаас үл хамааран ландшафтын хүрээнд зэрлэг амьтан, тэдгээрийн амьдрах орчинд үзүүлж болох “Хөгжлийн хуримтлагдах нөлөөлөл”-ийг тодорхойлох,
- Хөгжлийн төлөвлөгөө болон байгаль хамгааллын хооронд үүсэж болохуйц зөрчлийг хор уршиг учирхаас өмнө урьдчилан тогтоох,
- Зэрлэг амьтан болон эмзэг байгалийн унаган төрхөд нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх, зэрлэг амьтанд үзүүлэх хуримтлагдах нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах боломжийг тодорхойлох замаар хөгжил ба байгаль хамгааллын хэрэгцээг тэнцвэртэй хослуулж чадах хамгийн оновчтой боломжуудыг бий болгох,
- Төслийн нөлөөллөөс ямар тохиолдолд зайлсхийх, ямар тохиолдолд дүйцүүлэн хамгаалллыг хэрэгжүүлэх шаардлагатайг тогтоох,
- Экологийн хувьд ижил адилтгах орчин байх, ландшафтын хүрээнд байгаль хамгаалалд хувь нэмэр болохуйц, тухайн нөлөөлөлд өртсөн газарт ойролцоо байх, байгаль хамгааллын хамгийн их үр ашигтай байж чадах зэрэг шаардлагад нийцсэн дүйцүүлэн хамгаалллын арга замыг дэвшүүлэх,
- Төслийн зүгээс үзүүлсэн нөлөөллийг нөхөж чадахуйц, мөн биологийн олон янз байдлын хувьд “цэвэр ашигтай” байх зэрэг нөхцлийг хангасан дүйцүүлэн хамгааллыг тодорхойлох шаардлагатай.

Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх энэ арга нь хоёр ялгаатай орон зайн цар хүрээнд хэрэгждэг. Эхний үе шатанд, ландшафтын хүрээнд байгаль хамгааллын чухал холбогдолтой газруудыг эрэмбэлэх, тухайн бүс нутагт хуримтлагдах нөлөөллийг

тогтоох, байгаль хамгаалал ба хөгжлийн зорилт хоёрын хооронд үүсч болзошгүй зөрчилтэй газруудыг тогтоох, дээрх нөлөөллийг бууруулах, зайлсхийх талаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах (1 ба 2 дугаар үе шатыг үз) зэрэг асуудлуудыг авч үзнэ. Удаах үе шатанд "Хөгжлийг нөлөө багатай төлөвлөх нь" аргыг тухайн төсөл хэрэгжүүлэх газарт хэрэглэх бөгөөд тухайн төслийн нөлөөлөл, дүйцүүлэн хамгаалах боломжийг тодорхойлох, тэдгээр нөлөөллийг бууруулах арга замыг боловсруулна (3 ба 4 дүгээр үе шатыг үз).

Ландшафтын түвшинд:

1. Ландшафтын түвшинд байгаль хамгааллыг төлөвлөх (буюу Эко-бүс нутгийн үнэлгээний аргыг ашиглах),
2. Экологийн эмзэг байдал болон дахин сэргээгдэшгүй төлөв байдлыг харгалзан ландшафтын түвшний байгаль хамгааллын төлөвлөлтийг нөлөөллийг бууруулах дараалалтай хослуулан зөрчилтэй газарт үнэлэлгээ хийх,

Төслийн түвшинд:

3. Хөгжлийн үлдэгдэл нөлөөллийг тодорхойлж, дүйцүүлэн хамгаалах хамгийн зохистой хувилбарыг сонгох,
4. Байгаль хамгаалах эцсийн зорилтод дүйцүүлэн хамгааллын оруулах хувь нэмрийг тооцох явдал байх болно.

Энэ судалгаа нь ландшафтын түвшний дүн шинжилгээ хийх замаар төлөвлөж буй хөгжлийн нөлөөнөөс аль хэсэгт зайлсхийх, ямар тохиолдолд нөлөөллийг бууруулах эсвэл дүйцүүлэн хамгааллыг хэрэглэх нь зохистой вэ гэсэн чухал асуултуудад хариулт өгөхөд чиглэгдэнэ (Kiesecker et al. 2010, Thorne et al. 2006). Байгаль хамгааллын төлөвлөлт нь тухайлбал, эко-бүс нутгийн үнэлгээнд (e.g. Groves 2003) зэрлэг амьтны амьдрах орчин болон хүний хэрэгцээг хангахад шаардлагатай уудам түгээмэл, аливаа өөрчлөлтөд дасан зохицох чадвартай экосистемийг тэтгэх чиглэлтэй, байгаль хамгааллын зорилттой уялдсан нөлөөллийг бууруулах бүтцийг бий болгодог. Ландшафтын түвшний төлөвлөлтийг нөлөөллийг бууруулах үе шаттай хослуулах нь тухайн төсөл бүрээр нөлөөллийг авч үздэг уламжлалт аргатай харьцуулахад эрс ялгаатай давуу талыг агуулдаг. Учир нь, 1) одоогийн болон ирээдүйн хөгжлийн хуримтлагдах нөлөөллийг авч үздэг; 2) нөлөөллийг бууруулах үе шатыг хэрэглэхэд шаардлагатай (зайлсхийх эсвэл дүйцүүлэн хамгаалах гэх мэт) бүс нутгийн түвшний суурь мэдээллийг бүрэлдүүлэх; 3) нөлөөлөлд хамгийн их өртсөн экосистем болон биологийн зүйлийг хамгаалахад чиглэсэн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнээс уян хатан сонголт хийх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

1.5 СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ АШИГЛАХ НЬ

Экологийн бүс нутгийн үнэлгээний зорилго нь Монгол орны говь, цөлийн төлөөлөл болох биологийн олон янз байдал ба экологийн үйл явцыг тэтгэж чадах, зэрлэг амьтны амьдрах орчин болон улирлын шилжилт хөдөлгөөнд чухал үүрэгтэй, харьцангуй хөндөгдөөгүй байгаа түгээмэл экосистемийн цөм хэсгийг хамгаалахад ач холбогдолтой газрыг тогтооход чиглэгдсэн. Монгол улсын Засгийн газрын дэвшүүлсэн, нийт нутаг дэвсгэрийн 30 хүртэлх хувийг хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс хамгаалах шаардлагатай газрыг экосистемийн түвшинд дараах шалгууруудыг ашиглан тогтоолоо. Үүнд: экологийн нөхцөл байдлын хувьд хүний үйл ажиллагаанд хамгийн бага өртсөн, хамрах талбайн хэмжээ нь хамгийн бага байх, ашигт малтмалын болон газрын тосны хөгжлийн хэтийн төлөвтэй уялдсан байх, байгаль хамгаалах зорилгыг биелүүлэх боломжтой байх зэрэг шалгуурыг дурьдаж болно. Эдгээр газрыг тогтооход, байгаа мэдээлэл дээр тулгуурлан 510,000 км^2 талбай бүхий өргөн уудам бүс нутагт нийцсэн





байгаль хамгааллын төлөвлөлт хийх арга зүйг боловсруулан ашиглав. Судалгааны үр дүнд байгаль хамгаалал, хөгжил, газар ашиглалтын зохистой төлөвлөлтийг ландшафтын түвшинд авч үзэн, шийдвэр гаргахад дэмжлэг болохуйц мэдээллийн систем бүрэлдсэн болно. Судалгааны үр дүнд тогтоосон хамгаалах шаардлагатай газрууд болон мэдээллийн санг байгалийн баялагийн менежмент ба байгаль хамгааллын дараах үйл ажиллагаанд ашиглаж болно. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газрын сүлжээг төлөвлөх, өргөтгөх: Монгол улсын Тусгай хамгаалалттай газрын мастер төлөвлөгөөнд (1998 онд батлагдсан) тусгагдсан Монгол улсын нийт газар нутгийн 30 хүртэлх хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах зорилтыг хэрэгжүүлэхэд судалгааны үр дүнг ашиглах боломжтой. Улсын Их Хурлын 13 дугаар тогтоолоор газар нутгийн 15 хувийг улсын тусгай хамгаалалтад, 15 хувийг орон нутгийн хамгаалалтад тус тус хамруулах замаар дээр дурьдсан 30 хүртлэх хувийг хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхээр заажээ. Өнөөгийн байдлаар Монгол улс нийт нутаг дэвсгэрийнхээ 17.4 орчим хувь буюу 27.2 сая га газрыг хамарсан улсын тусгай хамгаалалттай 90 газрын сүлжээг байгуулаад байгаа билээ (Мягмарсүрэн ба Намхай 2012). Судалгааны үр дүн нь: 1) Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 30 хүртлэх хувийг тусгай хамгаалалтад авах зорилтыг биелүүлэх, 2) хамгаалалтад авах газрыг эрэмбэлэх, одоогийн тусгай хамгаалалттай газруудын менежментийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг болж чадах юм.
- Хөгжил ба байгаль хамгааллын хооронд үүсч болзошгүй зөрчлийг төлөвлөлтийн шатанд илрүүлэх: Хөгжил болон байгаль хамгааллын хооронд үүсч болзошгүй орон зайн давхцалыг урьдчилан тогтоосноор хөгжлийн болон байгаль хамгаалах зорилтуудыг тэнцвэртэй хадгалах замаар хөгжлөөс учирч болох нөлөөллийг үр дүнтэй бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх боломж бүрэлдэнэ.
- Уул уурхай болон газрын тос олборлох үйл ажиллагааны нөлөөллийг бууруулах: Нөлөөллөөс зайлсхийх болон дүйцүүлэн хамгаалах замаар нөлөөллийг бууруулах үе шатыг хэрэгжүүлэх бүтцийг бий болгосноор шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргах явцыг дэмжих боломжтой.
- Дүйцүүлэн хамгааллыг төлөвлөх: Одоогийн болон ирээдүйн хөгжлийн хуримтлагдах нөлөөллийн хүрээнд байгаль хамгааллын үнэ цэнийг тодорхойлсноор, хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангахын зэрэгцээ ландшафтын түвшний байгаль хамгааллын зорилтыг биелүүлэхэд хувь нэмэр оруулж чадахуйц дүйцүүлэн хамгааллыг төлөвлөхөд шаардлагатай үндэс суурийг бий болгоход туслана.
- Газар ашиглалтыг төлөвлөх: Хамгаалах шаардлагатай газар нутгууд, түүнтэй холбоотой мэдээллийг улс, аймаг, сумын газар ашиглалтын төлөвлөлтөд ашиглах боломжтой. Бүс нутгийн амьдрах орчны хэв шинж, малчин айл өрхийн нягтшил, газар ашиглалтын бусад мэдээллийг ашиглан бэлчээрийн зохистой менежмент хийх, зэрлэг амьтан ба малын бэлчээрийн өрсөлдөөнийг бууруулах, бэлчээрийн нөөц газрыг тогтоох ба менежментийн арга хэмжээг тодорхойлох боломж бүрдэнэ (3.1.5 хэсэгт дэлгэрэнгүй тайлбар бий).
- Экосистем ба экологийн үйл явцын талаарх судалгаа шинжилгээ, мэдлэгийг байнга сайжруулах ажлын үндэслэл: Ургамалшил болон экосистемийн зураглал, зүйлийн амьдрах орчны тархацын загвар нь амьтан, ургамлын зүйлийн эсвэл ургамалшлын судалгааны чиглэлийг тодорхойлох суурь болно. Судалгааны ажлын үр дүнг ургамалшил, экосистемийн зураг болон зүйлийн амьдрах орчны тархацын загварыг цаашид сайжруулахад ашиглах боломжтой.



2.0 АРГА ЗҮЙ БА ҮР ДҮН

2.1 ТОЙМ

Монгол орны өмнийн говийн экологийн бүс нутгийн төлөөлөл болох биологийн олон янз байдал, экологийн үйл явцыг тэтгэж чадах, хамгаалах шаардлагатай газар нутгийг тодорхойлоход энэ судалгааны ажлын зорилго оршино. Энэ бүс нутгийн биологийн олон янз байдлыг тодорхойлох зорилгоор газрын экосистемийн ангиллыг боловсруулж, 193 ялгаатай хэв шинжийг зураглав. Хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтоохдоо дараах шалгууруудыг ашигласан. Үүнд:

- **Төлөөллийн шалгуур:** Биологийн олон янз байдал тус бүрийн хувьд экологи, эволюцийн урт хугацааны үйл явцыг тэтгэхэд шаардлагатай тодорхой тоо болон хэмжээг хамгаалах зорилгыг хангасан байх. Хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг газрын экосистемийн ангилалаар тодорхойлж, судалгааны бүс нутагт оршин буй экосистем тус бүрийн газарзүйн тархацын хэсгийг төлөөлөл болгох замаар хамгаалах.
- **Экологийн нөхцөл байдлын шалгуур:** Бидэнд байгаа явцуу мэдлэг, дутмаг мэдээллийн хүрээнд хүний үйл ажиллагааны нөлөөллийн индексийг ашиглан экологийн нийлэмж чанар эсвэл хамгийн сайн амьдрах чадвартай биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг агуулж байгаа газар нутгийг илүүд үзэж, сонгох.
- **Үр дүнтэй байдлын шалгуур:** Өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн үйл ажиллагаанаас үзүүлэх аюул уршгийг даван туулах чадвартай, биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг хамгаалах зорилтыг хангаж чадахуйц, хамгийн бага талбай эзлэх, хамгийн цөөн тоотой хамгаалах газар нутгийг илрүүлэх.
- **Амьдрах орчны холбогдох байдал:** Олон жижиг газрыг сонгохоос илүүтэй хоорондоо ойр дөт байршилтай цөөн, уудам газрыг сонгох зарчим баримтлав. Харин боломжтой тохиолдолд үргэлжилсэн уудам газрыг сонгосон болно.

Хамгаалах шаардлагатай газар нутгийн сонголтыг доор дурьдсан үе шат ба бүрэлдхүүнд тулгуурлан гүйцэтгэв. Үүнд:

Нэгдүгээр үе шат – Ажлын хэсэг: Судалгаа ба бодлогын асуудлаар зөвлөх, төлөвлөлтийн явцад зөвлөгөө өгөх, хянан тохиолдуулах үүрэгтэй оролцогч талууд ба судлаачдаас бүрдсэн бодлогын болон судалгааны чиг үүрэгтэй хоёр ажлын хэсэг байгуулсан. Судалгааны ажлын хэсэгт мэдээлэл цуглуулах, боловсруулах, гарсан үр дүнд анализ хийж, зөвлөх үүрэгтэй, судалгаанд хамрагдсан

газар нутгийн талаар мэдлэгтэй, урьд өмнө тухайн газарт биечлэн судалгаа гүйцэтгэж байсан туршлагатай биологич, газарзүйч судлаачид оролцов. Судлаачдын зөвлөх баг нь судалгааны явцад гурван удаа уулзалт, ярилцлага зохион байгуулсны зэрэгцээ, олон удаа төслийн гүйцэтгэгч багтай хэсэгчилсэн болон ганцаарчилсан уулзалт хийж, цуглуулсан мэдээллийг боловсруулах, гарсан үр дүнг нягтлан, зөвлөж ажилласан болно. Бодлогын зөвлөх багийн бүрэлдхүүнд судалгааны дараах үе шатны хэрэгжилтийн асуудлаар зөвлөгөө өгөх чиг үүрэгтэй Засгийн газрын удирдах албан тушаалтан, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөлөл оролцсон. Ажлын хэсэг, оролцогч талуудын уулзалт, хэлэлцүүлгийн сэдвийг Хавсралт 7-с үзнэ үү.

Хоёрдугаар үе шат – Одоогийн тусгай хамгаалалттай газар нутаг:

Бидний судалгааны бүс нутагт оршиж буй дархан цаазат газар, байгалийн цогцолбор газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар зэрэг тусгай хамгаалалттай бүх газар нутгийн хилийн цэсийг орчны бүсийг оруулалгүй газрын зураг байршуулсан. Эдгээр газар нутаг нь хамгаалах шаардлагатай газар нутгийг шинээр тогтоох, төлөвлөх үйл ажиллагааны эхний алхам, үндсэн суурь болсон юм.



Гуравдугаар үе шат – Хамгаалах шаардлагатай газар нутаг:

Энэ судалгааны явцад, бусад байгаль хамгааллын чухал түшиц газраас тухайлбал, шувуудад чухал газар нутаг болон орон нутгийн тусгай хамгаалалттай (Тост уул зэрэг) газар нутгийг хамруулсны зэрэгцээ, зарим нэг өөрчлөлт оруулсныг дурьдах хэрэгтэй. Одоогийн улсын тусгай хамгаалалттай газар нутгуудыг хамгаалах шаардлагатай газруудад оруулсан ба цаашид хамгаалах шаардлагатай газруудыг нэмэж тогтоосон.

"Тост уул" орон нутгийн хамгаалалттай газар. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт оршдог Тост уул болон Тосон бумбын нуруу нь дэлхийд ховордсон ирвэс, түүний гөрөөл амьтан янгирын тоо толгой элбэг, харьцангуй их нягтшилтай идээшин амьдардаг нутаг юм (Г.Цогтжаргал, Tom McCarthy, Rodney Jackson нарын хэвлүүлээгүй мэдээ). Энэ газар нутгийг 2010 онд орон нутгийн хамгаалалтад авсан хэдий ч тухайн сумын Овоот, Урт, Тост багийн иргэд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах санал дэвшүүлжээ.

Шувуудад чухал газар (IBAs). Судалгаанд хамрагдсан газар нутгийн хүрээнд Bird Life International олон улсын байгаль хамгааллын байгууллагаас тогтоосон дэлхийн хэмжээнд ховордсон, тархац нутаг нь хумигдсан, байгалийн бүс нутгийн хүрээнд хязгаарлагдмал амьдрах орчин шүтэн оршдог ангилал зүйн бүлэг эсвэл шувууд олнооров цуглардаг шувуудад чухал 10 газар хамрагдаж байна (Nyambayar & Tseveenmyadag 2009). Эдгээр газруудыг доор жагсаав. Шувуудад чухал газраас Галбын говь, Борзон говь болон Булган гол бүхэлдээ, харин бусад нь тодорхой хэмжээгээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ. Харин Галбын говь, Булган голын шувуудад чухал хоёр газрын хувьд нөлөөллийн индекс (2.4-т тодорхойлсон)-ийг харгалзан үзэж, нөлөөлөлд илүү өртсөн амьдрах орчин бүхий хэсгийг хамгаалах шаардлагатай газрын талбайгаас хасаж тооцсон бөгөөд энэ тухай доор тайлбарлав.

- Булган голын шувуудад чухал газар: Булган гол - Их Онгогийн БЦГ-т Булган голын татмын нугатай газар ба голын эх орчим нутгийн 320 км^2 газар тус тус хамаарна. Тодруулга: Булган голын урсацын

Булган сумын төв орчим дамжин урсах хэсэгт малчдын өвөлжөө олон байгаа тул (40 км^2 талбайд ойролцоогоор 85 өрх өвөлждөг) өвөлжөөний эзлэх талбайг дөрөвдүгээр үе шатад хасаж тооцлоо.

- Их Богд уулын шувуудад чухал газар: Их Богдын БЦГ-ын нутаг дэвсгэрт оршдог.
- Говь Гурван Сайхан уулын шувуудад чухал газар: Говь Гурван Сайханы БЦГ-ын нутаг дэвсгэрт оршдог.
- Борзон Говийн шувуудад чухал газар: Ихэнх хэсэг нь Говийн Бага ДЦГ-ын “А” хэсгийн нутаг дэвсгэрт хамаардаг.
- Галбын Говийн шувуудад чухал газар: Говийн Бага ДЦГ-ын “А” хэсгийн дорнод хэсгээс, “Б” хэсгийн өрнөд этгээдийг хамран сунаж тогтсон байршилтай. Тодруулга: Говийн Бага ДЦГ-ын “А” ба “Б” хэсгийн завсар орших энэ газар нь Таван толгойн нүүрсний уурхай ба Гашуун сухайтын хилийн боомт хоорондын нүүрс тээврийн авто замаар тусгаарлагдсаны зэрэгцээ энд мөн Оюу Толгой уурхайгаас Гашуун сухайт чиглэлийн хурдны авто зам баригдаж байгаа, өндөр хүчдэл дамжуулах шугам саяхан баригдсан байна. Мөн энд Оюу Толгойн замын трассын дагуу Цагаанчулуут ба Шарчулуутын уурхайн ашиглалтын өргөдөл бүхий талбай оршдог. Иймд энэ хэсэг газрыг дөрөвдүгээр үе шатад оруулаагүй боловч, судлаачдын зөвлөх багийн зөвлөснөөр зургаадугаар үе шат (2.1.6.)-д хамгаалах шаардлагатай газарт оруулсан.
- Их Газрын Чулууны шувуудад чухал газар: Их Газрын Чулуу БНГ-ын нутаг дэвсгэрт оршдог.
- Их Нартын шувуудад чухал газар: Энэ нь Их Нартын БНГ-т багтана.
- Шувуудад чухал гурван газар (Бөөн цагаан нуур, Таацын цагаан нуур, Орог нуур) судалгааны нутгийн умард хязгаарт орших бөгөөд эдгээр нь Рамсарын бүртгэлтэй газруудын нэг хэсэг нь юм (Нууруудын хөндий; Ramsar 2011). Эдгээр газруудын хоёрынх нь багахан хэсэг нь судалгааны бүс нутагт хамаарна.

Дөрөвдүгээр үе шат – Экосистемийн төлөөлөл газруудыг сонгох:

Экосистемийн төлөөлөл болох зорилтыг хангахуйц хэд хэдэн газар нутгийг улсын тусгай



хамгаалалттай газар нутаг, шувуудад чухал газар, орон нутгийн хамгаалалтай газар (Тост уул) нутагтай хамтатган хийсний зэрэгцээ экосистемийн төлөөлөл болох шаардлагатай нэмэлт газруудыг Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-ийг ашиглан тогтоолоо. Энэ дүн шинжилгээ нь үндсэн гурван бүрэлдхүүн хэсэгтэй. Үүнд:

Нэгдүгээрт, **биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийн төлөөллийг** ГМС-д оруулах үйл явц нь био-газарзүйн бүсийн шатлалд үндэслэн хийсэн газрын экосистемийн ангиллыг ашиглан тодорхойлж, газрын зураг оруулсан амьдрах орчны хэв шинж, мөн ургамалшлын хэв шинж, газрын гадаргын хэлбэр зэрэгт тулгуурлан хийгдсэн экосистемийн хэв шинжийг тодорхойлох зэргээс бүрдэнэ (2.2.1 хэсэгт буй тайлбарыг үзнэ үү).

Хоёрдугаарт, эдийн засгийн хувьд өндөр үр ашигтай, нөгөө талаас, экологийн хувьд доройтсон ба олон малтай, бэлчээр ашиглалтын эрчим ихтэй газруудыг тодорхойлох зорилгоор, хүний үйл ажиллагааг төлөөлөх орон зайн мэдээлэл дээр тулгуурлан **нөлөөллийн индекс** (2.4-т тодорхойлсон)-ийг тооцоолов.

Гуравдугаарт, байгаль хамгааллын төлөвлөлт хийхэд ашигладаг “МАРКСАН” программ хангамжийг ашиглан улсын тусгай хамгаалалттай газар нутаг, шувуудад чухал газруудыг багтаасан, экосистемийн төлөөллийн зорилтыг хангасан, экологийн нөхцөл байдал ба холбогдох байдлын шалгуурыг хангахуйц хамгаалах шаардлагатай газар нутгийг оновчтойгоор **сонгосон** (2.6 – 2.8-д буй тайлбарыг үзнэ үү).

Тавдугаар үе шат – Төлөвлөж буй ашигт малтмал ба газрын тосны хөгжлөөс үүсч болзошгүй зөрчлийг бууруулах зорилгоор хамгаалах шаардлагатай буюу экологийн хувьд чухал ач холбогдолтой газрыг дахин төлөвлөх: Ирээдүйн хөгжлийн үйл ажиллагаа хэрэгжих боломжтой нутагт давхцаж буй хамгаалах шаардлагатай газар нутгийг тусгайлан анхаарав. Судалгааны бүс нутгийн хүрээнд ирээдүйн хөгжлөөс учруулах дарамтыг урьдчилан тодорхойлохын тулд, одоогоор олгогдсон уул уурхайн бүх төрлийн тусгай зөвшөөрлийг (хайгуул, өргөдөл болон ашиглалт г.м.) газрын зураг буулгасан болно. Хамгаалах шаардлагатай газар нутгууд болон уул уурхайн зориулалтаар тусгай зөвшөөрөл олгосон газруудын хоорондын давхцалыг дараах байдлаар дахин төлөвлөв. Биологийн болон амьдрах орчны үнэ цэн ихтэй (2.7 ба 2.8-д тайлбарыг ашиглан тодорхойлсон) давхцалтай газруудыг хөгжлийн үйл ажиллагаанаас зайлсхийх шаардлагатай газар хэмээн тусгайлан ялгалаа. Давхцалтай бусад газруудыг хамгаалах шаардлагатай газруудын жагсаалтаас хасаж, уул уурхайн тусгай зөвшөөрөл олгогдоогүй, экологийн нөхцөл, бүрдлийн хувьд ижил төсөөтэй өөр боломжит газрыг илрүүлж орлуулсан юм.

Зургаадугаар үе шат – Мэргэжилтнүүдийн санал, зөвлөмж: ГМС-ийн тусламжтай сонгосон хамгаалах шаардлагатай газрууд нь нарийвчлал багатай, одоо байгаа (Дөрөв ба Тавдугаар үе шатны) мэдээлэл дээр тулгуурласан тул мэргэжилтнүүдийн санал зөвлөмж нэн чухал ач холбогдолтой байв. Судалгааны зөвлөх багийн гишүүдийн 2013 оны 1-р сараас 3-р сард хийсэн хэд хэдэн хэсэгчилсэн уулзалтаар 17 газрыг хамгаалах шаардлагатай газар хэмээн нэмж тодорхойлсон (Хавсралт 5 болон Зураг 21-г үзнэ үү). Үүнд ДБХС-ийн Биологийн олон янз байдлын орхигдлын үнэлгээ (Chimed-Ochir et al. 2010)-гээр улсын тусгай хамгаалалттай газар болгохоор БОНХ яаманд санал болгосон 5 газрыг мөн оруулсан болно.

2.2 ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН БҮРДЭЛ ХЭСЭГ

Байгаль хамгааллын системтэй төлөвлөлтөд хамгаалах биологийн олон янз байдлын урт хугацааны туршид оршин амьдрахад шаардлагатай наад захын шаардлагыг хангахуйц биологийн бүхий л бүрдэл хэсэг, тэдгээрийн орон зайн тархац, төлөв байдлыг нь тусгасан хамгаалах зорилтыг тодорхойлох нь нэн чухал байдаг. Мэдлэг, мэдээллийн дутмаг байдал ба биологийн тогтолцооны нарийн төвөгтэй зохион байгуулалт зэрэг нь хамгаалбал зохих хэдэн мянган биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг тэр бүр тодорхойлоод байх боломжийг олгодоггүй ба тийм ч шаардлага байхгүй юм. Тиймээс тархац нутгийг нь газрын зурагт оруулах боломж бүхий мэдээллийн олдоцтой, тухайн бүс нутгийн биологийн олон янз байдлын бүрдэл







хэсгийг хамгийн сайн төлөөлж чадах хүрээлэн буй орчны шинж чанар, хэв шинж болон зүйл эсвэл биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг сонгон авах зарчмыг баримталдаг.

Биологийн олон янз байдал нь орон зайн янз бүрийн тархацтай байхын сацуу экологийн ялгаатай эрэмбэд оршдог. Тиймээс бүс нутгийн хэмжээнд байгаль хамгааллын төлөвлөлтийг хийхдээ, зүйлээс экосистем хүртэлх тогтоцын эрэмбэ болон орон зайн янз бүрийн хэмжээг харгалзан үзэх хэрэгтэй (Noss 1996, Margules & Pressey 2003, Groves 2003). Биологийн олон янз байдлын бүрдэл хэсэг нь Poiani нарын (2000) тодорхойлсноор орон нутгийн, дунд хэмжээтэй, өргөн болон бүс нутгийн хэмжээний хэмээх орон зайн ялгаатай тархацтай байж болно (Хүснэгт 4).

Экологийн бүс нутгийн үнэлгээний явцад хамгаалах биологийн олон янз байдлыг сонгохдоо ерөнхий болон нарийн шүүлтүүр гэсэн шалгуурыг түгээмэл ашигладаг. Үүнд, бүх экосистемүүд (ерөнхий шүүлтүүр) болон зөвхөн экосистемээр төлөөлүүлж болохооргүй ховор, маш тодорхой амьдрах орчин шаарддаг, уудам орон зайд нүүдэллэдэг зүйлүүд (нарийн шүүлтүүр) багтана (Groves et al 2002; Groves 2003). Ерөнхий шүүлтүүр ашиглах нь төлөөлөл экосистемийг хамгаалах боломж олгох ба элбэг тархацтай, сайн судлагдаагүй буюу тархац нь тогтоогдоогүй бүлгэмдэл, зүйлүүд тэдгээрийн эволюци явагддаг орчныг хамгаалах боломж олгодог гэж үздэг (Jenkins et al 1976, Hunter 1991). Байгаль хамгааллын төлөвлөлтөд зөвхөн амьтан, ургамлын зүйлийг авч үзэх нь амьдрах орчныг тэтгэж байдаг хүрээлэн буй орчны өргөн хүрээтэй үйл явц болон түгээмэл зүй тогтлыг хамгаалахад учир дутагдалтай байдаг. Ерөнхий болон нарийн шүүлтүүрийг ашиглах нь амьдрах орчны бүтэц, үйл ажиллагаанд чухал нөлөөтэй хүрээлэн буй орчны хэв шинж, үйл явц, тогтоцыг олон шатанд авч үзэх боломж олгоно. Хүрээлэн буй орчны янз бүрийн хэв шинж, бүтцийг янз бүрийн орон зайн хэмжээнд төлөөлж чадах биологийн олон янз байдлыг хамгаалахаар сонгох нь экосистемийн динамикт хэв шинж болон уур амьсгалын өөрчлөлтийн тодорхойгүй нөхцөлд байгаль хамгааллыг зохистой төлөвлөх боломж олгодог (Hunter 1988, Halpin 1998, Groves 2003, Beier & Brost 2010, Anderson & Ferree 2010).

Энэ арга нь бэлэн байгаа олдоцтой мэдээлэл дээр тулгуурлан, тухайн хамгаалах шаардлагатай газрын бүрэн төлөөлөл болж чадах цөөн тооны хамгаалах амьдрах орчны олон янз байдлыг сонгох боломж олгодог тул практик ач холбогдолтой. Зүйлийн тархац болон тэдний амьдрах орчны талаар өнөөгийн бидний шинжлэх ухааны мэдлэг, мэдээлэл хомс байгаа юм. ГМС-ийн бэлэн байгаа мэдээллийг ашиглан ерөнхий шүүлтүүрээр экосистемийг газрын зурагт оруулах боломжтой байдаг. Энэ нь байгаль хамгааллын төлөвлөлтийг хийх үндэс болох бөгөөд дутуу байгаа мэдээллийг нөхөх ач холбогдолтой. Нарийн шүүлтүүрээр илрүүлэх бүлгэмдэл, зүйлийн тархацын талаарх мэдээлэл ихэнх тохиолдолд хомс байдаг ба нарийвчилсан судалгаа шаарддаг тул орон зайн мэдээлэл нь харилцан адилгүй олдоцтой байдаг. Иймд ерөнхий боловч, нэг аргачлалаар тодорхойлсон экосистемийн ангиллыг ашиглах нь хээрийн судалгаагаар үнэмшилтэй тогтоосон

Зураг 4: Хамгаалбал зохих биологийн олон янз байдлыг сонгох нь: Орон зайн хэмжээ ба биологийн олон янз байдлын бүрдэл хэсэг. (Poiani ба бусад /2000/-ын боловсруулсан загварыг үндэслэн гаргав)



боловч, орон зайн хувьд жигд бус тархацтай зүйлийн талаарх мэдээллийн дутагдалтай байдлыг орлуулах боломж олгодог давуу талтай.

Биологийн олон янз байдлын ерөнхий шүүлтүүрийг тодорхойлж, газрын зураг буулгахын тулд бид био-газарзүйн муж, ургамалшил, геоморфологи дээр тулгуурласан экосистемийн ангиллыг боловсруулаа. Нарийн шүүлтүүрт (Хүснэгт 3-т үзүүлсэн мэдээг үзнэ үү) Улаан дансны жагсаалтад устаж болзошгүй, устаж байгаа, ховордож болзошгүй, эмзэг зэрэглэлээр бүртгэгдсэн нийт 33 зүйл хөхтөн, мөлхөгчид, шувуудыг хамруулав (Gombobaatar et al. 2011, Clark et al. 2006, Terbish et al. 2006). Эдгээр 33 зүйл амьтны амьдрах орчин ба тархац нутгийг газрын зураг буулгахдаа, эрдэм шинжилгээний бүтээл, бидэнд олдсон судлаачдын ажиглалтын мэдээлэл дээр тулгуурлан зүйлийн тархацын загварыг тус тус боловсруулав. Зүйлийн тархацын загварыг эрдэм шинжилгээний бүтээл, олдсон мэдээлэл дээр тулгуурлан ГМС-ийн нарийвчлал багатай өгөгдлүүд ашиглан боловсруулсан тул тухайн зүйлийн амьдрах орчин, тархацын талаарх нарийвчлал багатай таамаглал хэлбэрийн илэрц гэж ойлгож болно.

2.2.1 Газрын экосистемийн ангилал

Газрын экосистемийн ангиллыг ургамалшил, геоморфологи, газрын хэв шинж дээр үндэслэн био-газарзүйн муж, газрын экосистемийн дараалал байдлаар боловсруулсан. Энэ ангиллаар экосистемийн 193 ялгаатай хэв шинжийг ялган тодорхойлов (Хүснэгт 1 ба 2). Landsat-5 TM хиймэл дагуулын зургуудыг ашиглан Говь, цөлийн бүсийн тусгай хамгаалалттай газар нутгийн ургамалшлын хэд хэдэн газрын зураг илэрц хэвлэгдсэн байдаг. (Wesche et al. 2005, von Wehrden and Wesche 2006, von Wehrden et al. 2006, 2009). Гэвч, манай судалгааны зорилго нь богино хугацаанд, судалгааны уудам газар нутгийг хамарсан амьдрах орчин, ургамалшлын зураг гаргахад чиглэгдсэн байсан тул Landsat-ийн зургийг дангаар нь хэрэглэх боломжгүй байв. Иймд бид хэд хэдэн багц мэдээлэл, аргачлалыг хослуулан хэрэглэсэн. Ургамлын бүлгэмдлийн хээрийн судалгаан дээр үндэслэн хиймэл дагуулаас авсан мэдээллийг (1 км нарийвчлалтай MODIS 13A3 NDVI; NASA 2012) ангилах замаар түгээмэл тархацтай хээр ба цөлийн экосистемийг газрын зураг буулгасан. Баянбүрд, сайр, нуур, тойром орчмын өтгөн шигүү ургамалшилтай өвөрмөц экосистемийг


газрын зурагт нарийвчлан оруулахын тулд өндөршлийн тоон загвар (Digital Elevation Model - DEM)-т үндэслэсэн усзүйн загварыг (78 метрийн нарийвлалтай) зайнаас тандан судлалын хэд хэдэн индекстэй (30 метрийн нарийвчлалтай Landsat-5 TM) хослуулан ашигласан болно.

Үе шат I: Био-газарзүйн муж

Био-газарзүйн муж нь бүс нутгийн уур амьсгал ба физик газарзүйн ерөнхий хэв шинж, тэдгээрээс хамааралтай зүйлийн ба генетик олон хэлбэрийг төлөөлнө. Судалгааны бүс нутагт тархсан ихэнх экосистемийг био-газарзүйн мужаар ялгах нь хүрээлэн буй орчны хэв шинж, зүйлийн бүрдлийн хувьд ялгаатай байдлыг төлөвлөлтөд тусгах ач холбогдолтой ба тэдгээрийг хамгаалах газар нутгийг сонгоход олон удаагийн давтамжтайгаар хамруулах боломж олгох давуу талтай.
Газарзүйн хувьд ийнхүү давтагдах байдлыг хангах нь цаг уурын гэнэтийн үзэгдэл, өвчин эсвэл харь зүйл зэрэг хөнөөлөөс болж биологийн олон янз байдал тодорхой нэг газар нутагт устаж болзошгүй байдлаас сэргийлэх ач холбогдолтой. Энэ судалгаанд био-газарзүйн мужийг тодорхойлж, газрын зурагт оруулахдаа ДБХС-ын Биологийн олон янз байдлын орхигдлын үнэлгээгээр (Chimed-Ochir et al. 2010) тодорхойлсон Дорнод говь, Говь-Алтайн нуруу, Алтайн-өвөр говь, Зүүнгарын говийн экологийн бүсүүдийг сонгосон (Зураг 1). Монгол орны баруун өмнөд хэсэгт байх Алтайн-өвөр говийн өвөрмөц био-газарзүйн онцлог (Н.Батсайхан хэвлүүлээгүй мэдээ)-ийг тусгах зорилгоор бид Востокова, Гунин (Vostokova and Gunin 2005) нарын тодорхойлсон Алтайн-өвөр говийн ландшафтын экологийн бүсэд үндэслэн Алтайн-өвөр говийн экологийн бүсийг дахин хуваасан болно.

Үе шат II: Газрын экосистем

Экосистем нь ерөнхийдөө шим (ургамал, амьтан) ба биет (хүрээлэн буй физик орчны шинж чанар, үйл явц) бүрэлдэхүүн хэсгүүдээр тодорхойлогддог бөгөөд физик орчны үйл явцаас хамаарч орон зай, тархацын хэв шинжээр янз бүр байдаг. Экосистемийг бид орон зайн хэмжээгээр хоёр түвшинд ангилж зураглав. Нэгдүгээрт, ерөнхий хэв шинж болох өндөршил, жилийн хур тунадас, ургамалшлаар тодорхойлогдох уудам орон зайд тархдаг хуурай хээр, цөлжүү хээр зэрэг түгээмэл экосистемийг газрын зурагт буулгасан юм. Хоёрдугаарт, газрын гадаргуу, гадаргын ус, хиймэл дагуулын зураг ашиглан харьцангуй нарийвчлалтай тогтоосон баянбүрд, хужир мараалаг хотгор (цайдам) зэрэг эрс ялгаатай өвөрмөц, жижиг хэмжээтэй экосистемийг ангилж, газрын зурагт оруулсан болно. Экосистем тус бүрээр ашигласан эх сурвалж, зураглалд оруулсан арга зүй (Хүснэгт 1), тархацыг био-газарзүйн бүсээр ялган тодорхойлсон (Хүснэгт 2 болон Зураг 7). Экосистем тус бүрийн экологийн тодорхойлолтыг Хавсралт 1-д хавсаргав.
Түгээмэл экосистем нь газар нутгийн ихэнх хэсгийг эзэлдэг бөгөөд уур амьсгал, хур тунадасны ерөнхий хэв шинжээр тодорхойлогдоно. Үүнд судалгааны бүтээлүүдэд тодорхойлж бичсэн цөл, хээржүү цөл, цөлжүү хээр, хуурай хээр, уулын хээр зэрэг экосистем хамарна (Hilbig 1995, von Werden et al. 2006, von Werden et al. 2007, Wesche et al. 2005). Говь, цөлийн бүсэд хур тунадас, ургамалшил, ургамлын бүлгэмдлийн орон зайн хэв шинж хоорондын шууд хамаарал



өндөр байдаг (von Wehrden and Wesche 2007). Уг хамаарлыг ашиглан, бид жилд унах хур тунадасны хэмжээ, газрын гадаргуу, өндөршлийн мэдээлэл болон von Werden et al. (2009) ба Wesche et al. (2005) нарын 1,145 удаагийн судалгааны ажиглалт дээр тулгуурлан илрүүлсэн илэрхийлэгч ургамлын бүлгэмдлийн мэдээллэлд үндэслэн хээрийн болон говь, цөлийн экосистемийн тархацыг ерөнхийд нь тодорхойлох загвар боловсруулан ашиглав. Үүнд, MODIS хиймэл дагуулын (NASA 2011a) зургаас авсан ургамал ургалтын үеийн (6-9 сар хүртэл) Ургамлын нормчилсон ялгаврын индекс (Normalized Difference Vegetation Index, NDVI)-ийн 11 жил (2000-2011)-ийн дундаж утгаар ургамалшлыг тодорхойлсон. Хур тунадасны хувьд, WorldClim-ийн 50 жилийн цувааны сарын дундаж утгыг ашиглав (Hijmans et al. 2005). Гаргаж авсан үр дүн (Зураг 5)-д тулгуурлан ургамлын нормчилсон ялгаврын индексийн босго утгуудыг тогтоох замаар түгээмэл ургамалшлын хэв шинжийн тархацыг дараах байдлаар тогтоон газрын зурагт буулгав. Үүнд:

- Сайргат цөл: ургамал огт үгүй эсвэл ганц нэг сөөгтэй.
- Хэт гандуу цөл: ирэлхийлэгч нь будраат хэв шинж.
- Жинхэнэ цөл: цөлийн үндсэн хэв шинжийн сөөг болон модлог ургамал болох заг, бударгана зонхилно.
- Хээржүү цөл: цөлийн сөөг ургамалтай холилдсон өвслөг ургамлын тохиолдоцтой хэв шинж.
- Хээр болон цөлийн ус, чийглэг газрын ургамалшил: Хялгана зонхилох ба цөлийн сөөг үгүй.




Гурван ялгаатай хээрийн экосистем (цөлжүү хээр, хуурай хээр, уулын хээр) ба ус, чийглэг газрын өтгөн шигүү ургамалтай газрыг илүү сайн ялгахын тулд тухайн жилийн ургамлын нормчилсон ялгаварын индекс, өндөршил, жилд унах хур тунадасны хэмжээ (Hijmans et al. 2005) зэрэг үзүүлэлт дээр тулгуурлан ангилах аргыг боловсруулаа.


Бид, таван ялгаатай өвөрмөц экосистемийг ангилж, газрын зурагт оруулсан аргыг дараах хэсэгт тайлбарлав. Эдгээр экосистем нь бүгд газрын доорх уснаас хамааралтай бөгөөд газрын доорх устай холбоотойгоор сийрэг, алаг цоог байдалтай тархана. Өвөрмөц экосистем нь хүн, мал, зэрлэг амьтны хувьд биологийн ач холбогдлын зэргээрээ харилцан адилгүй юм.

i. *Цайдам:* Гадаргын ус хураах ерөнхий зүй тогтлыг дагасан голын хуурай голдрил буюу сайр эсвэл газрын гадаргад ойр газрын доорх устай даац, хужир мараалаг хотгорууд үүнд хамаарна. Газрын доорх усны түвшин газрын гадаргууд ойр байх тул заган төгөл, хайлаас зэрэг модлог ургамлын зүйлээр онцлог байх бөгөөд газрын доорх усны сүлжээний онцлогоос хамаарч хөрсний физик шинж чанарууд ч янз бүр байна. Ургамалшил ба хөрсний үржил шим харьцангуй сайн, бүтцийн хувьд олон янз байдаг тул ийм газрууд нь олон зүйлийн жижиг хөхтөн, шувуу, мөлхөгчдийн амьдрах орчин болдог байна (Н.Батсайхан хэвлүүлээгүй мэдээ). Бид 3-секунд (78 м)-ийн нягтралтай өндөршлийн тоон загвар (Lehner et al. 2008)-ыг ашиглан тухайн газрын урсацын хуримтлал, тухайн газрын гадаргын хэлбэр дээр тулгуурласан урсацын сүлжээг ГМС-д оруулан газрын гадаргын загварыг боловсруулж, гол, сайран голдрил дагуух ус, чийглэг газрыг зурагт оруулаа.
ii. *Шигүү ургамалтай газар*: Шигүү ургасан сухай, тоорой, жигд, улиас, бургас, хайлаас, заг зэрэг мод болон сөөг ургамалтай газрууд үүнд хамаарна. Ийм газруудыг хиймэл дагуулын зургаас гаргаж авсан ургамалшлын индексийг ашиглан газрын зурагт оруулав. Нэгдүгээрт, бид судалгаанд хамрагдах газар нутгийг бүрэн хамруулан

Зураг 5: Ургамлын бүлгэмдлийн тархац ба ургамлын бүтээмжид үндэслэсэн ургамалшлын ангилал. Ургамлын бүлгэмдлийн тархац тэмдэглэгдсэн газар (n=1,145) болон ургамлын нормчлогдсон ялгаврын индекс (NDVI, MODIS дагуулаас авсан, 6-9-р сарын 2000-2012 оны хоорондох 11 жилийн дундаж) хоорондын хамааралд тулгуурласан ургамалшлын ерөнхий хэв шинжийн ангилал.



Зураг 6: Хөрсний засалттай ургамалшлын нийлбэр индекс. Хөрсний засалттай ургамалшлын нийлбэр индекс (SATVI)-ийг 30 метрийн ялгах чадвартай хиймэл дагуулын мэдээнээс (Landsat-5 TM) авсан ба энэ индекс нь хэт гандуу газрын ургамлын бүрхэвчийг тодорхойлоход зориулагдсан юм. Энэ индексийг бид говь, цөлийн баянбүрд болон газрын гадаргад ойр орших газрын доорх усаар тэжээгдэн ургадаг өвөрмөц, нягт шигүү ургамалшлын тархац, байршлыг зураглахад ашигласан.





Landsat-5 TM хиймэл дагуулаас авсан 54 дэлхэц зургийг нэгтгэн боловсруулав (NASA 2011b). Эдгээр дэлхэц зургуудыг 2011 оны 6-р сарын 15-наас 9-р сарын 28-ны хооронд авчээ. 2010 онд авсан 6 дэлхэц зургийн хувьд эдгээрийн чанар сайн байсан тул ашиглав. Бид боловсруулалтын өмнөх үе шатанд агаар мандлын нөлөөг засах алгоритм, хувиргалтын алгоритм (Tasseled Cap Transformation коеффициент; ERDAS 1999), хөрсний засалттай ургамалшлын нийлбэр индекс (Soil Adjusted Total Vegetation Index, SATVI; Marsett et al 2006) ашиглан хиймэл дагуулын зургуудад урьдчилан боловсруулалт хийж эмхэтгэсэн. Хуурай гандуу нутгийн ургамлын биомассыг тооцоолохын тулд хөрсний засалттай ургамалшлын нийлбэр индексийг ашигладаг. Энэ индексээр хуурай гандуу нутагт байх өтгөн шигүү ургамалтай газар эрс ялгагдахуйц их утга үзүүлдэг байна (Зураг 6). Хөрсний засалттай ургамалшлын нийлбэр индексийн утга их байгаа газрыг бид шигүү ургамалтай газар гэж үзэв. Эцэст нь, гаргаж авсан үр дүнг усны эх булаг эсвэл усны сүлжээгээр нь a) сайр ба цайдмын (дээр тайлбарласан), b) булаг, шандны (доор тайлбарласан) голдрил дагуу тархсан өвөрмөц экосистем гэж ялган ангилав.

iii. *Тойром шал:* Дээр дурьдсан 2011 оны Landsat-5 TM хиймэл дагуулын мэдээг ашиглан устай газруудын байршил, хүрээ хязгаарыг тоон хэлбэрт оруулав. Хувиргалтын алгоритм (Tasseled Cap Transformation) нь 3 сувгийн зураг гаргадаг бөгөөд эдгээрийг халцгай газар, ус, ургамалтай газрыг илүү нарийвчлалтай ялгахад ашигласан. Энэ аргаар боловсруулсан зураг нь ландшафтын хэв шинжийг ангилах, устай газруудыг тоон хэлбэрт оруулахад чухал ач холбогдолтой байв. Эдгээр хувиргасан зургуудыг ашиглан 1:200,000 масштаб хэмжээтэй 1,200 гаруй усан мандалтай газрыг тоон хэлбэрт шилжүүлэв. Хур тунадасны хэмжээ харьцангуй их байсан 2011 оны зун маш олон тойром шал устай байсан нь Landsat хиймэл дагуулын зургт илүү тод харагдаж байсан.

iv. *Тарамцаг элс:* Томоохон манхан элстэй газрыг 1:200,000 масштабтай байрзүйн зурагнаас тоон хэлбэрт шилжүүлсэн. Манхан элсний усны өвөрмөц сүлжээ нь ургамал, амьтны зүйлийн баялаг бүрдэл, даац болон чийглэг нугархуу амьдрах орчинг бүрдүүлдэг.

v. *Уулын хөндий*: Газрын гадаргын ангиллаар (доор тайлбарласан) хөндийн ёроол хэсэг, түгээмэл хэлбэртэй экосистемийн ангиллаар (дээр тайлбарласан) уулын хээр эсвэл атираа нугачаа ихтэй уулын ургамалшлаар нь зургт оруулсан газрууд.

Үе шат III: Газрын гадаргын хэв шинж

Судалгааны бүс нутгийн 80 орчим хувьд түгээмэл экосистемийн 5 ялгаатай хэв шинж (хэт гандуу цөл, жинхэнэ цөл, хээржүү цөл, цөлжүү хээр, хуурай хээр) тархах ба газрын гадаргын хэв шинж, амьдрах орчныг сүйтгэх үйл явц, сукцессийн орчлоор бий болсон өөр хоорондоо ялгаатай, алаг цоог ургамлын бүлгэмдлүүдээс тогтдог. Эдгээр түгээмэл экосистемийн ургамлын бүлгэмдэл нь их төлөв газрын гадаргын орчны ялгаанаас хамааралтай илэрдэг. Экологи, хүрээлэн буй орчин, генетик олон янз байдлыг харуулахын тулд хээрийн экосистемийн ялгаатай хэв шинжийг газрын гадаргын хэв шинжид үндэслэн ангилав. Газрын гадаргын атираат хэлбэршил (Sappington et al. 2007), нарны тусгалын эрчим (Rich et al. 1995) болон газрын гадаргын хөрсний чийгшлийн индекс (Moore et al. 1991) зэргийг багцалсан ангилал (кластер анализ)-ын аргаар нэгтгэн газрын гадаргын хэв шинжийг ялган тодорхойлж газрын зургт оруулсан (Хүснэгт 2, Зураг 8).

Хүснэгт 1: Газрын экосистемийн ангилал: Мэдээллийн эх сурвалж, зураглал хийсэн аргачлал. Экосистемийн хэв шинжийг (i) био-газарзүйн муж, (ii) ургамалшлаар ангилсан экосистем, (iii) газрын гадаргын хэв шинжээр тус тус ангилсан. Үүний үр дүнд экосистемийн 193 ялгаатай хэв шинжийг ялгасан юм.

i. Био-газарзүйн муж (Chimed-Ochir et al. 2010)

Зүүнгарын Говь
Говь-Алтай
Өмнөд Говь
Дорнод Говь
Алтайн өвөр Говь - Н.Батсайханы зөвлөмжөөр Востокова Е.А. ба Гунин П.Д. (2005)-аас тоон хэлбэрт оруулсан.

ii. Экоситемийн хэв шинж

Түгээмэл экосистем нь уур амьсгал, хур тунадасны ерөнхий хэв шинжээр тодорхойлогдоно.

Сайргат цөл (хамада) Хэт гандуу цөл * Жинхэнэ цөл * Хээржүү цөл * Цөлжүү хээр * Хуурай хээр * Уулын хээр Хэц уулс	• Ургамалшлын хэв шинжид тулгуурлан Ургамлын нормчилсон ялгаврын индексийг (NDVI) ангилахын тулд ургамлын бүлгэмдлийн ажиглалтын 1145 мэдээг ашигласан (Wehrden et al. 2009, Wesche et al. 2005). • Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI): Ургалтын үеийн (6-р сараас-9-р сарын хооронд) 2000-2011 оны хоорондох ургамлын биомассыг тооцоолсон хиймэл дагуулын мэдээ (1 км нарийвчлалтай) (MODIS 13A3, NASA 2012). • Жилийн хур тунадас (50 жилийн Hijmans et al. 2005)-ны дундаж утга.

Өвөрмөц экосистем нь хөрсний чийгшил, гадаргын урсац, бичил уур амьсгал зэрэг нарийвчлалтай хэв шинжээр тодорхойлогдно.

Цайдам: Гадаргын урсацын ерөнхий хэв шинжийг дагасан, гүний ус ойр, сайр ба хужир мараалаг хотгор	
Жижиг сав газар (ус хураах талбай < 1,000 км^2) Томоохон сав газар (ус хураах талбай> 1,000 км^2)	• 3 секундын нягтралтай Өндрийн тоон загвар (DEM)-аар гаргасан газрын гадаргын загвар
Шигүү ургамалтай газар: Ихэвчлэн баянбүрдийн орчимд байх сухай, бургас, тоорой, жигд, улиас, хайлаас, заг зэрэг зүйлийн мод болон бутлаг ургамал шигүү ургасан газар.	
Шүүрлийн илрэц: булаг, шанд, даац Голдрил орчим: Чийглэг нугажуу газар	• Landsat 5 TM дагуулын зургаас ялгасан Хөрсний засалттай ургамалшлын нийлбэр индекс (SATVI). 2010, 2011 онуудын 6-9-р сарууд.
Тойром шал	• Landsat 5 TM дагуулын зурагнаас тоон хэлбэрт хөрвүүлсэн.
Тарамцаг элс	• 1:200,000 масштабтай байрзүйн зургаас тоон хэлбэрт хөрвүүлсэн.
Уулын хөндий	

iii. Газрын гадаргын хэв шинж нь хөрсний чийгшил, бичил уур амьсгалын хэв шинжээр тодорхойлогдох ургамлын бүлгэмдлийн ялгааг нарийвчлалтай тогтоох боломж олгоно. Эдгээрийг түгээмэл тархацтай экосистемийн 5 хэв шинжийг дотор нь ялгахад ашигласан (* дээрх тайлбарыг үзнэ үү).

Хад чулуутай уулын ар
Хад чулуутай уулын энгэр
Бэсрэг уулын ар
Бэсрэг уулын энгэр
Ухаа толгод, тэгш өндөрлөг
Нам дор тэгш тал
Хотгор
Хөндийн ёроол, сайр


78 м-ийн ялгах чадвартай өндрийн тоон загвараас гаргаж авсан топографын 3 загвараас кластер анализ ашиглан зураглал хийсэн:

- Газрын гадаргын чийгшлийн индекс (CTI; Moore et al. 1991)
- Нарны тусгал (SolarFlux; Rich et al. 1995)
- Гадаргын атираа, нугачаа (VRM; Sappington et al. 2007)


Хүснэгт 2: Газрын экосистемийн ангилал: тархацын цар хүрээ, талбай.
Энэ хүснэгтэд судалгаанд хамрагдсан био-газарзүйн мужаар тохиолдох экосистемийн ялгаатай хэв шинжийн эзлэх талбайн цар хүрээг үзүүлэв (Chimed-Ochir et al. 2010).

	Судалгаанд хамрагдсан талбай	Зүүнгарын Говь		Өмнөд Говь		Алтайн өвөр Говь		Говь-Алтай		Дорнод Говь	
	км^2	км^2	%	км^2	%	км^2	%	км^2	%	км^2	%
Түгээмэл хэв шинж:											
Сайргат цөл	2,909	201	1	161	0.2	2,451	5	95	0.1		
Хэт гандуу цөл *	19,931	803	3	4,749	5	13,332	25	823	1	224	0.1
Жинхэнэ цөл *	50,427	2,919	10	22,306	22	18,147	34	5,110	6	1,943	1
Хээржүү цөл *	176,610	13,522	48	57,254	56	14,302	27	27,714	33	63,816	26
Цөлжүү хээр *	128,654	5,691	20	5,428	5	697	1	22,599	27	94,238	38
Хуурай хээр *	57,186							24	0.0	57,163	23
Уулын хээр	13,057	495	2	89	0.1	3	0.0	12,470	15		
Хэц уулс	10,803	600	2	375	0.4	18	0.0	9,810	12		
Өвөрмөц экосистемийн хэв шинж:											
Хужир мараалаг жижиг хотгор	23,524	1,018	4	5,492	5	2,811	5	2,066	2	12,138	5
Хужир мараалаг уудам хотгор	9,145	1,114	4	1,459	1	703	1	653	1	5,216	2
Ургамлын арви ихтэй-чийглэг нугажуу газар	1,024	19	0.1	394	0.4	94	0.2	206	0.2	311	0.1
Шигүү ургамалтай сайр, садарга	6,913	1,118	4	739	1	12	0	866	1	4,178	2
Түр урсацтай голдрил	323	7	0.0	21	0.0	3	0.0	64	0.1	228	0.1
Тарамцаг элс	11,953	373	1	3,147	3	90	0.2	689	1	7,654	3
Уулын хөндий	1,104	38	0.1	5	0.0			1,062	1		
Нийт талбай	513,544	27,917	100	101,619	100	52,664	100	84,249	100	247,109	100
Судалгаанд хамрагдсан талбайд эзлэх хувь	100%	5%		20%		10%		16%		48%	


Зураг 7а: Газрын экосистемийн ангилал: судалгааны нутгийн баруун хэсэг.
Ангилал, зураглалын аргазүй болон өгөгдлийн эхийг 2.2.1-р бүлэгт тодорхойлсон. Газрын экосистемийн ангиллыг Хавсралт 1-д үзүүлсэн болно.




Зураг 7б: Газрын экосистемийн ангилал: судалгааны нутгийн зүүн хэсэг. Ангилал, зураглалын аргазүй болон өгөгдлийн эхийг 2.2.1-р бүлэгт тодорхойлсон. Газрын экосистемийн ангиллыг Хавсралт 1-д үзүүлсэн болно.



Зураг 7в: Газрын экосистемийн ангилал – Өвөрмөц экосистемийг тодруулж харуулав.



Зураг 8: Газрын гадаргын хэв шинж. Өндрийн тоон загварын (DEM) топографын гурван индексийг ангилах замаар гаргасан. Үүний үр дүнд говь, цөлийн бүсэд гадаргын хэлбэрийн 8 хэв шинжийг тодорхойлж зураглал хийсэн. Бид үүнийг 1) түгээмэл экосистемийг тогтоох ба 2) сонгосон төлөөлөл зүйлийн хувьд тэдний амьдрах орчны тархацыг загварчилахад ашигласан.



2.2.2 Хамгааллын төлөөлөл зүйл

Биологийн олон янз байдлын нарийн шүүлтүүр буюу ховор, ховордсон зүйлийг хамгаалах, тархацыг тогтоохын тулд бүс нутгийн улаан дансанд (Gombobataar et al. 2012, Clark et al. 2006, Terbish et al. 2006) ховордлын зэрэглэлээр эрэмблэгдэж бүртгэгдсэн 33 зүйл хөхтөн, мөлхөгч ба хоёр нутагтан, шувуудын амьдрах орчны тархацын загварыг ГМС дээр боловсруулаа (Хүснэгт 3). Ихэнх зүйлийн амьдрах орчны тархацын загварыг судалгааны бүтээлүүдэд тодорхойлсон амьдрах орчны тодорхойлолт, экосистемийн ангилал, газрын гадаргын хэв шинжийн ангилал дээр тулгуурлан таамаг буюу дедуктив аргаар боловсруулсан. Амьдрах орчны тархацын 3 загварыг хээрийн судалгааны ажиглалт, амьдрах орчны сонголт дээр тулгуурласан бодит буюу индуктив (өгөгдөл дээр тулгуурласан статистик) арга ашиглан боловсруулав (Хавсралт 3).

Судалгааны ажиглалтын мэдээллийг дараах эх сурвалжуудаас нэгтгэн авав. Үүнд:

- Хоёр нутагтан, хэвлээр явагчид: МУИС (доктор Х.Тэрбиш, Н.Батсайхан)
- Хөхтөн амьтан (том): ШУА (Г.Цогтжаргал, доктор Яа.Адъяа, доктор Б. Мөнхцог, доктор Б.Лхагвасүрэн, Яад.Адьяа)
- Хөхтөн амьтан (жижиг): МУИС (Н. Батсайхан):
- Ургамал: доктор Д.Суран (МУИС), доктор Д.Зүмбэрэлмаа (ШУА), доктор Д.Ариунгэрэл (Mercy Corps)

Үүнээс гадна, тухайн амьтны зүйлийн шүтдэг амьдрах орчин, тархацын тухай мэдээллийг эрдэм шинжилгээний бүтээлээс авсан болно. Монгол орны жижиг хөхтөн, мөлхөгчид, шувуудын зүйлийн амьдрах орчны талаар хэвлэгдсэн судалгааны ажлууд харьцангуй бага байдаг тул бид доктор Х.Тэрбиш (хоёр нутагтан, мөлхөгчид), доктор Н.Цэвээнмядаг (шувуу), Н.Батсайхан, Г.Цогтжаргал (хөхтөн) нарт хандан тухайн ангилал зүйн бүлгийн экологи, амьдрах орчны талаарх тойм дүгнэлтийг бичүүлж авав.

2.3 ТӨЛӨӨЛҮҮЛЭН ХАМГААЛАХ ЗОРИЛТ

Хамгаалах шаардлагатай газрыг тогтоох эхний алхам нь төлөөлүүлэн хамгаалах зорилтын хэмжээг тогтоох асуудал байдаг. Төлөөлүүлэн хамгаалах зорилтыг тоо хэмжээгээр илэрхийлэх нь төлөөллийг хэмжих, хамгаалах шаардлагатай газрыг төлөвлөх, өөрчлөн сайжруулах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд уян хатан, ил тод байдлыг бий болгодог (Carwardine*et al.*, 2009). Экосистемийн хувьд төлөөлүүлэн хамгаалах зорилтыг 30% байхаар тогтоосон нь Монгол улсын Засгийн газрын нийт нутаг дэвсгэрийн 30 хүртлэх хувийг хамгаалах зорилт дээр үндэслэсэн (Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгуудын мастер төлөвлөгөө 1998, УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоол).



Хүснэгт 3: Сонгосон төлөөлөл зүйл. Устаж болзошгүй болон ховордсон зүйлийн тархац, мөн биологийн олон янз байдлын нарийн шүлтүүрийн бүрдэл хэсгийг таамаглахын тулд бүс нутгийн улаан дансны цувралд (Gombobaatar et al. 2011. Terbish et al 2006.) үндэслэн доор жагсаасан 33 зүйл амьтны амьдрах орчны тархацын загварыг ГМС-д оруулан боловсруулав.

Шинжлэх ухааны нэр	Монгол түгээмэл нэр	Бүс нутгийн ховордлын зэрэглэл	Дэлхийн ховордлын зэрэглэл
Хөхтөн амьтан (19 зүйл)			
Жижиг хөхтөн (Мэрэгчдийн баг; 11 зүйл)			
Spermophilus alashanicus	Гозоорой зурам	EN	LC
Dryomys nitedula	Ойн унтаахай	DD	NT
Allactaga bullata	Говийн алгадаага	DD	NT
Allactaga elater	Давжаа алгадаага	EN	LC
Cardiocranius paradoxus	Таван хуруут атигдаахай	DD	VU
Euchoreutes naso	Соотон алгадаахай	VU	EN
Salpingotus crassicauda	Өөхөн-сүүлт атигдаахай	DD	VU
Salpingotus kozlovi	Козловын атигдаахай	DD	NT
Stylodipus sungorus	Зүүнгар даахай	EN	EN
Cricetulus migratorius	Бордуу шишүүхэй	DD	NT
Meriones tamariscinus	Шаргал чүчүүл	EN	LC
Махан идэшт амьтан (Махчдын төрөл; 2 зүйл)			
Panthera uncia	Ирвэс	EN	EN
Ursus arctos gobiensis	Мазаалай	EN	CR
Туруутан (Туруутан; 6 зүйл)			
Equus hemionus	Хулан	EN	VU
Camelus bactrianus ferus	Хавтгай	EN	CR
Gazella subgutturosa	Цагаан зээр	VU	VU
Procapra gutturosa	Хар сүүлт зээр	EN	LC
Ovis ammon	Аргал	EN	VU
Capra sibirica	Янгир	NT	LC
Хоёр нутагтан ба мөлхөгчид (7 зүйл)			
Bufo pewzowi	Ногоон бах	VU	LC
Cyrtopodion elongatus	Говийн махир хуруут гүрвэл	VU	NE
Teratoscincus przewalskii	Нохой гүрвэл	NT	NE
Laudakia stoliczkana	Замба гүрвэл	NT	NE
Eryx tataricus	Тэмээн сүүл могой	NT	NE
Coluber spinalis	Нарийн могой	NT	NE
Шувуу (8 зүйл)			
Chlamydotis undulata	Жороо тоодог	VU	
Ciracaetus gallicus	Могойч бүргэд	EN	
Falco cherrug	Идлэг шонхор	VU	
Gypaetus barbatus	Ёл	VU	
Passer ammodendri	Загийн бор шувуу	NT	
Podoces hendersoni	Хулан жороо	VU	
Tetraogallus altaicus	Алтайн хойлог	NT	
Aegypius monachus	Нөмрөг тас		NT

Устаж байгаа (Critically Endangered-CR), Устаж болзошгүй (Endangered – EN), Эмзэг (Vulnerable – VU), Ховордож болзошгүй (Near Threatened – NT), Анхааралд өртөхөөргүй (Least Concern – LC), Мэдээлэл дутмаг (Data Deficient – DD), Үнэлгээ хийгээгүй (Not Evaluated – NE).




Дэлхийн бусад экологийн бүс нутгийн үнэлгээнд ерөнхий шүүлтүүрийн түүхэн тархац нутгийн 30 хувийг хамгаалах зорилт дэвшүүлсэн байдаг (Tear et al. 2005, Groves 2003) бөгөөд энэ нь арлын био-газарзүй, "арал маягийн амьдрах орчин"—ны (MacArthur & Wilson, 1967; Dobson, 1996; Groves 2003) онол дээр тулгуурласан амьдрах орчин - зүйлийн харилцан хамаарлын онолоос үүдэлтэй. Амьдрах орчин устах нь аажмаар тухайн амьдрах орчныг шүтэн амьдардаг зүйл устахад хүргэнэ. Dobson (1996)-ны боловсруулсан зүйл ба газар нутгийн харилцан хамаарлын (Зураг 9 -д үзүүлсэн) онол ёсоор, ерөнхий шүүлтүүр болох экосистемийн түүхэн тархацын 10-30 хувийг хамгаалж чадваас тухайн газарт оршиж буй зүйлийн 55-85 хувийг хамгаалах боломжтой. Хуурай гандуу нутагт ургамлын бүтээмж бага, амьдрах орчны өөрчлөлт ихтэй байдгаас зэрлэг амьтны зүйлийн амьдрах орчны тархацын хэмжээ харилцан адилгүй байх тул дээрх онолын үзэл баримтлал бүрэн нийцэхгүй байж болно.
Мэдлэг, мэдээлэл дутмаг нөхцөлд хамгааллын зорилтыг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг. Цөөн хэдэн амьтны зүйлийн хувьд удаан хугацааны туршид оршин тогтноход шаардагатай амьдрах орчны тархац, нийт популяцийн хэмжээ, популяцийн нягтшлын нарийвчилсан судалгаа хийгдсэн байдаг. Иймээс төлөөлүүлэн хамгаалах зорилт нь зүйл, экологийн үйл явцыг удаан хугацаагаар оршин тогтноход шаардлагатай популяци, тэдгээрийн тархацыг хамгаалах эхний таамаг юм. Төлөөлүүлэн хамгаалах зорилтыг дасан зохицох менежментийн суурь, таамаглал гэж үзэх нь зүйтэй. Бид хамгаалах шаардлагатай газрыг сонгохдоо одоогийн болон ирээдүйн болзошгүй аюул уршигийн нөлөөлөлд тэсвэрлэх чадварыг хангахын тулд хүрээлэн буй орчин, амьдрах орчны олон янз байдлыг хангалттай давтагдалтай байдлаар төлөөлүүлэхийг эрмэлзлээ. Төлөөлүүлэн хамгаалах зорилтыг талбайн хэмжээ (км^2) ба экосистемийн төрлөөр ялган жагсаав (Хавсралт 2а).

Бид хамгаалах шаардлагатай газрыг тогтоох болон сонгох явцад зүйлийн тархацын загварчлалыг шууд ашиглаагүй болно. Харин, хамгаалах шаардлагатай газрыг тогтоосны дараа сонгосон зүйл тус бүрийн амьдрах орчны төлөөлөл хэрхэн хамрагдсаныг нягталж үзсэн. Хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтооход хамгааллын төлөөлөл зүйл тус бүрээр төлөөлүүлэн хамгаалах зорилт дэвшүүлэх нь хүндрэлтэй байдаг. Учир нь: 1) хамгааллын төлөөлөл зүйлийн тархацын загвар нь хязгаарлагдмал мэдлэг, мэдээлэл дээр тулгуурласан төдийгүй хээрийн судалгаагаар газар дээр нь шалгаагүй байдаг, 2) зүйлийн хувьд тодорхой зорилт тавихын тулд популяцийн амьдрах чадварын талаар сайн ойлголттой байх ёстой, 3) устаж байгаа болон ховордсон зүйлийн хувьд байгаль хамгааллын практик зорилт нь одоо оршин байгаа популяцийн тархацыг хамгаалах эсвэл нэмэгдүүлэхэд чиглэгддэг.

Өмнө өгүүлснээр, газар нутгийн 30 хувийг хамгаалах зорилтыг экосистем болон амьдрах орчны ерөнхий хэв шинжийг (ерөнхий шүүлтүүрийн бүрдэл хэсэг) хувьд хамгаалах зорилт болгон хэрэглэх нь түгээмэл. Газар нутгийн 30 хувийг хамгаалах зорилтыг устаж байгаа, устаж болзошгүй ховордлын зэрэглэлтэй зүйлийн тухайд хэрэглэх бололцоогүй. Учир нь, эдгээр ховордлын зэрэглэлтэй зүйлийн тархацын талаарх мэдээлэл дутмаг бөгөөд ялангуяа, жижиг хөхтөн, мөлхөгчид, хоёр нутагтны талаарх мэдээлэл хомс байдаг. Зүйлийн тархацын загвар нь устаж байгаа, устаж болзошгүй зэрэглэлд хамрагдсан зүйлийн хамгийн сүүлчийн амьдрах орчныг тогтоох найдвартай мэдээлэл болж чадахгүй тул хэрэглэгчид болгоомжтой ашиглах нь зүйтэй. Гэсэн хэдий ч, зүйлийн тархацын загвар нь тусгай хамгаалалттай газар нутаг болон хамгаалах

Зураг 9: Зүйл болон амьдрах орчны хамаарлын муруй: Амьдрах орчны талбай болон зүйлийн тоо хэмжээний хоорондын хамаарал. Dobson (1996)-ны загвар



шаардлагатай газарт зүйлийн амьдрах орчин хэр хэмжээгээр хамрагдсан болохыг тооцоолох, цаашдын судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох зэрэгт ач холбогдолтой (Хавсралт 2б). Ялангуяа, хулан, цагаан зээр, хар сүүлт зээр, аргаль, ирвэс зэрэг уудам орон зайд тархан амьдардаг зүйлийн тухайд чухал идээшил амьдрах орчин нь зөвхөн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан амьдрах орчноор хязгаарлагддаггүй.

2.4 НӨЛӨӨЛЛИЙН ИНДЕКС

Амьдрах орчны экологийн бүрэн бүтэн байдал буюу түүхэн эсвэл байгалийн нөхцөл байдлаас хэрхэн өөрчлөгдсөнийг илэрхийлэх шууд бус хэмжүүр нь хүний үйл ажиллагааны хуримтлагдах нөлөөлөл юм. Бид мэдээллийн олдоц дээр тулгуурлан одоогийн хүний үйл ажиллагааны нөлөөллийн хэлбэр, эх үүсвэрийг ГМС дээр тооцоолох замаар нөлөөллийн индексийг боловсруулаа. Боловсруулсан нөлөөллийн индексийг дараах дүн шинжилгээнд ашиглав: Үүнд: 1) хамгаалах шаардлагатай газар нутаг сонгоход экологийн харьцангуй сайн нөхцөлд оршиж байгаа экосистемийн хэв шинжийг хамруулах, 2) зүйлийн тархацын загварыг ангилахын зэрэгцээ доройтсон байж болзошгүй амьдрах орчныг илрүүлэх, 3) судалгаанд хамрагдсан бүс нутгийн хэмжээнд экосистемийн хэв шинж, амьдрах орчинд үзүүлэх одоогийн ба ирээдүйд учруулж болзошгүй (уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөл дээр үндэслэн) хуримтлагдах нөлөөлөлд дүн шинжилгээ хийх зэргийг дурьдаж болно. Эдгээр бүрдэл хэсгийг доор тайлбарлав (Хүснэгт 4, Зураг 10 болон Зураг 11-ийг үзнэ үү).

- Хүн ам төвлөрсөн суурин газар ба түүний орчмын нөлөөнд өртсөн газар нутаг: Аймгийн төв, сумын төв, хилийн боомт орчмын газар нутаг нь ихэвчлэн бэлчээрийн талхигдал (Fernandez-Gimenez 2001), ан агнуурын дарамтад өртсөн (Wingard and Zahler 2006) байхын зэрэгцээ зэрлэг амьтад нохойд хөөгдөх, ноцуулах нь (Young et al. 2012) түгээмэл тохиолддог.
- Автозамын сүлжээний нягтрал, ачаалал ба төмөр зам: Автозам нь зэрлэг амьтны амьдрах орчин, амьдралын хэв маягт олон хэлбэрээр сөрөг үр нөлөө үзүүлдэг (Trombulak and Frissell 2000). Говийн бүс нутагт ихэнх автозам нь шороон зам бөгөөд байнга өөрчлөгдөж байдаг. Зарим замыг бусдаас илүү эрчимтэй ашигладаг тул хэд хэдэн замыг ачаалал ихтэй зам гэж тодорхойлсон. Бид автозамыг өмнө хэвлэгдсэн газрын зураг, Монголын автозамын атлас (Monsudar 2009)-ыг ашиглан тоон хэлбэрт оруулсан болно. Үүний үр дүнд хэдийгээр бүрэн бус боловч, байнга ашиглагддаг замыг ГМС-д оруулаа.
- Уул уурхай, түүнийг дагалдсан дэд бүтэц: Уул уурхай, түүнийг дагалдсан дэд бүтэц нь тухайн газраар хязгаарлагдахгүй, ургамалшил, газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл (уурхайн нүх, дэд бүтэц гэх мэт) нь уудам орон зайд тархдаг. Уул



уурхайн үйл ажиллагааны зориулалтаар гүний ус татсанаар тухайн газар нутгийн газрын гадаргад ойр газрын доорх усны түвшин доошилж, энэ үзэгдэл нь улмаар газрын доорх усны сүлжээнээс хамаарч илүү уудам газар нутгийг ч хамарч болно (Walton 2010). Тухайлбал, худаг ус, булаг шанд, ургамлын бүтээмжид нөлөөлж, ус тэжээлийн хангамжийг бууруулж, баянбүрд, хайлааст шугуй, заган төгөл зэрэг газрын доорх устай шүтэлцээтэй экосистемд нөлөөлдөг. Уул уурхайн үйл ажиллагаанд ашиглаж байгаа авто зам нь их хэмжээний тоос дэгдээх ба энэ нь алс тархаж, улмаар ургамлын бүтээмжид нөлөөлдөг (Walton 2010). Тоосжилтын нөлөө, шилжилт хөдөлгөөний талаар хийгдсэн маш олон судалгааны тухай сонирхож болно (http://www.roaddustinstitute.org/; http://www.dirtandgravel.psu.edu/ Research/research.html).

- Мал бэлчээрлэлтийн эрчим: Малын бэлчээр ашиглалт нь ургамлын зүйлийн бүрдэл (Fernandez-Gimenez and Allen-Diaz 2001) болон зэрлэг амьтны амьдрах орчны хэвийн нөхцөл, чанарт нөлөөлдөг. Мал зэрэгцэн оршиж буй зэрлэг амьтантай өрсөлдөж тэднийг амьдрах орчноос нь шахаж (Wingard et al. 2011, Yoshihara et al. 2008, Campos-Arceiz et al. 2004), эсвэл зэрлэг амьтны сорчлон иддэг ургамлын зүйлийн тоог буруулах зэргээр нөлөөлдөг (Gana Wingard хэвлүүлээгүй мэдээ). Olson нар (2011)-ын судалгаагаар цагаан зээр нь малчин айл орчмын газар нутгаас зайлсхийх ба хот айлын бөөгнөрөл нь цагаан зээрийн шилжилт хөдөлгөөнд саад учруулж, идээшил бэлчээртээ хүрэх боломжийг хязгаарладаг нь тогтоогджээ. Мөн малчин өрхийн нягтрал их газар, ойр орчимд нь цагаан зээрийн хууль бус агнуур (Wingard and Zahler 2006), гэрийн тэжээвэр нохойд бариулах, ноцуулах нь илүү түгээмэл тохиолддог болохыг судлаачид (Young et al. 2011, Buuveibaatar et al. 2009) тогтоожээ.




Бид хамгаалах шаардлагатай газар нутгийг сонгох явцад нэг талаас нөлөөлөлд бага өртсөн, экологийн харьцангуй сайн нөхцөлд байгаа газрыг оновчтой сонгох, нөгөө талаас мал олноор бэлчээдэг эдийн засгийн хувьд ач холбогдолтой, өрсөлдөхүйц газраас зайлхсийх шаардлагыг харгалзан үзэх зорилгоор нөлөөллийн индексийг ашигласан юм. Иймд нөлөөллийн индекс нь байгаль хамгаалах арга хэмжээг зардал багатай хэрэгжүүлэх ерөнхий арга гэж үзэж болно. Мөн зүйлийн тархацын загварыг нөлөөлөлд өртсөн байдал, амьтдын амьдрах орчин болж чадахааргүй газрууд, бэлчээрийн өрсөлдөөн болон бусад зөрчлийн хэлбэрийг ангилахад нөлөөллийн индексийг ашиглав. Судалгаанд хамрагдсан газар нутгийг нөлөөллийн зэргээр дараах гурван хэсэгт хуваах болох юм. Үүнд:

- Нөлөөлөл их (хуримтлагдах нөлөөллийн индексийн утга хамгийн их, судалгаанд хамрагдсан газар нутгийн 5 орчим хувь). Энэ зэрэглэлд хүн амын нягтрал ихтэй суурин газар (аймаг, сумын төв, хилийн боомт), үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, ачаалал ихтэй зам (төв зам, уул уурхайн тээврийн зам, төмөр зам), малчин айл өрх олноороо суурьшсан газар нутаг (3 км^2 нутагт нэгээс олон айл байх) болон эдгээрийн байршил давхцсан газар хамрагдаж байгаа юм.
- Нөлөөлөл дунд (судалгаанд хамрагдсан газар нутгийн 45 орчим хувь): Энэ зэрэглэлд суурин газраас 5 км түүнээс алс зайд байрлах малчин айл өрх, малын тоо харьцангуй олон, их нягтшилтай байх газар нутгийг хамруулав.
- Нөлөөлөл бага (судалгаанд хамрагдсан газар нутгийн үлдэх 50 хувь): Зам, дэд бүтэц бараг хөгжөөгүй, малчин айл өрхийн


байршил тархуу сийрэг (60 км^2 талбайд нэгээс цөөн хот айлын нягтшилтай) газар энэ зэрэглэлд хамарна.

Бид экосистем ба хамгааллын төлөөлөл зүйлийн амьдрах орчинд үзүүлж болох хуримтлагдах нөлөөллийг үнэлэхийн тулд экосистемийн хэв шинж, төлөөлөл зүйлийн тархацыг нөлөөллийн зэрэглэл тус бүрээр ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй давхцуулж үзсэн юм. (Хавсралт 4). Экосистемийн хэв шинжээс баянбүрд орчмын өтгөн шигүү ургамалшилтай төрөл нь хамгийн ихээр хуримтлагдах нөлөөлөлд өртсөн дүр зураг ажиглагдаж байна. Баянбүрд орчмын өтгөн шигүү ургамалшилтай хэмээн илэрсэн газар нутгаас 10-20 хүртлэх хувь нь нөлөөлөлд их өртсөн, харин 50 гаруй хувь нь нөлөөлөлд дунд зэрэг өртсөн дүр зураг илрэв. Хээрийн хэв шинжийн экосистем нь цөлийн экосистемтэй харьцуулахад харьцангуй илүү нөлөөлөлд өртсөн байна. Уулын хээр, хуурай хээр, цөлжүү хээрийн экосистем нь тус бүр 80%, 69%, 65% нөлөөлөлд их ба дунд зэрэг өртсөн ажээ.

Зураг 10: Нөлөөллийн индексийн хүчин зүйлс ба ГМС-н өгөгдөл.
Газарзүйн мэдээллийн системийн өгөгдөл болон нөлөөний хэлбэрт үндэслэн нөлөөллийн индексийг тооцоолсон.



Зураг 11: Нөлөөллийн индекс.



Хүснэгт 4. Нөлөөллийн индексийн тооцоо. Энд нөлөөллийн хүчин зүйл, тухайн мэдээллийн эх сурвалж, ГМС-ийн хэмжилтийн үзүүлэлт болон нөлөөллийн индексийн харгалзах утгыг үзүүлэв.

Төрөл Хүчин зүйл	Мэдээллийн эх сурвалж	ГМС–ийн хэмжилтийн үзүүлэлт
А. Хүн амын төвлөрөл		
1. Аймгийн төв	Суурин газрын газар ашиглалтын бүс - ГХГЗЗГ	Эвклидийн алслалт, 10 км радиустайгаар
2. Сумын төв	Суурин газрын газар ашиглалтын бүс - ГХГЗЗГ	Эвклидийн алслалт, 5 км радиустайгаар
3. Хийлийн боомтууд	Автозамын зургаас холболт хийсэн (масштаб 1:1)	Эвклидийн алслалт, 10 км радиустайгаар
4. Суурин газрын шөнийн гэрэлтэлт	Хиймэл дагуулын 2011 оны мэдээ	Эвклидийн алслалт, 5 км радиустайгаар
Б. Зам тээвэр		
5. Ердийн зам	Автозамын зургаас холболт хийсэн (1:1 М хэмжээтэй)	Нягтшил, 2.7 км тойрог хэлбэрийн шилжих нэгж талбай (2.7 km* radius moving window)
6. Улирлын чанартай зам	Автозамын зургаас холболт хийсэн (1:1 М хэмжээтэй)	Нягтшил, 2.7 км тойрог хэлбэрийн шилжих нэгж талбай (2.7 km* radius moving window)
7. Хурдны зам	Автозамын зургаас холболт хийсэн (1:1 М хэмжээтэй)	Нягтшил, 2.7 км тойрог хэлбэрийн шилжих нэгж талбай (2.7 km* radius moving window)
8. Уул уурхайн зам	Google Earth-ээс холболт хийсэн	Нягтшил, 2.7 км тойрог хэлбэрийн шилжих нэгж талбай (2.7 km* radius moving window)
9. Төмөр зам	ГХГЗЗГ	Нягтшил, 10 км тойрог хэлбэрийн шилжих нэгж талбай (10 km* radius moving window)
В. Уул уурхай		
10. Уул уурхайн дэд бүтэц	Google Earth-ээс холболт хийсэн	Нягтшил, 5 км тойрог хэлбэрийн шилжих нэгж талбай (5 km radius moving window)
11. Ашиглалтын тусгай зөвшөөрөл	ЭБЭХЯ 2012 он	Тусгай зөвшөөрлийн талбай
Г. Малын бэлчээр		
12. Малчин өрхийн зуслан	ГХГЗЗГ	Малчин өрхийн зулсангийн нягтшил, 10 км тойрог хэлбэрийн шилжих нэгж талбай (10 km* radius moving window)
13. Малчин өрхийн өвөлжөө	ГХГЗЗГ	Малчин өрхийн өвөлжөөний нягтшил, 10 км тойрог хэлбэрийн шилжих нэгж талбай (10 km* radius moving window)

Нөлөөллийн индексийн тооцоо:

i. дээрх хүчин зүйлүүдийг 0-1 утгатай байхаар дахин ангилал хийсэн.

ii. дахин ангилсан утгуудын нийлбэрээр нөлөөллийн төрлүүдийг тогтоосон.

iii. нөлөөллийн төрлүүдийг мөн 0-1 утгатай байхаар дахин ангилсан.

iv. дээрх 4 төрлийн нийлбэрээр нөлөөллийн индексийг тооцоолон гаргасан.

ГХГЗЗГ: Газрын харилцаа, Геодези зураг зүйн газар

* АНУ-ийн баруун бүсийн хээрийн уул уурхай болон эрчим хүчний дэд бүтэцийн хөгжлийн судгаагаар (Hebblewhite 2008) амьдрах орчинд үзүүлэх замын нөлөөлөл 2.7 – 3.7 км зайд буурдаг гэж тогтоосон байна.

2.5 ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хамгаалах шаардлагатай газар нутгийг сонгох ГМС-ийн боловсруулалт, дүн шинжилгээ хийхийн тулд судалгааны бүс нутгийг ижил дүрс (зургаан талт) болон хэмжээтэй (50 км^2) ойролцоогоор 10,550 орчим төлөвлөлтийн нэгжид хуваав. Төлөвлөлтийн нэгж тус бүрээр дараах утгыг өгсөн. Үүнд:

- Улсын тусгай хамгаалалттай газар, Тост уулын орон нутгийн тусгай хамгаалалттай газар, Шувуудад чухал газрын утгыг оруулах (IBAs) (2.1.3 хэсгийг харна уу).
- Төлөвлөлтийн нэгж тус бүрт нөлөөллийн индексийн утга өгөх.
- Экосистемийн хэв шинж бүрээр төлөвлөлтийн нэгжийн тоог (газрын хэмжээ буюу тоо) гаргах.

2.6 ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ГАЗРЫГ СОНГОХ

MAPKCAH нь байгаль орчны төлөвлөлт хийхэд зориулагдсан компьютерийн багц программ хангамж бөгөөд хамгаалах шаардлагатай газрыг тогтооход хэрэглэгчийн дэвшүүлсэн биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг төлөөлөн хамгаалах зорилтыг хамгийн оновчтой хувилбараар сонгохын зэрэгцээ, хэрэглэгчийн тогтоосон төлөвлөлтийн нэгжийн өртгийн утга хамгийн бага байхаар сонгох боломж олгодог (Ball & Possingham, 2000; Possingham, Ball & Andelman, 2000). MAPKCAH-ы өртгийн функц нь амьдрах орчин хоорондын холбоосыг хангахын тулд хил залгаа орших амьдрах орчныг сонгох хувилбартай. Өртгийн функцийн талаар Possingham (2000), Game & Grantham (2008) нар дэлгэрэнгүй тайлбарласан байдаг тул эдгээр бүтээлээс лавлан үзэж болно.

Бидний дүн шинжилгээнд 10,550 ширхэг зургаан талт төлөвлөлтийн нэгжийг авч үзлээ. Биологийн олон янз байдлын бүрдэл хэсэг нь экосистемийн 193 хэв шинжээс бүрдэнэ. Төлөвлөлтийн нэгжийн өртгийг төлөвлөлтийн нэгж дэх нөлөөллийн индексийн нийлбэрээр тооцов. Улсын тусгай хамгаалалттай газар, Тост уул орон нутгийн хамгаалалттай газар, Шувуудад чухал газрыг хамгаалах




шаардлагатай газар нутагт шууд хамруулсан бөгөөд экосистемийг төлөөлүүлэн хамгаалах зорилтыг биелүүлэхийн тулд төлөвлөлтийн нэгжийг нэмж өгөв. Үүний үндсэн дээр MAPKCAH программыг ашиглан экосистемийн төлөөлүүлэн хамгаалах зорилтод нийцсэн хамгаалах шаардлагатай газрыг тогтоосон. Мөн экологийн хэвийн нөхцөлд байгаа (нөлөөллийн индексийг ашиглан) газрын сонголт, түүний үр дүнг сайжруулахын тулд төлөвлөлтийн нэгжийг аль болох нэгдмэл, хил залгаа байх шаардлагыг анхаарч үзсэн юм (Зураг 12).

Марксан программ нь ялгаатай хэдэн үзүүлэлтийг (биологийн олон янз байдал, хамгаалах хувь хэмжээ, өртгийн индекс, газрын хилийн урт, жингийн коэффициент зэрэг) харгалзан боломжит олон хувилбарыг тооцоолдог ба үр дүнг нь “хамгийн шилдэг сонголт” буюу “сонголтын нийлбэр” болгон боловсруулдаг. MAPKCAH-ны сонголт бүр нь тусгай алгоритм ашиглан, төлөвлөлтийн нэгжийн өртөг ба хилийн урт хамгийн бага байх, зорилтод хамгийн бага зардлаар хүрэхээр тооцоолдог. “Хамгийн шилдэг сонголт” гэдэг нь бусад сонголтоос хамгийн бага нийлбэр утгатай сонголт байдаг. “Сонголтын нийлбэр” гэдэг нь олон удаагийн сонголтоор дахин давтагдан сонгогдож байгаа төлөвлөлтийн нэгжийн сонгогдох давтамжийн үзүүлэлт юм. Энэ хоёр хувилбар нь тухайн зорилтод хүрэхэд нэг нь нөгөөгөө харилцан нөхдөг чухал үзүүлэлт болдог. Ийнхүү хамгийн шилдэг сонголт нь төлөөлүүлэн хамгаалах зорилтыг хангаж чадах, хамгийн үр дүнтэй төлөвлөлтийн нэгжийн сонголт, тэдгээрийн нийлбэр нь төлөвлөлтийн нэгж тус бүрийн сонголтод оруулах хамгийн

үр дүнтэй хувь нэмрийг тооцох хэмжүүр болж байдагт оршино. Газар ашиглалтын байдал болон бусад мэдээлэл нэмэгдэхийн хэрээр хамгаалах шаардлагатай газар нутгийг шинэчлэн сайжруулж байх шаардлагатай тул сонголтын нийлбэр нь хамгаалах шаардлагатай газрын хувилбарыг тогтоох болон судалгаанд хамрагдсан газар нутгийн аль ч хэсгийн байгаль хамгааллын харьцангуй үнэ цэнийг тогтооход ашиглаж болох нэлээд ач холбогдолтой үзүүлэлт юм.

Зураг 12: Хамгаалах шаардлагатай газар нутгийн эхний хувилбар. Анхдагч байдлаар тогтоосон хамгаалах шаардлагатай газар нутаг: УТХГ, Тост Уул орон нутгийн тусгай хамгаалалттай газар, Шувуудад чухал газар (IBA) (2.1.3 хэсэг) болон экосистемийн бүх хэв шинжийн тархацын талбайн 30% хүртэл (2.2.1 хэсэг) тохиромжтой нөхцөл байдал (нөлөөллийн нэгж индекст оногдох байдлаар, 2.4 хэсэг) болон тэдгээрийн хамаарал (2.6 хэсэг).



2.7 БИОЛОГИЙН ҮНЭ ЦЭНИЙН ХЭМЖҮҮР


Сонголтын нийлбэрийг MARXCAN программын өгөгдлийн нэг багц болон хамгаалах зорилтын нэг багцаас гарган авдаг. Wilhere нар (2008) Марксан программ ашиглан хамгийн оновчтой сонголтыг хийхэд оруулах хувь нэмэр болон хамгаалах нэг зорилтоос үл хамаарах байдал дээр үндэслэн хамгаалах газрыг сонгох индекс боловсруулжээ. “Оновчтой байдал” хэмээх энэ арга тэгээс 100 хувь хүртэл хамгаалах зорилтын нийлбэр сонголтыг тооцоолдог. Оновчтой байдал нь хэдэн хувийг хамгаалах шаардлагтай вэ гэсэн зорилтоос үл хамааран судалгаанд хамрагдсан газар нутаг дах тухайн нэгж газрын хамгааллын харьцангуй үнэ цэнийн илэрхийлэл юм. Бид оновчтой байдлыг сонголтын нийлбэр байдлаар 10%, 20%, 30%, 40%, 50%, 60%, 70%, 80%, 90% гэсэн ялгаатай 9 түвшинд тооцоолж үзсэн (Зураг 13).

Оновчтой байдал нь ерөнхийдөө нөлөөллийн индекс болон Марксан программын өгөгдлийн функц тул “ховор байдал”-ыг шууд илэрхийлж чадахгүй. Иймээс, бид төлөвлөлтийн нэгж бүрийн хувьд тухайн газарт байх биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийн ховор эсвэл элбэг байгааг үндэслэн биологийн үнэ цэнийн хоёр дахь хэмжүүр болох “ховор байдал”-ыг боловсруулаа. “Ховор байдал”-ыг үнэлэхийн тулд тухайн нэг төлөвлөлтийн нэгж дэх тухайн нэг экосистемийн тохиолдоцыг нийт судалгааны нутагт хэр элбэг тархацтай байгаад үндэслэн харьцангуйгаар тогтоосон. Биологийн олон янз байдлын харьцангуй индексийн (Schill & Raber 2009) аргыг өөрчлөн боловсруулж, төлөвлөлтийн нэгж талбайн хэмжээний нөлөөллийг хасч, төлөвлөлтийн нэгж талбайн тархац болон үнэ цэнийн утгын хэлбэлзлийг стандартчлах замаар гүйцэтгэв. Тухайн төлөвлөлтийн нэгж тус бүр дэх экосистемийн ховор байдлыг гаргасны дараагаар төлөвлөлтийн нийт нэгжийн хэмжээнд эдгээр утгын нийлбэрийг ГМС дээр тооцох замаар “ховор байдал”-ыг тогтоосон. Үүний дараа, бид тухайн төлөвлөлтийн нэг нэгж дэх ховор байдлын үнэмлэхүй их утгыг сонгон авах замаар төлөвлөлтийн нэгжийг эрэмбэлсэн болно (Зураг 14).


Энэ үр дүнд нь бий болсон төлөвлөлтийн нэгжийн “ховор байдал”-ын зэрэглэл нь био-газарзүйн мужийн цар хүрээ ба өвөрмөц экосистемийн тархацаар тодорхойлогдоно. Тухайлбал, Зүүнгарын говийн бүс нь харьцангуй бага газар нутагт орших учраас Зүүнгарын говийн экосистем тархсан газар нутгийн хэмжээ нь судалгаанд хамрагдсан нийт газар нутагтай харьцуулбал маш бага орон зайг эзэлнэ. Иймд, Зүүнгарын говь дахь төлөвлөлтийн нэгжийн ховордлын утга их гарч байна. Үүнтэй нэгэн адилаар, өвөрмөц экосистемийн хамрах орон зайн хэмжээ нь бага тул баянбүрд орчмын ургамалшил, тойром шал, зэрэг бусад өвөрмөц экосистемийн хэв шинжийн хувьд “ховор байдал”-ын зэргийн утга их байна.

Төлөвлөлтийн нэгж тус бүрээр “оновчтой байдал” болон “ховор байдал” тус бүрт 0-ээс 1-ийн хоорондох утга өгч стандартчилаад хооронд нь нэмэх аргыг ашиглан биологийн үнэ цэнийн байдлыг тооцоолон гаргав. Энэхүү биологийн үнэ цэнийн индекс нь хамгаалах шаардлагатай газрыг тогтоох гол шалгуураас гадна уул уурхайн болон бусад хөгжлийн нөлөөллөөс зайлсхийх газрыг тогтоох үндэслэл болно.

Зураг 13: Оновчтой байдлын сонголт: Марксан программ ашиглан хамгийн үнэмлэхүй сонголтоор хамгаалах газрыг тогтоодог. “Оновчтой байдал” гэдэг нь хамгаалах нийт зорилтот түвшний 0-ээс 100 хувь хүртэлхээс (2.7 хэсгийг үзнэ үү) Марксан оновчтой сонголт юм.



Зураг 14: Ховор байдал: Экосистемийн хэв шинжийг хувьд хамгийн ховор тохиолдол бүхий төлөвлөлтийн нэгжүүд. Тухайн нэгж газарт тухайн экосистемийн хэв шинжийн тархцын талбайг нийт судалгаанд хамрагдсан газар нутагт харьцуулан жиших замаар тооцоолсон хэмжээг тохиолдоц гэж ойлгоно (2.7 хэсгийг үзнэ үү).



2.8 ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ГАЗАР НУТГИЙГ ТОГТООХ


Хамгаалах шаардлагатай газрууд болон уул уурхай, газрын тосны төлөвлөлтийн хооронд үүсч буй зөрчлийг бууруулахын тулд бид хамгаалах шаардлагатай газрын эхний хувилбарыг дараах байдлаар өөрчлөн засварласан юм. Эхний ээлжинд, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий газрууд болон хамгаалах шаардлагатай газрын хооронд давхцал, зөрчил үүсч буй газруудыг тогтоосон (Зураг 16 болон Зураг 17-г үзнэ үү). Давхцал илэрсэн газар нутгийн хэмжээ нь 30,950 км^2 байсан бөгөөд энэ нь хамгаалах шаардлагатай газрын 16 хувь буюу нийт судалгаанд хамрагдсан бүс нутгийн 6 хувийг эзэлж байна. Давхцал илэрсэн газар дахь биологийн үнэ цэн өндөртэй төлөвлөлтийн нэгжийг дараах хоёр шалгуур ашиглан тогтоов. Үүнд:

1. Биологийн үнэ цэнийн утга (оновчтой байдал + ховор байдал) хамгийн өндөртэй 30% утгатай байх төлөвлөлтийн нэгж (13,850 км^2 буюу давхцал илэрсэн газар нутгийн 45%).
2. Хулангийн амьдрах орчны тархацын загвараар их бүтээмжтэй, нөлөөлөлд бага өртсөн гэж тодорхойлогдсон Дорнод Говийн хэсэг (5,700км^2 буюу давхцал илэрсэн газар нутгийн 18%) буюу хулангийн хувьд чухал амьдрах орчин гэж тогтоогдсон газрууд (Зураг 15). Энэ орчмын нутаг нь ховордсон зүйл болох хулангийн дэлхийн болон Монгол дахь цөм популяцийн идээшил амьдрах орчин болдог (Moehlman et al. 2008). Хулангийн энэ популяцийн тархац нь судалгаанд хамрагдсан бүс нутгийн зүүн умард хэсгийг дайран өнгөрөх УБ-Бээжингийн төмөр зам, өрнөд этгээдэд уул уурхайн тээврийн замын нөлөөгөөр хумигдсан бөгөөд ирээдүйд төлөвлөж буй уул уурхайн төсөл, Сайншанд-Тавантолгой хоорондын төлөвлөж буй төмөр зам болон Таян нуурын төмрийн хүдрийн ордоос Бургастайн боомт хүрэх Их говийн ДЦГ-ын “А” болон “Б” хэсгийн хооронд баригдах автозамын нөлөөнд өртөх магадлалтай байна.



Бид дээрх хоёр шалгуур үзүүлэлтийн аль нэгийг хангаж байгаа төлөвлөлтийн нэгжийг биологийн үнэ цэн ихтэй гэж үнэлэн, тухайн нэгж газарт аливаа хөгжлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээс зайлсхийх нь зүйтэй гэж үзсэн болно. Хөгжлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээс зайлсхийх газар нутгийн хэмжээ нь 19,850 км^2 буюу давхцал илэрсэн нийт талбайн 64 хувийг эзэлж байна (Зураг 18). Давхцал илэрсэн бусад газар нутаг болох 11,100 км^2 талбай (давхцал илэрсэн нийт газар нутгийн 36 хувийг эзлэхээр байгаа)-г хамгаалах шаардлагатай газрын жагсаалтаас гаргаж, экологийн нөхцөл ижил төстэй, одоогийн тусгай зөвшөөрөлтэй давхцаагүй газруудаас сонголт хийж орлуулсан (Зураг 19-г үзнэ үү). Үүний үр дүнд, бид биологийн үнэ цэнэ өндөртэй гэж тодорхойлсон газруудаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газартай давхцаагүй хамгаалах шаардлагатай газар нутгийг дахин шинэчлэн тогтоолоо (Зураг 19). Шинэчлэн тогтоосон хамгаалах шаардлагатай газар нутаг нь нийтдээ 195,000 км^2 дэвсгэр нутаг буюу судалгаанд хамрагдсан бүс нутгийн 37 хувийг эзлэх, 50 нэгж газраас бүрдэж байгаа бөгөөд одоогийн тусгай хамгаалалттай газар нутаг нь 110,000 км^2 дэвсгэр нутаг буюу хамгаалалтанд авах шаардлагатай газар нутгийн 57 хувийг эзэлж байгаа ажээ. Одоогийн тусгай хамгаалалттай газар нутаг зарим экосистемийн 30 хувиас илүү талбайг хамарч байгаа учраас хамгаалах шаардлагатай газар нутгийн нийт хэмжээ нь судалгаанд хамрагдсан бүс нутгийн 30%-аас илүү талбайг хамарч байна.

Зураг 15: Хулангийн амьдрах орчны тархацын загвар.



Хулан (*Equus hemionus*) –гийн амьдрах орчны загвар


1. Тархац : одоогийн (Kaczensky, et al. 2011) болон боломжит тархацын хилийг газрын зурагт үзүүлэв.

2. Амьдрах орчны ангилал: Kaczensky, et al. (2011), Хулангийн амьдрах орчин тэдгээрийн боломжит холбоосыг үнэлж нутаг дэвсгэр болон биомассын хэмжээгээр таатай амьдрах орчинг зураглажээ. (үулсыг хамруулаагүй).

- их: хээржүү цөл болон цөлжүү хээр [1]
- бага: жинхэнэ цөл [1]
- хэт гандуу цөлийг хамруулаагүй [1]
- нам уулс, тэгш талыг хамруулаагүй [2]


3. Амьдрах орчин нөхцлийн ангилал[3]

- Тохиромжгүй: судалгаанд хамрагдсан газар нутгийн 5% нөлөөлөлд өртсөн газар,
- Дунд зэрэг 45% үлдсэн
- Хамгийн сайн: судалгаанд хамрагдсан газар нутгийн 50% хамгийн бага сүйтгэгдсэн, цагаан: хулангийн амьдрах орчин бүс саарал: үнэлээгүй (судалгааны талбайн гадна газар).




[1] Экосистемийн ангилалын зураг (Бүлэг 2.2.1, Зураг 7, 27)
[2] Газрын гадаргын хэв шинжийн зураг (Бүлэг 2.2.1, Зураг 8)
[3] Нөлөөллийн индекс (Бүлэг 2.4)


Зураг 16: Хамгаалах шаардлагатай газар нутгийн эхний хувилбар болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон газрууд.



Зураг 17: Хамгаалах шаардлагатай газар нутгууд ба ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай газрууд.



Зураг 18: Хамгаалах шаардлагатай газар нутгууд ба ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй давхцаж буй зарим газрыг хассан байдал.



Зураг 19: Хамгаалах шаардлагатай газар нутгууд, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн давхцалыг багасгах зорилгоор дахин загварчилсан байдал.



2.9 ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ БУСАД ГАЗАР НУТАГ

2.9.1 Зэрлэг амьтны идэш тэжээл, шилжилт хөдөлгөөний хувьд чухал идээшил нутаг

Хулан, хар сүүлт зээр, цагаан зээр зэрэг уудам орон зайд идээшлэн амьдардаг туруутан амьтны одоогийн популяцийг тусгай хамаалалттай газар нутаг дангаараа хамарч чадахгүй. Төв Азийн говь, цөл, хээрт ургамалшлын төлөв байдал нь цаг хугацаа, орон зайн хувьд ялгаатай, өөрчлөгдөж байдаг (von Wehrden et al. 2012, von Wehrden et al. 2010, Zhang et al. 2010, Yu et al. 2004, Fernandez-Gimenez and Allen-Diaz 1999). Тухайлбал хээрийн ургамалшил нь хур тунадасны хэмжээнээс хамааран жил, сараар, газар бүрт харилцан адилгүй өөрчлөгддөг (Зураг 20). Цагаан зээр зэрэг бэлчээрийн туруутан амьтдын амьдарлын хэв маяг нь хур тунадасны хэмжээнээс хамаарч өөрчлөгддөг, идэш тэжээлээ дагаж уудам орон зайд шилжин нүүж байхаар хувьсаж иржээ (Mallon and Zhigang 2009, Mueller et al 2008, Mueller and Fagan 2008). Цагаан зээрийн идээшил амьдрах нутаг дэвсгэр нь Монгол орны хялганат хээрийн экосистемд 14,000-аас 32,000 км^2 талбайг эзэлдэг (Olson et al 2010). Хулангийн тархац нутаг дэвсгэр нь Монгол оронд 70,000 км^2 талбай хүртэл хэмжээтэй (Kaczensky et al. 2011, Lkhagvasuren et al. 2009). Хээрийн туруутан амьтад нь ургамлын бүтээмжээс хамааран идэш тэжээл хайн алс зайд шилжин нүүдэллэдэг тул амьдрах орчны хуваагдалд эмзэг байдаг бөгөөд зэрлэг амьтан, малтай бэлчээр тэжээлийн хувьд өрсөлдөх, малаас халдварлах өвчин зэрэг нөлөөнд өртөмтгий байдаг (Berger 2004). Хулан, хар сүүлт зээр, цагаан зээрийн хувьд, улсийн хилийн болон төмөр замын торон хашаа (Лхагвасүрэн 2000, Kaczensky et al. 2011, Ito et al. 2005, Olson 2012), Таван Толгойн нүүрс тээвэрлэдэг автозам зэрэг ачаалал ихтэй зам, тээврийн дэд бүтцээс (Ito et al. 2013, Lkhagvasuren et al. 2011, Kaczensky et al. 2006) үүдэх амьдрах орчны хуваагдал хамгийн ноцтой аюул занал учруулж байна.

Иймээс экосистемийн төлөөллийг 30 хувийг хамгаалахаар сонгон авсан (2.8.1 хэсэг), хамгаалах шаардлагатай газар нь өргөн уудам орон зайд бэлчээрлэн амьдардаг туруутан амьтдын хувьд хангалтгүй юм (Зураг 23). Нөлөөллийн индекс ашиглан тогтоосон, өрсөлдөөн ба давхцал бага илэрсэн газар нутаг нь бэлчээрийн амьдралын хэв маягтай зүйлийн хувьд улирлын бэлчээр ба шилжилт хөдөлгөөн хийхэд ач холбогдолтой байж болох юм (Зураг 21-т харуулав). Зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд саад тотгор учруулж болзошгүй одоогийн болон ирээдүйд баригдах тээврийн дэд бүтцийн байршлыг Зураг 23-д харуулав.

Дээр дурьдсан гурван зүйл туруутан амьтны популяцийн шилжилт хөдөлгөөнд үзүүлж буй нөлөө нь бусад зэрлэг амьтад, малчид, ер нь бэлчээрийн хувьд чухал асуудлыг хөндөж байна. Уудам орон зайд бэлчээрлэн амьдардаг туруутан нь ургамлын бүлгэмдлийн зүйлийн олон янз байдлын хэв шинжид нөлөөлж болох шимт тэжээлийн бодисыг дахин тараах




экологийн чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ (Mazancourt et al. 1998) мах идэшт амьтан болон сэг зэмээр хооллодог амьтдын идэш тэжээл болдог. Үүнээс гадна, нутгийн анчид ч эдгээр зүйл амьтныг агнаж, өрх гэрийн хүнс тэжээлдээ нэмэрлэх нь бий (Olson 2008).


2.9.2 Судлаачдын тодорхойлсон хамгаалах шаардлагатай газар нутаг

Ландшафтын түвшний байгаль хамгааллын төлөвлөлтөнд ГМС-ийн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтоох үйл явц нь суурь мэдээлийн нарийвчлал, баттай байдал, газрын зургийн чанар зэргээс ихээхэн хамааралтай байдаг. Судалгаанд хамрагдсан Монгол орны өмнийн говийн бүс нь их уудам газар нутгийг хамарч буй тул шийдвэр гаргахад ерөнхий мэдээлэл болох юм. Иймээс хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтоох ГМС-ийн дүн шинжилгээнд нэмэлт болох, чиглүүлэх, засан сайжруулахад судлаачдын санал, зөвлөмж, оролцоо туслалцаа зайлшгүй хэрэгтэй байдаг. Судлаачдаас бүрдсэн судалгааны зөвлөх баг судалгааны эхний шат болох судалгааны бүс тогтоох, ховор зүйлийн жагсаалт гаргах зэргээс эхлэн хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтоох эцсийн шат хүртэл ажилласан. Судалгааны зөвлөх баг 2013 оны 1-ээс 3-р сард хэд хэдэн удаа уулзалт хийж ГМС-ийн тусламжтайгаар боловсруулсан хамгаалах шаардлагатай газар нутгийг сонгосон байдлыг дүгнээд, 17 газар нутгийг нэмж оруулахыг санал болгосон (Зураг 21, Хавсралт 5). Үүнд, ДБХС-ийн орхигдлын үнэлгээний үр дүнгээр улсын тусгай хамгаалалтад авахаар санал болгосон 5 газар нутаг хамрагдсан байгаа болно (Chimed-Ochir et al. 2010). Эдгээр газар нутаг нь 53,000 км^2 талбай буюу судалгаанд хамрагдсан газар нутгийн 10 хувийг хамарч байна.


Зураг 20: Бэлчээрийн ургамлын бүтээмжийн өөрчлөлт ба идээшил нутаг. Хулан, цагаан зээр, хар сүүлт зээр болон хавтгай зэрэг ургамал идэшт амьтад нь орон зай, цаг хугацааны хувьд өөрчлөгдөж байдаг идэш тэжээл, бэлчээрээ даган уудам нутагт бэлчээрлэдэг. Ургамлын бүтээмж нь хуртай болон гандуу жилүүдэд хэрхэн өөрчлөгдөж байгаа 11 жилийн хугацааны өөрчлөлт (ВК, 2000-2011) ба хулан ба хар сүүлт зээрийн бэлчээрлэх дэвсгэр нутгийн хэмжээ зэргийг доорх зурагт харуулав.




Зураг 21: Хамгаалах шаардлагатай газар нутаг.



Зураг 22: Хамгаалах шаардлагатай газар нутаг болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл



Зураг 23: Тээврийн зурвас дэд бүтцээс зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд учруулах саад тотгор.



Хамгаалах шаардлагатай газар нутаг

Хамгаалах шаардлагатай газар

Судлаачдын тодорхойлсон хамгаалах шаардлагатай газар нутаг
(Зөвлөх баг ба ДБХС-ийн боловсруулсан хувилбар – Бүлэг 2.9.2-г үзнэ үү)

Зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөн ба сорчлон идээшлэх бэлчээр нутаг

Хамгийн тохиромжтой/ Өөрчлөгдөөгүй

Нөлөөнд өртсөн

Зам тээврийн томоохон зурвас дэд бүтэц

Төмөр зам

Уурхайн тээврийн эрчим ихтэй зам

Сайншанд - Таван толгой хооронд барихаар төлөвлөж буй төмөр зам

Баянговь-Шивээ хүрэн хооронд барихаар төлөвлөж буй автозам

Таяннуур-Бургастайн боомт хооронд барихаар төлөвлөж буй автозам

Бусад төлөвлөж буй төмөр зам

Бусад төлөвлөж буй хурдны зам

Зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд саад тотгор болохуйц одоогийн оршиж буй ба ирээдүйд баригдах зурвас дэд бүтцийн байршил:

A. Улаанбаатар – Бээжин хоорондын төмөр зам. Төмөр замын хоёр талаар баригдсан өргөст торон хашаа нь хулангийн хувьд саад, харин цагаан зээрийн хувьд “үхлийн урхи” болдог (Olson 2012).

B. Сайншанд – Таван толгой хооронд барихаар төлөвлөж байгаа төмөр зам. Энэ зам хулангийн хамгийн том цөм популяцийн хуваагдалгүй үлдсэн хамгийн чухал нэлэнхүй амьдрах орчныг таслан хуваахад хүргэх юм (Kaczensky et al. 2011).


C. Говийн Бага ДЦГ-ын “А”, “Б” хэсгийн хооронд орших Таван толгой ба Оюу толгойн тээврийн замын зурвас

D. Нарийн сухайт уурхайгаас Шивээ хүрэнгийн хилийн боомт хүртэлх автозамын зурвас.

E. Баянхонгорт байршилтай уурхайнуудыг Шивээ Хүрэн боомттой холбохоор төлөвлөж байгаа сайжруулсан замын зурвас.

F. Таян нуурын төмрийн хүдрийг Бургастайн боомт хүртэл тээвэрлэхээр төлөвлөж буй автозамын зурвас.

Зураг 24: Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-ийн гүйцэтгэлийн стандартыг хэрэгжүүлэх зорилгод нийцүүлсэн амьдрах орчны ангилал. Монгол орны өмнийн говийн экологийн бүс нутгийн үнэлгээний ажлын үр дүнг ОУСК-ын гүйцэтгэлийн стандарт (IFC 2012)-ыг мөрдөх үйл ажиллагаанд ашиглах зөвлөмжийг тайлбарласан болно (3.1.3-ийг үзнэ үү). Гүйцэтгэлийн стандартыг хэрэгжүүлэх зорилгод нийцүүлэн амьдрах орчныг өөрчлөгдсөн, байгалийн, онцгой чухал гэж хувааж үзсэн юм.



2.10 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ХУВИЛБАРУУД

Ландшафтын түвшний байгаль хамгаалах төлөвлөгөө, ялангуяа хамгаалах шаардлагатай газар нутаг ба амьдрах орчны газрын зургийг биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах газрыг тогтооход хэрхэн ашиглах жишээг харуулахын тулд дүйцүүлэн хамгаалах газрыг хэрхэн сонгох энгийн хоёр хувилбарыг боловсруулав. Үүнд: 1) том хэмжээний нэг уурхай, 2) нэг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг бүх уурхайн нэгдсэн дүйцүүлэн хамгаалах газрууд.

Дүйцүүлэн хамгааллыг байгаль хамгаалах нэг чухал хэрэгсэл болгож ашиглах боломжтой байдаг ч, хэрэгжилтийн шатанд онолын ба аргачлалын нэлээд бэрхшээлийг шийдвэрлэх шаардлага тулгардаг (Kiesecker et al. 2009). Үүний нэг нь дүйцүүлэн хамгаалах газрын байршлыг нөлөөнд өртсөн газартай харгалзан тогтоох асуудал юм. Нөлөөлөлд өртсөн газрыг дүйцүүлэн хамгаалах шаардлага ойлгомжтой боловч, дүйцүүлэн хамгаалах газрыг нөлөөлөлд өртсөн газартай аль болох ойр оршин байхаар сонгох (ингэснээр нөлөөлөлд өртсөн тухайн газар нутагт ашигтай байх), эсвэл хамгааллын үр ашиг хамгийн их байх боломжтой газрыг сонгох (дүйцүүлэн хамгаалах газар хаана байх нь чухал бус) гэсэн хоёр ялгаатай хувилбарын хооронд зөрчил үүсдэг. Хамгаалах шаардлагатай газар нутаг ба ГМС-ийн мэдээлэл нь байгаль хамгааллын хувьд хамгийн үр ашигтай байж чадахуйц дүйцүүлэн хамгаалах газрыг сонгох үндэслэл болно.


Хамгаалах шаардлагатай газар нутаг нь нэг эсвэл хэд хэдэн хөгжлийн төслийн сөрөг нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах газрыг тогтооход дэмжлэг болж чадна (Kiesecker et al. 2010, Kiesecker et al. 2011, Thorne et al. 2009). Нэг газарт үүсэх хөгжлийн хэд хэдэн төсөл хөтөлбөрийн хуримтлагдах сөрөг нөлөөллийг хам байдлаар дүйцүүлэн хамгаалах нь ашигтай байдаг талтай. Ийм нөхцөлд хам байдлаар дүйцүүлэн хамгаалах нь дүйцүүлэн хамгааллын менежментэд шаардлагатай мэргэжлийн ур чадварыг нэг газарт төвлөрүүлэх боломж олгох тул дүйцүүлэн хамгааллын амжилтад хүрэх магадлалыг ихэсгэхээс гадна учирч байгаа нөлөөллийг бага зардлаар үр дүнтэй бууруулах боломж олгоно. Дүйцүүлэн хамгааллын хам хэлбэр нь байгаль орчны үнэлгээний улмаас цаг алдах, удаашрах асуудлыг шийдэхэд дөхөмтэй. Нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах

асуудалд ландшафтын үүднээс хандах нь экологийн хувьд илүү үр дүнд хүрэх боломж олгоно. Хэрэв, олон төслийн нөлөөллийг бууруулах бол тэдгээрийг нэгтгэн цөөн боловч, уудам газар нутагт дүйцүүлэн хамгаалвал экологийн нэгдмэл байдлыг хангах болон өртөг зардлыг хэмнэх талаасаа ач холбогдолтой. Төсөл хэрэгжүүлэгчид нөлөөг бууруулахад дүйцүүлэн хамгааллыг ашиглаж байгаа бол дүйцүүлэн хамгаалал нь экологийн хувьд ижил байх, ландшафтын түвшний байгаль хамгааллын зорилтод хувь нэмэр оруулж чадах, биологийн олон янз байдлын хувьд аливаа алдагдалгүй байх эсвэл эерэг үр дүнтэй байх зэрэг шалгуурыг хангаж чадах дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг төлөвлөх ёстой. Бид нэг төсөл болон Дорноговь аймгийн нийт тусгай зөвшөөрлийн үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах судалгааг хийх арга замыг энд жишээгээр үзүүлэв. Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтоох судалгаа нь доорх хоёр үе шатнаас бүрдэнэ. Үүнд:


1. **Хөгжлийн төслийн нөлөөллийг тодорхойлох чиглэл:** Хөгжлийн нөлөөнд өртсөн газар нутгийн хэмжээ буюу ул мөрийг тогтооно. Энэ нь зэрлэг амьтны амьдрах орчинд үзүүлэх хөгжлийн төслийн нөлөөллийг судалгаан дээр үндэслэн их эсвэл бага байх хувилбараар тооцож үзнэ. Бидний авсан хялбар жишээнд хөгжлийн төслийн нөлөөлөл буюу ул мөрийг тооцоолохын тулд бид уул уурхай болон холбогдох дэд бүтэцтэй (зам, дамжуулах шугам) давхцаж буй төлөвлөлтийн нэгжийг сонголоо.
2. **Дүйцүүлэн хамгаалах боломжит газар нутгийг тодорхойлох чиглэл:** Бид экосистемийн ангилал дээр тулгуурласан статистик импутаци аргыг ашиглан хөгжлийн төслийн нөлөөлөлд өртсөн газар нутгийн хэмжээ буюу ул мөртэй ижил төстэй амьдрах орчинтой хамгаалах шаардлагатай багц газрыг сонгов. Импутацийг ашиглан төслийн нөлөөнд өртсөн газрын төлөвлөлтийн нэгжийн экосистемийн бүтэцтэй ижил төстэй төлөвлөлтийн нэгжийг хамгаалах шаардлагатай газар нутгаас олж тогтоосон. Импутаци гэдэг нь олон хувьсагч ашиглан хэд хэдэн ажиглалтын мэдээлэл хоорондын ижил төстэй байдлыг хэмждэг статистик аргачлал юм (Hudak et al. 2008). Энэ тохиолдолд хувьсагч нь экосистемийн хэв шинж ба ажиглалтын мэдээлэл нь төлөвлөлтийн нэгж болно. Бид импутацийн анализийн үр дүнд Нарийн сухайтын уурхайн нөлөөг дүйцүүлэн хамгаалж болох хэд хэдэн газрыг олж тогтоов (Зураг 25). Дорноговь аймгийн нутаг дэвсгэр дэх ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газруудад үүсч болзошгүй нөлөөллийг дүйцүүлэн хамгаалж болох боломжтой 10-12 газрыг олж тогтоов (Зураг 26).

Дээр дурьдсан жишээнд дүйцүүлэн хамгаалах газрыг сонгох дараах гурван шалгуурыг ашигласан болно. Үүнд: 1) дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг ландшафтын түвшний төлөвлөгөөтэй уялдуулах буюу бүс нутгийн хэмжээний байгаль хамгаалах зорилтод нийцүүлэх, 2) дүйцүүлэн хамгаалах газар нь экологийн нөхцөлийн хувьд нөлөөлөлд өртсөн амьдрах орчинтой ижил төстэй байх, 3) дүйцүүлэн хамгаалах газар нь нөлөөлөлд өртсөн газартай ойр оршдог байх. Энэ жишээнд дүйцүүлэн хамгааллын тооцоолол, ба зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд үзүүлэх нөлөөллийг тооцоолоогүй болно. Дүйцүүлэн хамгааллын тооцоолол нь төслийн нөлөөллийг тогтоох, дүйцүүлэн хамгаалах боломжит газар нутгийг тогтоохоос гадна дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төрөл, хэрэгжүүлэх хугацаа, биологийн олон янз байдлын хувьд алдагдалгүй байх зорилтод хүрэхүйц зардлыг тооцоолох асуудлуудыг багтаадаг. Дүйцүүлэн хамгааллын эдгээр чухал бүрэлдэхүүн хэсгүүдийг энд дурьдсан дүйцүүлэн хамгааллын жишээнд оруулаагүй болно.

Зураг 25: Бүс нутгийн хүрээнд уул уурхайн нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах боломжит хувилбар: нэг уурхайн жишээн дээр. Доорх газрын зурагт нэг уурхайн эдэлбэр газрын нөлөөллийн орон зайн ул мөр болон хамгаалах шаардлагатай газрын хүрээнд илэрсэн экологийн нөхцлөөр ижил төсөөтэй багц газрыг тус тус үзүүлж байна. Энэ бүдүүвч зургаар экологийн нөхцлөөр ижил төсөөтэй, ландшафтын түвшний хамгааллын ач холбогдол (2.10 хэсгийг үзнэ үү)-ыг тэтгэж байх зэрэг дүйцүүлэн хамгааллын шалгуурыг хангасан газрыг үзүүлсний зэрэгцээ, ландшафтын түвшний хамгааллын төлөвлөгөө болон судалгааны мэдээллийг ашиглаж болохыг жишээгээр харуулав.



Зураг 26: Бүс нутгийн хүрээнд уул уурхайн нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах боломжит хувилбар: нэг аймгийн хүрээнд. Доорх газрын зурагт Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт олгогдсон ашигт малтмалын ашиглалт болон бусад тусгай зөвшөөрлийн байршил ба хамгаалах шаардлагатай газрын хүрээнд илэрсэн экологийн нөхцлөөр ижил төсөөтэй багц газрыг тус тус үзүүлжээ.



УТХГазар


Хамгаалах шаардлагатай газар нутаг

Дүйцүүлэн хамгааллын дүн шинжилгээ


Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт олгогдсон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл болон өргөдөл бүхий талбайн орон зайн үл мөр буюу нөлөөлөл

Хамгаалах шаардлагатай газар нутгийн хүрээнд илэрсэн экологийн нөхцөл ижил төсөөтэй газар

Зураг 27а: Газрын доорх уснаас хамааралтай экосистемийн хэв шинж: Судалгаанд хамрагдсан бүс нутгийн баруун хэсэг.



Зураг 27б: Газрын доорх уснаас хамааралтай экосистемийн хэв шинж: Судалгаанд хамрагдсан бүс нутгийн дорнод хэсэг.





3.0 ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

3.1 СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ БА НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРХЭН АШИГЛАХ НЬ

Энэ судалгаа нь уул уурхайн хөгжил, бэлчээрийн мал аж ахуй, байгаль хамгаалах шаардлагуудыг тэнцвэртэй хослуулсан газар зохион байгуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөх боломж олгож байгаа тул Монгол орны өмнийн говийн бүсийн тогтвортой хөгжилд зохих хувь нэмрээ оруулна гэж бид үзэж байна. Мөн тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөтгөх, уул уурхайн хөгжлийн нөлөөг зохистой бууруулах бодлого төлөвлөлт болон практик ач холбогдолтой.

3.1.1 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний өргөтгөл ба менежмент

Манай судалгааны үр дүнг Монгол улсын Засгийн газрын нийт нутаг дэвсгэрийн 30 хүртэлх хувийг хамгаалалтад авах зорилтыг биелүүлэх болон тусгай хамгаалалттай газрын менежментийг сайжруулах, ач холбогдлын эрэмбэ тогтоох зэрэг үйл ажиллагаанд ашиглаж болно. Улсын Их Хурлын 13 дугаар тогтоолд дээр дурьдсан 30 хувийг хамгаалах зорилтыг биелүүлэхэд нийт нутаг дэвсгэрийн 15 орчим хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар заасан ажээ. Түүнчлэн энэ судалгааны үр дүнг орон нутгийн тусгай хамгаалалттай газрын зохистой сүлжээг бүрдүүлэхэд ашиглах боломжтой юм. Газрын тухай хуулинд аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг 12-16 жил тутамд хийж байхаар заасан байдаг (Газрын тухай хууль, 123 дугаар зүйл, 2002).

Их Нартын БНГ (Анх орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сум), Тост уулын орон нутгийн хамгаалалттай газар (Өмнөговь аймгийн Гурвантэс сум) нутаг нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг шинээр байгуулах, түүний менежментийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий зөв жишиг загвар болж байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс “Монгол улсын Тусгай хамгаалалттай нутгийн сүлжээг бэхжүүлэх нь” (UNDP SPAN- Strengthening of the Protected Area Network in Mongolia) төслийн хүрээнд Их Нартын БНГ-ыг үндэсний загвар гурван газар нутгийн нэгээр сонгон авч төсөл хэрэгжүүлж байна. Энэ төслийг БОНХЯ-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар хэрэгжүүлж байгаа бөгөөд менежментийн үр дүнтэй байдал, санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх зорилготой юм (http://www.undp.mn/snrm-span.html).



3.1.2 Уул уурхай, эрчим хүчний хөгжлийн нөлөөллийг бууруулах чиглэл

Судалгааны үр дүнг Монгол орны говь, цөлийн бүс нутагт уул уурхайн хөгжлийн нөлөөллийг бууруулахад ашиглах боломжтой. Нэгдүгээрт, уул уурхайн хөгжил эрчимтэй явагдаж буй өнөө үед хамгаалах шаардлагатай газрыг тогтоох нь төлөвлөж буй уул уурхайн хөгжил болон байгаль хамгааллын хооронд үүсч болзошгүй зөрчлийг "урьдчилан мэдээлэх" боломж бүрдүүлнэ. Хоёрдугаарт, хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх арга ба энэ судалгааны үр дүн нь хөгжлийн нөлөөг бууруулах (нөлөөллөөс зайлсхийх эсвэл дүйцүүлэн хамгаалах гэх мэт) талаар шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлнэ. Хамгаалах шаардлагатай газар болон ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл давхцаж буй газар нутагт хөгжлийн нөлөөлөлд өртөж болзошгүй биологийн олон янз байдлын амьдрах орчныг өөр газар шилжүүлэн хамгаалах зорилгоор хамгаалалтад авах газрыг "дахин шинэчлэн тогтоох" шаардлага урган гарч болох юм (Зураг 18, 19-ийг үзнэ үү). Хэрэв нөлөөлөлд өртөж болзошгүй биологийн олон янз байдлыг өөр газарт дүйцүүлэн хамгаалах боломжгүй бол хөгжлийн төслийг хэрэгжүүлэхээс татгалзах эсвэл биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай. Энэ нь биологийн чухал ач холбогдолтой олон янз байдал буюу хамгаалах шаардлагатай газрууд ба төлөвлөж буй хөгжлийн төслийн хооронд үүсч болзошгүй зөрчлөөс сэргийлэх, төслийн нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны дарааллын зохих үе шатыг хэрэгжүүлэх талаар холбогдох шийдвэр гаргахад удирдамж болно.

Бүх төрлийн хөгжлийн төсөл нь биологийн олон янз байдал бүрд нөлөө үзүүлэх эсэх нь тодорхой бус бөгөөд давхцал үүсч л байвал нөлөөтэй гэж дүгнэж болохгүй. Иймээс, аливаа хөгжлийн төслийн нөлөөллийг үнэлэхийн тулд биологийн олон янз байдлын бүрдэл хэсэг тус бүрээр ялган авч үзвэл зохистой. Үүний тулд, хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын тархац болон хөгжлийн нөлөөллийн талаар илүү нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай. Бидний хийсэн ландшафтын түвшний төлөвлөлт буюу экологийн бүс нутгийн үнэлгээ нь хаана зөрчил үүсч болзошгүйг илрүүлэх, мөн хаана ямар нэмэлт судалгаа шаардлагатай болохыг тогтоох эхний алхам болно.

3.1.3 Зээлдүүлэгчийн гүйцэтгэлийн стандарт: Чухал амьдрах орчин

Монгол орны өмнийн говийн бүс нутагт хэрэгжүүлж байгаа хөгжлийн зарим төсөл хөтөлбөр нь Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ), Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) зэрэг санхүүгийн байгууллагаас санхүүжилт авч байгаа юм. Зээлдүүлэгч байгууллага шинээр батлагдсан гүйцэтгэлийн стандарт, шаардлага, зөвлөмжийг дагаж мөрддөг (IFC 2012). Гүйцэтгэлийн стандартын зорилго нь хөгжлийн төслийг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дэмждэг, биологийн олон янз байдлыг хамгаалах, байгалийн амьд нөөц баялгийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг болгоход чиглэгдэнэ. Говийн экологийн бүс нутгийн үнэлгээний ажлын үр дүнг гүйцэтгэлийн шинэ стандартыг (IFC 2012) хэрэгжүүлэхэд хэрхэн ашиглах тухай Зураг 24-т тайлбарласан. Гүйцэтгэлийн стандарт 6-г хэрэгжүүлэх зорилгоор амьдрах орчныг өөрчлөгдсөн, байгалийн хэвийн, чухал гэж хуваах үзлээ.

Чухал амьдрах орчинд дэлхийн эсвэл үндэсний хэмжээнд устаж байгаа ба устаж болзошгүй, хязгаарлагдмал тархацтай эсвэл унаган зүйл, нүүдлийн ба олноор цугладаг зүйлийн бөөгнөрөл бүхий, аюулд хэт нэрвэгдсэн ба өвөрмөц жижиг экосистем, эволюцийн чухал үйл явцыг агуулсан газар нутаг багтана. Эдгээр

газруудыг өмнийн говийн бүсийн хамгаалах шаардлагатай газар нутагт оруулсан тул чухал амьдрах орчныг тогтооход ашиглаж болно. Өөрөөр хэлбэл, хамгаалах шаардлагатай газар нутгуудыг чухал амьдрах орчин гэж үзэж болно. Өмнө бид хамгаалах шаардлагатай газар нутгийн эхний хувилбарыг боловсруулах шатанд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй давхцаж буй хэсгийг боломжтой бол өөр ижил хэв шинж бүхий газарт олж тогтоож болох тухай дурьдсан. Давхцлын улмаас хамгаалах шаардлагатай газар нутгийн жагсаалтаас хасагдсан эдгээр газруудыг мөн чухал амьдрах орчин гэж үзэх нь зүйтэй. Эдгээр газарт хөгжлийн үйл ажиллагаа хэрэгжих тохиолдолд биологийн олон янз байдлын хувьд эрэг үр дүнд хүрэхийн тулд үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах ёстой.

Хамгаалах шаардлагатай газар нутгийн гадна байх байгалийн ургамалшил бүхий газар нутгийг байгалийн хэвийн амьдрах орчин гэж үзнэ. Хөгжлийн төсөл энэ газарт хэрэгжиж болох боловч биологийн олон янз байдлын хувьд алдагдалгүй байх зорилгоор үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах ёстой.

Бид өөрчлөгдсөн амьдрах орчин гэдэгт нөлөөллийн индексийн утга хамгийн их буюу нөлөөлөлд хамгийн их өртсөн 5%-н утга бүхий газруудыг сонгосон. Нөлөөллийн индекс гэдэг нь одоогийн хүний үйл ажиллагааны хуримтлагдах нөлөөлөл, эсвэл түүхэн болон байгалийн нөхцөл байдлаас хэр зэрэг өөрчлөгдсөнийг харуулах хэмжээс юм (2.4-ийг үзнэ үү). “Нөлөөлөлд хамгийн их өртсөн” газар нутаг гэдэгт суурин газар (аймаг, сумын төвүүд, хилийн боомт), ашиглалт явуулж буй уул уурхай болон гол дэд бүтцийн коридор (автозам, уул уурхайн зам болон төмөр зам), эсвэл малчин өрхийн нягтшил ихтэй (3 км^2-д нэгээс доошгүй малчин өрх байх), эсвэл эдгээрийн давхцал бүхий газруудыг оруулсан. Өөрчлөгдсөн амьдрах орчинд хөгжлийн төслийг хэрэгжүүлэхдээ менемжентийн шилдэг практикийг ашиглах ба дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэхгүй байж болох юм. Гэсэн хэдий ч, өөрчлөгдсөн амьдрах орчинд хөгжлийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөнд саад учруулах зам тээврийн дэд бүтэц, замын хөдөлгөөний их ачаалал үүсгэх гол сөрөг нөлөөллийг үзүүлж болзошгүй. Иймээс эдгээр шууд бус нөлөөллийг бууруулах шаардлага тулгарна.

3.1.4 Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтоох нь

Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх ба нөлөөллийг бууруулах үе шатны дараагийн алхам нь төслийн нөлөөллийн цар хүрээг тодорхойлж, дүйцүүлэн хамгаалах хамгийн боломжтой, зохистой хувилбарыг тогтоох шаардлагатай. Хөгжлийн төслийг хэрэгжүүлэхэд аль болох олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн менежментийн шилдэг практикийг хэрэгжүүлэх замаар төслийн нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой. Байгаль хамгаалал ба хөгжлийн хэрэгцээний тэнцвэрийг хангахын тулд хөгжлийн нөлөөллөөс зайлсхийх, бууруулах/нөхөн сэргээх үе шатыг зохих ёсоор хэрэгжүүлсний дараа, үлдэх нөлөөг тооцож, түүнийг дүйцүүлэн хамгаалах нь зүйтэй (Зураг 21). Хөгжлийн төсөл хэрэгжүүлж буй газар биологийн олон янз байдлын хувьд алдагдалгүй байх зорилт дэвшүүлэх нь хамгаалах шаардлагатай газрын гадна бий болж буй нөлөөллийг хамгаалах шаардлагатай газарт хэрэгжих байгаль хамгаалах үйл ажиллагаа болгон хувиргах (дүйцүүлэн хамгаалах) замаар байгаль хамгааллын зорилтод хүрэх боломж олгоно.

Дүйцүүлэн хамгаалал нь нөлөөлөлд өртсөн газартай экологийн хувьд ижил төсөөтэй, үр дүнд хүрэх, аль болох нөлөөнд өртсөн газрын ойролцоо хил залгаа байх, ландшафтын хэмжээнд байгаль хамгаалах зорилтыг





биелүүлэх зарчмыг удирдлага болгодог. Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтооход төслийн нөлөөлөлд өртсөн газартай экологийн нөхцөл ижил төстэй, дүйцэхүйц байх, ойр дөт залгаа орших зэрэг шалгуурыг хэрэгжүүлэхэд хамгаалах шаардлагатай газар нутгийг ашиглаж болно. Хамгаалалтад авах шаардлагатай газрыг ландшафтын хэмжээний байгаль хамгаалах зорилтод хүрэхийн тулд нэгэнт тогтоогдсон дүйцүүлэн хамгаалах газрыг хамгаалах шаардлагатай газраас сонгох нь ландшафтын түвшний байгаль хамгаалах зорилгод нийцнэ. Дүйцүүлэн хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй байгаль хамгаалах үйл ажиллагааг үнэлэхийн тулд хамгааллын ач холбогдол, эрсдэл, өртгийг тооцож үнэлэх нь чухал (McKenney & Kiesecker 2010, Kiesecker et al. хэвлэлд).

3.1.5 Газар ашиглалтын төлөвлөлт

Хамгаалах шаардлагатай газар нутаг, түүнтэй холбоотой мэдээллийг улс, аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөлт, бүсчлэлийг хийхэд ашиглах боломжтой. Амьдрах орчин, малчин айл өрхийн нягтшил, газар ашиглалтын бусад зургуудыг бэлчээрийн нөөц газрыг тогтоох, зохистой ашиглах, зэрлэг амьтан ба мал хоорондын бэлчээрийн өрсөлдөөнийг бууруулах, бэлчээрийг зохистой ашиглах, зохицуулах зэрэг бэлчээрийн менежментэд ашиглаж болно. Хээрийн бүс дэх хамгаалах шаардлагатай газар нутгийг ган, зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдэл, эсвэл онцгой тохиолдлоос бусад үед малын бэлчээр, хадлан тэжээл бэлтгэх үйл ажиллагаанаас чөлөөлж, бэлчээрийн нөөц газар (отрын бэлчээр) маягаар ашиглах боломжтой. Өмнөговь аймагт хийсэн Leisher et al. (2010) нарын судалгаагаар, малчдын оролцоотой менежмент бүхий бэлчээрийн нөөц газар нь хэрэв зохистой ашиглаж чадах аваас цаг хүндэрсэн үеийн бэлчээр эсвэл отрын нөөц бэлчээр болох зэрэг ашиг тустай нь тогтоогджээ. Бэлчээрийн хэв шинж, ургац, бүтээмж газар ашиглалт дээр тулгуурлан бэлчээрийн нөөц газрыг тогтооход хамгаалах шаардлагатай газар нутгийг ашиглах боломжтой юм (Girvetz et al. 2012). Бүс нутгийн ГМС-ийн мэдээллийг уул уурхай, түүнийг дагалдах дэд бүтцийн хөгжлийн үйл ажиллагаанаас бэлчээрт үзүүлэх нөлөөг тогтоох, мөн уул уурхайн хөгжил зэрэг газар ашиглалтын өөрчлөлттэй уялдан нутгийн иргэд, мал сүргийг нүүлгэх, төлөвлөхөд ашиглаж болно.

3.1.6 Судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх үндэслэл

Монгол орны говь, цөл нутгийн уугуул ургамал, амьтны түүхэн тархац хадгалагдан үлдсэн боловч зарим зүйл нь ховордоод байгаа билээ. Цаашид ашигт малтмалын олборлолт, түүнийг дагасан дэд бүтцийн хөгжлийн нөлөөгөөр улам бүр ховордож болзошгүй. Говийн судалгаанд хамрагдсан бүс нутгийн дийлэнх нь бага судлагдсан бөгөөд устаж болзошгүй, ховордсон амьтан, ургамлын зүйлийн өнөөгийн төлөв байдал, экологийн талаар мэдээлэл хомс байна. Байгаль хамгааллын үйл ажиллагаа, нөлөөллийг бууруулах, мониторинг хийхэд шаардагдах үндсэн судалгаа, шинжилгээний ажлыг яаралтай эхлүүлэх хэрэгтэй байна (Batsaikhan et al. 2010, Clark et. al 2006).

Зарим алслагдмал нутагт хийсэн судалгаагаар өмнө нь ажиглагдаж байгаагүй шинэ зүйл олонтой тэмдэглэгдэж байна. Ургамалшил, экосистемийн зураг ба зүйлийн тархацын загварыг зүйлийн эсвэл ургамалшлын судалгааны ажлыг төлөвлөх, чиглүүлэхэд ашиглаж болно. Ирээдүйд ийм чиглэлийн судалгаа хийснээр ургамалшил, экосистемийн зураг ба зүйлийн тархацын загварыг сайжруулах боломж бүрдэнэ.

3.2 ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БУСАД АСУУДАЛ

3.2.1 Хамгаалах шаардлагатай болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн давхцал илэрсэн газар

Бид хамгаалах шаардлагатай газар болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайн давхцал илэрсэн газрын талаарх дүн шинжилгээний талаар Тайлангийн 2.8.1-д өгүүлсэн ба судалгаанд хамрагдсан бүс нутагт нийт 19,850 км^2 дэвсгэр нутагт давхцал илэрсэн газрыг тогтоосон. Эдгээр давхцал илэрсэн газрын ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах, эсвэл хилийн цэсийг нь өөрчлөх замаар хөгжлийн төсөл хөтөлбөрөөс ангид байх ёстой газар гэж бид тодорхойлон зөвлөмж гаргалаа. Үүнд ашиглалтын 5 тусгай зөвшөөрөл нэлээд олон тооны хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газар хамарч байна (Зураг 22).

3.2.2 Зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөнд учрах саад бэрхшээл

Монгол орны өмнийн говийн экосистем нь уудам нутагт тархан амьдрах олон зүйл амьтны тархац, идээшил нутгийг тэтгэж байдаг. Үүнд хулан, цагаан зээр, хар сүүлт зээр зэрэг талархаг нутгаар бэлчээрлэн нүүдэллэдэг туруутан, улархаг нутгаар идээшилдэг ховордсон туруутан янгир, аргаль, мөн ховордсон мах идэшт ирвэс зэрэг зүйлийг дурьдаж болно. Тоо толгой нь эрс цөөрсөн мазаалай, хавтгай зэрэг түүхэн тархац нутаг нь Монгол орны говь цөлийн уудам нутагт оршдог зүйл болон бусад зэрлэг амьтдын урт хугацааны туршид оршин амьдрах нөхцөлийг хангахын тулд Их Говийн ДЦГ-ын “А” хэсгийн өнөөгийн хилийг тэлэх шаардлагатай. Эдгээр зүйл нь идэш тэжээлийн хомс нөөцөд хүрэх, үржилд орох замаар генийн сангаа хадгалах зэрэг мэнд үлдэж оршин байх үндсэн шаардлагын улмаас уудам газарт шилжин нүүдэллэх хэрэгтэй болдог. Одоо байгаа болон бүтээн байгуулахаар төлөвлөж байгаа зам тээврийн дэд бүтэц бол амьтдын шилжилт хөдөлгөөн, нүүдэлд учруулах үндсэн саад бэрхшээл болж байна (Kaczensky et al. 2006, Olson 2012, Lkhagvasuren et al. 2011).

Зам тээврийн дэд бүтцийн улмаас зэрлэг амьтны шилжилт, хөдөлгөөнд учирч байгаа нэн яаралтай шийдвэрлэх ёстой аюул бэрхшээлийг дор жагсаан үзүүлэв (Зураг 23). Одоо ашиглаж буй автозам болон төмөр замын нөлөөллийг бууруулах арга хэмжээг (хонгил болон гүүрэн гарц, хөдөлгөөн хязгаарлалтыг түр хугацаагаар зохицуулах, өргөст төмөр утастай хашааг буулгах эсвэл зэрлэг амьтан осолгүй шурган нэвтэрч чадах бүтэц хийж өөрчлөх зэрэг) нэн тэргүүнд хэрэгжүүлэх нь зүйтэй.

A. Одоогийн Улаанбаатар – Бээжин чиглэлийн төмөр зам. Төмөр замын хоёр талаар баригдсан өргөст төмөр утастай тор нь хулангийн хувьд нэвтрэх боломжгүй саад тотгор (Olson 2012) болохын зэрэгцээ цагаан зээр өргөст төмөр утсанд нэвтрэх оролдлого хийх үед ороцолдох “үхлийн урхи” болдог нь ажиглагдаж байна. Энэ саад тотгорыг арилгах хамгийн хялбар шийдэл нь хулангийн тархац нутгийн хүрээнд төмөр замын торыг боломжтой





газарт (сумын төвөөс зайдуу, малчид цөөн нутагладаг зэлүүд газарт) бүр мөсөн буулгах явдал юм. Харин цагаан зээрийн тархац нутгийн хүрээнд өргөст төмөр утастай хашааны загварыг өөрчлөх (хамгийн дээд, доод эгнээний утаснуудыг өргөсгүй болгох, мөн доод эгнээг газраас өндөр татах зэрэг) замаар цагаан зээр нэвтрэх үед ороолдох эрсдлийг бууруулах боломжтой (Olson 2012).

Б. Төлөвлөж буй Сайншанд – Таван толгойн төмөр зам. Хулангийн дэлхийн дайд үлдсэн цөм популяцийн тархац, одоогийн байдлаар дорнод этгээдэд Улаанбаатар – Бээжин чиглэлийн төмөр замын хайсаар, өрнөд этгээдэд Таван толгойн автозамаар таслагдан Дорнод говьд үлдсэн байна. Төлөвлөж буй төмөр зам нь хулангийн хамгийн том хуваагдалгүй үлдсэн сүүлчийн нэлэнхүй амьдрах орчныг таслаж, хуваах уршигт хүргэх юм (Kaczensky et al. 2011). Замын барилга байгууламж болон ачаа тээвэрлэлтийн нөлөөллөөс үүдэн төмөр замын дагуух зурвас нутгийн бэлчээр доройтон сүйтгэгдэх болно.

В. Говийн Бага ДЦГ-ын “А” болон “Б” хэсгийн хооронд орших Таван толгой болон Оюу толгойн тээврийн автозам.

Г. Өмнөговь аймгийн Гурвантэсийн нутагт буй Нарийн сухайтын уурхайгаас Шивээ хүрэнгийн хилийн боомт хүрэх тээврийн автозам.

Д. Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт байрлах олон уурхайг хилийн боомттой холбох Их Говийн ДЦГ-ын “А” хэсэг болон Гурвансайханы БЦГ-ын хооронд тавихаар төлөвлөж байгаа автозамын ажил. Хавтгай болон мазаалайн өнөөгийн оршиж буй тархац нутаг тэлэх боломжтой Их Говийн ДЦГ-ын дорнод ба зүүн умард этгээдэд одоо ажиллаж байгаа нэг уурхай ба хайгуулын хэд хэдэн тусгай зөвшөөрөл мэдэгдээд байна.

Е. Таян нуурын төмрийн хүдрийн ордыг олборлоод Бургастайн боомт хүртэл зөөх зорилготой төлөвлөж буй авто зам нь Их Говийн ДЦГ-ын “А” болон “Б” хэсгийн хил хоорондуур гарах юм.

Зэрлэг амьтны нүүдэл, шилжилт хөдөлгөөнд чухал газрыг хамгаалах нэг загвар жишээ бол, АНУ-ын өрнөд нутагт Холбооны болон мужын засгийн газар, төрийн бус байгууллага, газар өмчлөгчид хамтран байгуулсан Цав эвэрт (*Antilocapra americana*) гөрөөсний нүүдлийн зурвас нутаг юм. Энэ зурвас нутаг нь газрын тос, байгалийн хий олборлолт, тэдгээртэй холбоотой дэд бүтэц зам, торон хашаа болоод хурдацтай баригдаж буй хувийн болон нийтийн эзэмшлийн газрыг хамарчээ. Дурьдсан зурвас газрын хамгаалалт ёсоор Холбооны болон муж улсын Засгийн газрын мэдлийн газарт баригдах дэд бүтцийн барилга байгууламж, төлөвлөлт нь Цав эвэрт гөрөөсний нүүдлийн замналын шаардлагыг хангах ёстой ажээ (USFS 2008).

3.2.3 Газрын доорх устай шүтэлцээтэй экосистемийг хамгаалах нь

Газрын зурагт дүрсэлсэн экосистемийн ангилалд зэрлэг амьтан, мал, хүн амын суурьшлын тухайд биологийн үнэ цэн ихтэй газрын доорх устай шүтэлцээтэй экосистемийг тусгайлан ялгасан нь газрын доорх усны сүлжээний тогтоцыг даган цөөн, алаг цоог байдлаар тархан байрших дүр зураг ажиглагдав (Зураг 27). Үүнд 1) Тоорой, сухай зэрэг баянбүрдийг шүтсэн өтгөн шигүү ургамалшил ба 2) хайлааст сайр, заган төгөл эсвэл бусад өндөр сөөгт бүлгэмдэлтэй чийглэг цайдам хотгор хамаарна. Эдгээр экосистем нь зүйлийн бүрдэл баялаг, жижиг хөхтөн, мөлхөгч болон шувуудад чухал идээшил амьдрах орчныг тэтгэхийн зэрэгцээ хавтгай, хар сүүлт зээр, мазаалай зэрэг говь, цөлийн том хөхтөн амьтдын идээшил чухал түшиц газар юм. Жороо тоодог (*Chlamydotis macqueenii*), загийн бор шувуу (*Passer ammodendri*), хулан жороо

(*Podoces hendersoni)*, могойч бүргэд (*Circaetus gallicus)*, тас (*Aegypius monachus*) зэрэг олон зүйл шувуу заган төгөл болон хайлаас шүтэж үүрлэн, идэш тэжээлээ олж амьдардаг. Ийм экосистем нь цөөн тоотой, хоорондоо алслагдмал байршилтай амьдрах орчны сүлжээг бүрдүүлж байдаг тул метапопуляци (популяцийн систем) хоорондоо холбогдох байдалд чухал үүрэгтэй. Эдгээр экосистем нь газрын доорх усны горимын өөрчлөлтөд ихээхэн эмзэг байх ба нөхөн сэргээхэд олон жил, бүр хэдэн арван жил ч шаардагдаж болно. Дорнод говьд хулан 50 хүртэл см гүн татаал ухаж газрын гадаргууд ойр байгаа усанд хүрч, өөрийгөө болон бусад зэрлэг амьтдыг ундаалдаг байна (Kaczensky et al. 2006).

Эдгээр газрын доорх устай шүтэлцээтэй экосистемийг хамгаалах нь түүнийг шүтэж амьдардаг олон зүйлийг хамгаалж үлдээхэд нэн ач холбогдолтой. Баянбүрд, хужир мараалаг хотгор нь хуулиар хамгаалагдсан (Ойн тухай хууль 2005, Усны тухай хууль 2009) хэдий ч, хамгаалах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эдгээр экосистемийн экологийн нөхцөл, хамгаалах үйл явцыг газрын зурагт нарийвчлал сайтай буулгах шаардлагатай. ТХГ-ын ургамалшлын саяхан гаргасан зураг, 1:100,000 масштабтай байр зүйн зураг, судалгааны явцад бүтээсэн өвөрмөц буюу жижиг хэмжээтэй экосистемийн зураг зэргийг хамтад нь бүс нутгийн хэмжээний газрын зураг бүтээх, мониторинг хийх, хамгаалах арга хэмжээг төлөвлөхөд загвар болгон ашиглахад нийцтэй.

3.2.4 Газрын доорх усны өөрчлөлтийн хүн, мал, зэрлэг амьтанд үзүүлэх нөлөө, түүний мониторинг

Уул уурхайн зориулалтаар газрын доорх усыг ашиглах нь газрын доорх усны нөөцөд нөлөөлөх ба энэ нь худаг, булаг шандны усны түвшин, ургамлын ургац буурах зэргээр илэрнэ. Ингэснээр усны эх булаг шавхагдах, ширгэх, мал ба зэрлэг амьтны идэш тэжээл хомсдох, мөн дээр дурьдсан олон ховордсон жижиг хөхтөн, мөлхөгч амьтны шүтэж амьдрах орчин болох олон янз байдал баялагтай, ялангуяа газрын доорх устай шүтэлцээтэй хужир мараалаг цайдам, чийглэг хотгорын экосистемд шууд нөлөөлөх нь дамжигггүй.

Газрын доорх устай шүтэлцээтэй экосистемийн усны сүлжээний ойлголт хязгаарлагдмал байдгаас шалтгаалан уул уурхайн зориулалтаар газрын доорх усны ашиглалтаас үүдэх нөлөөллийг тооцоолох нь тун ярвигтай. Бид говийн бүсийн газрын доорх усны сүлжээний ойлголтын хүндрэлтэй байдлыг харгалзан,





уул уурхайн зориулалтаар газрын доорх ус ашигласнаас үүдэх ургамалшлын өөрчлөлтийг тогтоох арга зүй боловсруулахыг зөвлөж байна (Хавсралт 6-г үзнэ үү). Мониторингийн энэ аргад Landsat хиймэл дагуулын зураг ба манай судалгаанд ашигласан хөрсний засалттай ургамалшлын нийлбэр индексийн зургийг ашиглахыг санал болгож байгаа юм.


3.2.5 Хуримтлагдах нөлөөлөл

Байгалийн нөөцийг үр дүнтэй ашиглах менежментийг хэрэгжүүлэхийн тулд ашиглалт ба хамгааллын хам үр дагаврыг цаг хугацаа, газарзүйн ялгаатай орон зайн хэмжээст ойлгох нь чухал. Тухайлбал, зэрлэг амьтны менежментийн тухайд, популяц ба зүйлд үзүүлэх нөлөөллийг бүрэн дүүрэн ойлгохын тулд зөвхөн ганц нэг төслийн хүрээнд эсвэл менежмент хэрэгжүүлж буй газар нутгийн хүрээгээр хязгаарлахгүй харин популяцийн түвшинд нөлөөг ойлгох ёстой гэж судлаачид үздэг (Ruggiero et al. 1994).

